# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2019 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

/ЗТХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээ/

2019.12.19 Улаанбаатар хот

| | ЗГҮАХ-т тусгагдсан зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | 2019 он | | Хэрэгжилт | Үнэл-гээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв, (сая төгрөг) | | |
| **Тэргүүлэх зорилт № 2.1.** Макро тэнцвэрийг бататгасан олон тулгуурт дотоодын үйлдвэрлэлд түшиглэсэн, тогтвортой эдийн засгийг бий болгон Монгол Улсын үндэсний нийт орлогыг нэмэгдүүлж, дундаж-дээгүүр орлоготой орнуудын эгнээнд буцаан оруулна. | | | | | | | | | |
| 1 | 2.11. Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана | 2. “Эдийн засгийн коридор” хөтөлбөрийн хүрээнд 3 улсын хил дамнасан олон улсын авто замын транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх | 2016-2020 | - | - | Гадаа-дын хөрөнгө оруулал-тыг татах үндсэн нөхцөл бүрдэх | - | **БТГ:**<br>Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын ЗГ хоорондын комиссын тээврийн ажлын XIII хуралдааны протоколын төсөлд “Азийн авто замын сүлжээгээр олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх тухай” ЗГ хоорондын хэлэлцээрийн хүрээнд энэхүү зорилтыг хэрэгжүүлэх саналыг 2018 оны 02 дугаар сарыг 08-ны өдрийн 02/610 тоот албан бичгээр ГХЯ-нд хүргүүлсэн. ОХУ-ын Москва хотноо 2018.02.28-ны өдөр зохион байгуулагдсан Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын ЗГ хоорондын комиссын Тээврийн ажлын хэсгийн XIII хуралдааны үеэр монголын тал “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийн хүрээнд 3 улсын хил дамнасан олон улсын авто замаар транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг худалдааны чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг дэвшүүлсэн боловч оросын тал энэхүү асуудал нь тээврийн ажлын хэсгийн хэлэлцэх зүйл бус харин өргөн хүрээ хамарсан хил хамгаалал, гааль болон бусад хяналтын байгууллагуудын оролцоо шаардлагатай тул Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын ЗГ хоорондын комиссын XXII хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгаж, хэлэлцүүлэх санал дэвшүүлснийг талууд дэмжиж тохиролцсон.<br>Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн XXII хуралдааны протоколын Тээврийн салбарын хамтын ажиллагаа хэсгийн 3.14-т “Монгол Улсын чөлөөт бүс Алтанбулаг болон ОХУ-ын Кяхта хотын хооронд авто замыг нээх саналыг монголын тал дэвшүүлэв” гэж тусгуулсан.<br>Эдийн засгийн коридор хөтөлбөрийн хүрээнд 3 улсын дамжин өнгөрөх тээврийн Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрөх асуудлаар ГХЯ-аас Оросын талд хандсан боловч Оросын талаас уг асуудлыг шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу мэдэгдсэн байна. Уг асуудлыг дахин Монгол-Оросын ЗГХК-ын 2018 оны хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | оруулахаар саналаа ГХЯ-д хүргүүлсэн. Гэвч энэхүү асуудал нь Оросын талаас хамаарч байгаа бөгөөд монголын тал бие даан шийдвэрлэх боломжгүй байна.<br>Улаанбаатар хотноо 2019 оны 02 дугаар сарын 24-өөс 25-ны өдөр зохион байгуулагдсан Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Тээврийн ажлын хэсгийн 14 дүгээр хуралдааны протоколын төсөлд Алтанбулаг худалдааны чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг дэвшүүлсэн боловч оросын тал энэхүү асуудлыг дэмжээгүй болно.<br>Монгол Улсын Засгийн газар, ЗТХЯ, ГХЯ-ны зүгээс Орос-Монгол-Хятад 3 улсын хил дамнасан олон улсын авто замын транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг дэмжүүлэхээр ОХУ-тай ихээхэн хүчин чармайлт гаргаж ажилласан боловч уг асуудал **“олон улсын тээвэрлэлт Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрөхгүйгээр**” шийдвэрлэгдсэн.<br>Иймд дээрх арга хэмжээнд туссан “.... судлан шийдвэрлүүлэх” ажлыг бүрэн гүйцэтгэсэн болно. | |
| **Тэргүүлэх зорилт №2.6.** Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлнэ. | | | | | | | | | |
| 2 | 2.107. Олон улс, хот хоорондын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээг дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, бүх аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн хэсгийг үргэлжлүүлнэ | 1. Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 189.7 км хатуу хучилттай авто замыг барих | 2016 - 2018 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 114 300,0 | Барил-гын ажлыг дуусгах | 57 150,0<br>2017 онд зарцуул-сан 50 681,02<br>2018 он 82,888.8<br>2019 он 46,482.4 | **АЗБХЗГ:** “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд АХБ-ны 3129-MOH зээлийн хөрөнгөөр хэрэгжих Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 189.7 км авто замын барилгын ажлыг 4 багц хэсгээр зохион байгуулан хэрэгжүүлж байна. Зам барилгын ажлын гэрээг багц тус бүрээр 2015 оны 08 дугаар сард байгуулсан.<br>Зам барилгын ажлыг хэрэгжилтийг багц тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:<br>Багц 1 хэсэг буюу Хашаатын даваа-Шурагийн гүүр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын барилгын дууcч 07/13/18 дугаар дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан.<br>Багц 2 хэсэг буюу Шурагийн гүүр-Ховд чиглэлийн 53.9 км хатуу хучилттай авто замын барилгын ажил дууcч 07/13/18 дугаар дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан.<br>Багц 3 хэсэг буюу Хашаатын даваа-Толбо сум чиглэлийн 60 км хатуу хучилттай зам барилгын ажлыг гэрээнд заасны дагуу 2019.09. 31-ны өдөр бүрэн дуусгасан. 2019.11.16-ны өдөр улсын комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан.<br>Багц 4 хэсэг буюу Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад 2016 онд гарсан шүүхийн шийдвэрийн улмаас АХБ-ны хөрөнгө оруулалтыг ашиглах боломжгүй болоод байсан ба тус багц хэсгийг санхүүжүүлэх хүсэлтийг дахин 2019.03.28-ны өдөр АХБ-нд тавьсан. АХБ-аас тус багц хэсгийн гүйцэтгэгчийн тендерийг дахин зарлах зөвшөөрлийг 2019.07.30-ны өдөр ирүүлсэн. Тендерийн баримт бичгийн төсөлд 2019.09.11-ний өдөр АХБ-аас зөвшөөрөл авч, тендерийг 2019.09.12-ны өдөр зарласан. Тендерийг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 2019.10.25-нд нээсэн ба үнэлгээний тайланг 2019.11.29-ний өдөр АХБ-нд хүргүүлсэн. Энэ ондоо багтаж гэрээ байгуулна. | |
| 3 | | 2. Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км хатуу хучилттай авто замыг барих | 2018-2020 | Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | 220,000.0 | Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь | 110,000.0 | **АЗБХЗГ:** Концессын “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр ЗГ-ын 2017.06.14-ний өдрийн 166 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад нэмж тусгасан. Уг тогтоолын дагуу ҮХГ-аас 2017.08.16-ны өдөр “Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км цемент бетон хучилттай их даацын авто зам төсөл”-ийн концесс олгох 2 үе шаттай уралдаант шалгаруулалтыг зарласан. Урьдчилсан шалгаруулалтад оролцох саналыг 2017.10.16-ны өдрийн 11.00 цаг хүртэл хүлээн авсан бөгөөд тус төсөлд 1 оролцогч санал ирүүлсэн бөгөөд комисс уг оролцогчийн саналыг үнэлж, дараагийн үе шат болох уралдаант шалгаруулалтад оруулахаар шийдвэрлэсэн.<br>Комиссоос уралдаант шалгаруулалтын баримт бичиг боловсруулан тус оролцогчид 2018.01.16-ны өдөр баримт бичгийг олгож эхэлсэн бөгөөд төслийн саналыг 2018.04.19-ний өдөр нээсэн боловч нэг ч санал ирээгүй. Концессын хуулийн дагуу концесс эзэмшигчийг шалгаруулж гэрээ байгуулан хэрэгжилтэд хяналт тавих эрх үүргийг Үндэсний хөгжлийн газар хэрэгжүүлэн ажилладаг.<br>Авто зам барих хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар буюу концессын “Барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Үндэсний хөгжлийн газраас концессын хуулийн дагуу шууд гэрээ байгуулах ажлыг зохион байгуулахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Үндэсний хөгжлийн газраас ирүүлсэн албан бичгийн хариуд тус яамнаас 2019.04.24-ны өдрийн 02/2058 тоот албан бичгээр шууд гэрээнд тавигдах нөхцөл болох техникийн тодорхойлолтыг хүргүүлсэн.<br>Үндэсний хөгжлийн газраас концесс эзэмшигчийг сонгон шалгаруулах шууд гэрээний урилгыг 2019.08.30-ны өдөр цахим хуудсандаа байршуулсан боловч төслийн санал ирүүлээгүй байна. Иймд тус төслийг цаашид концессоор хэрэгжүүлэхэд дахин төслийн санал ирүүлэх магадлал бага байгаа тул хөрөнгө оруулалтын өөр хэлбэрээр хэрэгжүүлэх боломжийг судлах үүэхийг хүссэн 01/3163 дугаартай албан тоотыг Үндэсний хөгжлийн газраас тус яаманд ирүүлсэн. | 40% |
| 4 | | 3. Өгийнуур-Батцэнгэл-Их Тамир чиглэлийн 130.6 км хатуу хучилттай авто замыг барих | 2018-2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 57,200.0 | Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь | 28,600.0 | **АЗБХЗГ:** Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд тухайн төслийн эхний 63 км замыг 2019-2020 онд хэрэгжүүлэхээр XIII.1.1.48 дугаартайгаар тусгагдсан.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019.01.10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар Архангай аймгийн Засаг дарга зохион байгуулахаар эрх шилжсэн.<br>Тендерийг зарлаж, 2019.06.14-ний өдөр нээсэн боловч шаардлагад нийцсэн нэг ч оролцогч ирээгүй. Тендерийг дахин зарлаж 2019.08.02-нд нээсэн бөгөөд нэг ч компани оролцоогүй тул "Хурдны зам" ХХК-тай 2019.11.11-ний өдөр 57090.92 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шууд гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч болон орон нутгийн зүгээс төсөвт магадлал хийлгэхээр холбогдох газарт хүсэлт гаргаад байна. | 40% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | | 4.Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.5 км хатуу хучилттай авто замыг барих | 2016-2018 | Гадаад зээл | 86 100,0 | Барил-гын ажлыг дуусгах | 60 270,0<br><br>2017 онд зарцуул-сан 37 478,6<br><br>2018 онд зарцуул-сан 54,754.8<br><br>2019 онд зарцуул-сан 44,062.4 | **АЗБХЗГ:**<br>2017 онд: Тус авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Шанхай Констракшн Групп” компани шалгарч 2016.04.15-ны өдөр нийт 56,785,696.10 ам.долларын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан бөгөөд 2018 онд авто замын барилгын ажлыг бүрэн дуусгана.<br>2017 онд нийт ажлын явц 39.2%-тай байна. 8.48%-ийн хоцролттой.<br>2018 онд:<br>Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2018.04.01-ний өдөр эхлүүлсэн бөгөөд талбай дээр хөрс хуулалт 100%, далангийн дүүргэлт 100%, хөлдөлтөөс хамгаалах үе 100%, суурийн ажил 95.6%, гүүрийн ажил 98.6%, хиймэл байгууламжийн ажил 99.5%, хучилтын ажил 79.1% тус тус хийгдээд байна.<br>2019 онд: Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 180 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2019.02.20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн.<br>Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2019.04.01-ний өдөр эхлүүлж, суурийн болон хучилтын ажил бүрэн дууссан. Нийт ажлын явц 100%-тай. Улсын комисс 2019.08.06-ны өдөр ажиллаж, улсын ашиглалтад хүлээн авч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэн. Улсын комиссын 10/11/19 дүгээр дүгнэлтээр баталгаажуулсан. | 100% |
| 6 | | 5.Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замыг барих | 2017-2019 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 152 320,0 | Барилгын ажлыг дуусгах | 45,696.0 | **АЗБХЗГ:** Концессын “Барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр Хөрөнгө оруулалтын газраас /хуучнаар/ “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХХК-тай 2015.08.15-ны өдөр концессын гэрээ байгуулан зам барилгын ажлыг эхлүүлж нийт ажлын 5%-ийг гүйцэтгээд байсан боловч “Эрдэнэ зам” ХХК нэхэмжлэл гаргаж, МУ-ын Засгийн газрыг шүүхэд өгснөөр төслийн ажлыг шүүхээс түр зогсоогоод байсныг шийдвэрлэн “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХХК-тай байгуулсан гэрээнд 2018.02.05-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулан сэргээсэн.<br>Зам барилгын ажлыг 2019.12.01-ний өдрийн дотор дуусгаж, ашиглалтад хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019.03.14-ны өдрийн 75 дугаар тушаалаар тус төслийн хэрэгжилтийг судлан, ажлын явцыг эрчимжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулан, танилцуулах үүрэг бүхий Үндэсний хөгжлийн газартай хамтарсан ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгээс санхүүжилтээ шийдвэрлэж чадахгүйгээс ажил удааширч байгаа тул гэрээний үүргээ биелүүлээгүй "Эрчим хүчний барилга угсралтын трест" ХХК-тай концессын гэрээг цуцалж, шууд гэрээ байгуулах замаар ажлыг эрчимжүүлэх санал, зөвлөмж гарган Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Засгийн газрын 2019.04.19-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлээр концессын төсөвт өртгийг нэмэгдүүлэхгүй, гэрээнд заасан хугацаанд ашиглалтад оруулах талаар харилцан тохиролцож концесс эзэмшигчийн эрх, үүргийг "Макс роуд" ХХК-д шилжүүлэх арга хэмжээ авахыг Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайханд даалгасан. Дээрх үүрэг даалгаврын дагуу гэрээний хэлцэл хийж, | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 2019.05.09-ний өдөр “Макс роуд” ХХК-тай концессын гэрээ байгуулан барилгын ажлыг эхлүүлсэн.<br>Зам барилгын талбайд далан, ухмал, сууръ, хоолой, төмөрбетон гүүр, хучилтын ажлууд хийгдсэн бөгөөд эхний 30 км замыг 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс ашиглалтад оруулсан. Улсын комиссын 10/17/19 дүгээр дүгнэлтээр баталгаажуулсан.<br>2019 онд нийт ажлын 45%-ийг хийж гүйцэтгээд байна. | |
| 7 | | 6. Дашинчилэн-Их тамир чиглэлийн 130 км авто замын Орхон голын 220 урт метр төмөр бетон гүүрийг барих | 2018-2019 | Улсын төсөв | 9,450.0 | Барилгын ажлыг дуусгах | 6,615.0 | **АЗБХЗГ:** Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд тухайн төслийн эхний 63 км замыг 2019-2020 онд хэрэгжүүлэхээр XIII.1.1.48 дугаартайгаар тусгагдсан.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх Архангай аймагт шилжсэн. Тендерийг зарлаж, 2019.06.14-ний өдөр нээсэн боловч шаардлагад нийцсэн нэг ч оролцогч ирээгүй. Тендерийг дахин зарлаж 2019.08.02-нд нээсэн бөгөөд компани оролцоогүй тул " Хурдны зам" ХХК-тай 2019.11.11-ны өдөр 57090.92 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шууд гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч болон орон нутгийн зүгээс төсөвт магадлал хийлгэхээр холбогдох газарт хүсэлт гаргаад байна. | 40% |
| 8 | | 7. Завханы Цагаанхайрханы Ширээгийн голын 90.9 урт метр төмөр бетон гүүрийг барих | 2019 | Улсын төсөв | 3,780.0 | Гүүрийг барьж ашиглалтад оруулах | 3,780.0<br>2019 онд 972.3 | **АЗБХЗГ:** Улиастай-Алтай чиглэлийн замд орших Ширээгийн голд 90 у/м-ийн төмөрбетон гүүрийн зураг төслийг орон нутгийн зүгээс хийлгэсэн. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгагдсан тус гүүрийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “ЗЗБ” ХХК шалгарч, 2018.05.14-нд гэрээ байгуулсан. 2019 онд хийгдэх барилгын ажлын нарийвчилсан төлөвлөгөө батлуулсан. Барилгын ажил 2019.05.25-нд эхэлсэн. Нийт ажлын гүйцэтгэл 100%-тай. Улсын комисс ажиллаж 2019.11.08-нд ашиглалтад хүлээн авсан. Комиссын 10/12/19 дүгээртэй дүгнэлтээр баталгаажуулсан. | 100% |
| 9 | | 8.Хужирт-Арвайхээр чиглэлийн 56 км хатуу хучилттай авто замын зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх | 2019-2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 14,560.0 | Зураг төслийг боловсруулах | 7,280.0 | **АЗБХЗГ:** Хужирт-Арвайхээр чиглэлийн 56 км хатуу хучилттай авто замын зураг төслийг боловсруулах хөрөнгө оруулах **хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй.** | - |
| 10 | | 9. Дорнод аймгийн Хэрлэн сум-Хавиргын боомт чиглэлийн 125.5 км хатуу | 2019-2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 68,460.0 | Барилгын ажлын гүйцэтгэл 20 хувь | 22,820.0 | **АЗБХЗГ:** Зураг төсөл хийгдсэн. Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан. Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна.<br>Төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга батыг сайжруулах зорилгоор “Барих-шилжүүлэх” нөхцөлтэйгөөр хэрэгжих концессын зүйлийн жагсаалтыг Улсын Их Хурал тухайн жилийн төсвийн тухай хуулийн хавсралтаар батлахаар 2017.04.14-ний өдөр | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх | | | | | | Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолоор Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдах хүртэл дээрх нөхцөлтэй концессын гэрээ байгуулахгүй байхыг Засгийн газарт даалгасан. 2018 оны төсвийн тухай хуульд "Барих-шилжүүлэх" төслүүдийн жагсаалтад ороогүй.<br>Уг төслийн санхүүжилтийг "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны төсвийн хязгаарыг батлах тухай" тогтоолын төсөлд тусгуулахаар 2018.06.13-ны өдрийн 01/2777 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Мөн 2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад тусган 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2019 оны улсын **төсвийн тухай хуульд тусгагдаагүй**.<br>Уг төслийн барилгын ажлын санхүүжилтийг төсвийн төсөлд тусгуулахаар 2019.08.14-ний өдрийн 01/4326 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2020 оны улсын төсвийн тухай хуульд тусгагдаагүй. | |
| | | 10. Дорнод аймгийн Хэрлэн сумаас Баянхошуу боомт чиглэлийн 323 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх | 2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 22,710.0 | Барилгын ажлыг эхлүүлэх | - | 2017.04.28-ны өдрийн 03/1754 тоот албан бичгээр Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгуулах санал Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн боловч тусгагдаагүй. Инженерийн нарийвчилсан зураг төслийг 2016 онд "Эм Си Пи Си Жи Ар" ХХК боловсруулсан. Уг төслийн барилгын ажлын санхүүжилтийг төсвийн төсөлд тусгуулахаар 2019.08.14-ний өдрийн 01/4326 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2020 оны улсын төсвийн тухай хуульд тусгагдаагүй. | - |
| | | 11. Дорнод аймгийн Хэрлэн сум-Хавиргын боомт чиглэлийн авто замаас Эрээнцав боомт хүртэлх 160 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх | 2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 11,230.0 | Барилгын ажлыг эхлүүлэх | - | Уг төслийн инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулах санхүүжилтийн асуудлыг төсвийн төсөлд тусгуулахаар 2019.08.14-ний өдрийн 01/4326 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2020 оны улсын төсвийн тухай хуульд тусгагдаагүй тул хэрэгжих боломжгүй болоод байна. | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 12. Булган аймгийн Хутаг-Өндөр сумаас Бага-Илэнх боомт хүртэлх 136 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх | 2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 13,200.0 | Барилгын ажлыг эхлүүлэх | - | Хутаг-Өндөр-Тэшиг-Бага илэнх чиглэлийн 131.27 км хатуу хучилттай замын нарийвчилсан зураг төслийг 2012 онд "Ай Си Ти Сайн Консалтинг" ХХК боловсруулсан. Барилгын ажлыг эхлүүлэх хугацаа болоогүй. | - |
| 11 | | 13. Баянхонгор-Арвайхээр чиглэлийн огцом эргэлтийн 4.4 км трасс өөрчлөх | 2018 | Улсын төсөв | 3,300.0 | Барил-гын ажлыг дуусгах | 3,300.0<br><br>2018 онд зарцуул-сан 1,600.0 сая<br>2019 онд 1,677.0 | **АЗБХЗГ:** 2018 оны төсвийн тухай хуульд Баянхонгор-Арвайхээр чиглэлийн огцом эргэлтийн 4.4 км трасс өөрчлөх ажилд 3.3 тэрбум төгрөгийг зарцуулан 2018-2019 онд хэрэгжүүлэхээр тусгасан.<br>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Баянхонгор аймгийн орон нутгийн өмчийн газарт шилжүүлсэн тул орон нутаг нь тендерийг зарлан “Их Богд зам” ХХК-ийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан.<br>"Их богд зам" ХХК нь 3277.33 төсөвт өртгөөр барилгын ажлыг гүйцэтгэхээр 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээний хугацаа 2019.10.30-нд дуусна. 2019 оны барилгын ажлын нарийвчилсан төлөвлөгөө батлуулсан. Барилгын ажил 2019.03.25-нд эхэлсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 100%-тай. Улсын комисс ажиллуулах хүсэлт ирүүлсэн. | 100% |
| 12 | | 14.Алтай-Дарви чиглэлийн 263 км хатуу хучилттай авто замыг барих | 2016-2017 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 283 920,0 | Барил-гын ажлыг дуусгах | 70 980,0<br>2017 онд зарцуул-сан -<br>Эргэн төлөлт хийх 70,980.0 | **АЗБХЗГ:** Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто замыг комиссын 2017.03.31-ний өдрийн 07/04/17 дугаар актаар баталгаажуулан улсын ашиглалтад оруулсан.<br>Тус чиглэлийн 165 км хатуу хучилттай авто замын барилгын ажил дууcч, комисс ажиллаж, 2017.12.08-ны өдрийн 07/16/17 дугаар дүгнэлт, хурлын тэмдэглэлээр баталгаажуулсан. | 100% |
| 13 | | 15.Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замыг барих | 2016-2017 | Гадаад зээл | 28 980,0 | Барил-гын ажлыг дуусгах | 24 840,0<br><br>2017 онд зарцуул-сан<br>-<br><br>2018 онд зарцуул-сан | **АЗБХЗГ:** Захиалагч 2016 оны 12 дугаар сард тус авто замын барилгын ажлын гэрээг дүгнэн хөрөнгийн эх үүсвэр өөрчлөгдөж байгаатай холбогдуулан гэрээг дуусгавар болгосон.<br>БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замын барилгын үлдэгдэл ажлыг санхүүжүүлэхээр БНХАУ-ын Эксим банктай тохиролцож, ЗГ-ын 2017 оны 132 дугаар тогтоолоор БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Тус яамны зүгээс уг авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хязгаарлагдмал тендерийг Сангийн яам болон Монгол Улсад суугаа БНХАУ-ын Элчин сайдын ирүүлсэн албан бичгийн дагуу 3 аж ахуйн нэгжийн дунд зохион байгуулсан бөгөөд гүйцэтгэгчээр “Чайна Коммуникэйшн Констракшн” ХХК- | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | -<br><br><br>2019 онд зарцуул-сан –<br><br>26,759.6 | тай шалгарч 2018.03.12-ны өдөр нийт 18.9 сая ам.долларын өртөгтэй гэрээг байгуулснаар тухайн төсөлд Засгийн газрын 2017 оны 132 дугаар тогтоолоор батлагдсан хөрөнгөөс 5.1 сая ам.долларыг хэмнэсэн.<br>Хяналтын зөвлөх үйлчилгээний зардалд шаардагдах нэмэлт хөрөнгийг тус зээлийн хөрөнгийн хэмнэлтээс шийдвэрлэх саналыг Хятадын талд тавьж шийдвэрлүүлэх асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэж, ЗГ-ын 2018.05.16-ны өдрийн 133 дугаар тогтоолоор баталсан.<br>БНХАУ-аас МУ-д суугаа Элчин сайдын яамнаас санал болгосон “Гуанжоу Ванан Констракшн Супервишн” ХХК-тай хэлэлцээр хийж, зөвлөх үйлчилгээний гэрээг 2018.07.03-ны өдөр байгуулан 2018.07.04-ний өдрийн 03/3221 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн боловч Хятадын Эксим банкнаас зөвлөхийг санхүүжилтийг олгох боломжгүй талаар албан бичгийг Сангийн яам болон тус яаманд ирүүлсэн.<br>Сангийн яамнаас 2018.08.20-ны өдрийн албан бичгээр Эксим банкнаас зөвлөхийн зардлыг санхүүжүүлэх боломжгүй болсон тул тухайн зөвлөхийн зардлыг шийдвэрлэх холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар мэдэгдсэн. Үүнтэй холбогдуулан тус чиглэлийн авто замын хяналтын зөвлөх үйлчилгээний зардал 2,265,596,740,2 төгрөгийг<br>2019 оны Төсвийн тухай хуульд тусгуулж, шийдвэрлүүлэхээр Сангийн яаманд 2018.08.27-ны өдөр албан бичиг хүргүүлсэн. 2018 онд тухайн төслийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардлын хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй тул зам барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй болсон.<br>Тухайн төслийн тусгайлсан зээлийн хэлэлцээрийг 2018 оны 08 сард байгуулсан.<br>Уг авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр “Чайна Коммуникэйшн Констракшн” ХХК шалгарч 2018 онд тус яамтай гэрээ байгуулсан. Энэхүү авто замын барилгын ажилд өдөр тутмын техник, технологийн хяналт тавих зөвлөхийн үйлчилгээний зардлыг 2019 оны Улсын төсвийн урсгал зардалд тусгаж шийдвэрлэсэнтэй холбогдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж, зөвлөхөөр шалгарсан "Мөнхөд ашдын зам" ХХК-тай 2019.06.05-ны өдөр гэрээ байгуулсан. Туслан гүйцэтгэгч “Түм арвижих” ХХК нь ПК0+000-ПК28+110 хүртэл 28.11 км, “Арж роуд” ХХК нь ПК28+110-ПК64+480 хүртэл 36.37 км авто замын барилгын ажлыг тус тус хийж гүйцэтгэж байна.Тус яамны зүгээс 2019 оны 05 дугаар сарын 23 -ны өдөр улаан шугамыг гүйцэтгэгч компанид хүлээлгэн өгсөн бөгөөд 2019 оны 06-р сарын 07-ны өдөр авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг гүйцэтгэгч компанид өгсөн.<br>Талбай дээр 133 машин механикм, тоног төхөөрөмж, 290 хүн ажиллаж байна. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 229 дүгээр тушаалаар авто замын барилгын ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан Завхан аймгийн Алдархаан, Идэр, Яруу сумдын нутаг дэвсгэр дэх Загастайн давааны дээрх чиглэлийн 67 км авто замыг 2019 оны 07 дугаар сарын 13-наас 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд түр хааж, барилгын ажлыг | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | гүйцэтгэж байна. 2019 оны 4-р улирлын байдлаар нийт ажлын гүйцэтгэл өссөн дүнгээр 65 хувьтай байна.<br>Гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээний дагуу барилга угсралтын ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр ашиглалтад оруулна. | |
| 14 | | 16.Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто замыг барих | 2016-2018 | Гадаад зээл | 83 500,0 | Барил-гын ажлыг дуусгах | 66 800,0<br><br>2017 онд зарцуул-сан 27 851,2<br><br>2018 онд зарцуул-сан 34,605.3<br><br>2019 онд зарцуул-сан 15,358.3 | **АЗБХЗГ:** Тус авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Шинжиан Бэйшин Роуд энд Бридж Групп” компани шалгарч 2016.04.15-ны өдөр нийт 42,198,856.39 ам.долларын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан бөгөөд 2018 онд авто замын барилгын ажлыг бүрэн дуусгана.<br>2017 онд **нийт ажлын явц 59%-тай.**<br>2018 онд: Тус авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Шинжиан Бэйшин Роуд энд Бридж Групп” компани шалгарч 2016.04.15-ны өдөр нийт ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан. Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 138 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2018.02.06-ны өдрийн 45 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн.<br>Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2018.04.15-ны өдөр эхлүүлсэн бөгөөд талбай дээр хөрс хуулалт 100%, далангийн дүүргэлт 100%, хөлдөлтөөс хамгаалах үе 100%, суурийн ажил 100%, гүүрийн ажил 100%, хиймэл байгууламжийн ажил 100%, хучилтын ажил 99.7% тус тус хийгдээд байна. **Нийт ажлын явц 99.98%-**тай байна.<br>Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 35 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2019.02.20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Гэрээ байгуулж авто замын барилгын ажил эхэлснээс хойш нийт 36,533,178.71 ам.долларын барилгын ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулан санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.<br>Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2019.05.25-ны өдөр эхлүүлсэн. Нийт ажлын явц 100%-тай байна. Улсын комисс 2019.08.08-ны өдөр ажиллаж, ашиглалтад хүлээн авч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэн. Комиссын 10/10/19 дүгнэлтээр баталгаажуулсан. | 100% |
| 15 | | 17. Тосонцэн-гэлийн баруун талын 4 замын уулзвараас Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто замыг барих | 2018-2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 198,700.0 | Барилгын ажлын гүйцэтгэл 60 хувь | 99,350.0 | **АЗБХЗГ:** "Концессын “Барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр Үндэсний хөгжлийн газраас “Монгол ЛЗ зам гүүр” ХХК-тай 2017.03.30-ны өдөр концессын гэрээг шинэчилж байгуулсан. Зам барилгын ажлыг эхлүүлэх 06/01/2018 дугаартай зөвшөөрлийг 2018.01.05-ны өдөр олгосон. Зам барилгын ажлыг эхлүүлэх 06/01/2018 дугаартай зөвшөөрлийг 2018.01.05-ны өдөр олгосон. 2019 оны зам барилгын ажлыг 04 дүгээр сарын 25-ны өдөр эхлүүлсэн. Барилгын талбайд нийт 66 /монгол-185, хятад-481/ ИТА, 165 ширхэг тоног төхөөрөмж, машин механизмтай ажиллаж байна. **Нийт ажлын явц 100%-тай.**<br>Улсын комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан. Комиссын 10/15/19 дүгээр дүгнэлтээр баталгаажуулсан. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | | 18.Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто замыг барих | 2016-2018 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 148 700,0 | Барил-гын ажлыг дуусгах | 104 090,0<br><br>2017 онд зарцуул-сан<br>-<br><br>2018 онд 44,610.0<br><br>Зарцуул-сан - | **АЗБХЗГ:** Үндэсний хөгжлийн газраас барилгын ажлыг гүйцэтгэх концессын гэрээг "Хос мөнгөн зам" ХХК-тай байгуулсан. Зам барилгын ажлын гүйцэтгэгчээр "Шинжиан Шинфа" ХХК, Зөвлөхөөр "Ар Си Эс Си" ХХК ажиллаж байна: Зам барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх 06/10/2017 дугаартай зөвшөөрлийг 2017.09.14-ний өдөр олгосон.<br>2018 онд далан, ухмал, дэд суурь, цементээр бэхжүүлсэн суурь, хиймэл байгууламжийн ажил, суурь хучилт 100%, өнгө хучилт 83.3 км хийгдсэн бөгөөд эхний 83.3 км замыг 2018 оны 12 сард ашиглалтад хүлээн авсан. Улсын комисс 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдрүүдэд ажиллаж, үлдсэн 52 км авто замыг ашиглалтад хүлээн авсан. Комиссын 10/15/19 дгээр дүгнэлтээр баталгаажуулсан. | 100% |
| 17 | | 19.Цэцэрлэг - Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хөвсгөл аймгийн Жаргалант, Шинэ-Идэр чиглэлийн 95 км хатуу хучилттай авто замын зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх | 2019-2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 14,010.0 | Зураг төслийг боловсруулах | 4,670.0 | **АЗБХЗГ**: **Тус замын зураг төслийг 2018 онд “Жи Ар Си” ХХК боловсруулсан.**<br>2019 оны улсын төсвийн тухай хуульд XIII.1.1.33 дугаартай "Аялал жуулчлалын босоо тэнхлэгийн зам, Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хөвсгөл аймгийн Жаргалант сум хүртэлх хайрган хучилттай авто зам, 27 км /Завхан, Их-Уул сум, Хөвсгөл, Жаргалант сум/" буюу тус замын эхний 27 км -ийг 2019-2020 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн.<br>Үнэлгээний хороо 2019.04.15-ны өдөр байгуулагдаж, 2019.06.28-ны өдөр нээсэн. "Хөвсгөл зам" ХХК-тай 2019.07.09-ны өдөр 5159.55 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гэрээ байгуулсан. Барилгын ажил 20%-тай. | 100% |
| 18 | | 20. Хатгал-Ханх чиглэлийн 179.7 км хатуу хучилттай авто замын зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг эхлүүлэх | 2019-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 11,123.6 | Зураг төслийг боловсруулах | 683.6 | **АЗБХЗГ:** Хатгал-Ханх чиглэлийн 179.7 км хатуу хучилттай авто замын зураг төслийг боловсруулах **хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй.** | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | | 21. Булган аймгийн Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх | 2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 10,320.0 | Барилгын ажлыг эхлүүлэх | 10,320.0 | Булган аймгийн Гурванбулаг-Хишиг-Өндөр чиглэлийн төгсгөлийн 22 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэгчээр "Эйч Кей Би интернэйшнл холдинг" ХХК гэрээ байгуулан ажилласан бөгөөд барилгын ажил 100% хийгдсэн. 2019.07.06-нд улсын комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан. Комиссын 10/04/19 дүгээр дүгнэлтээр баталгаажуулсан. | 100% |
| 19 | | 22.Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн хатуу хучилттай авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэн дуусгах | 2016-2020 | Улсын төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл | 143 086,0 | Барилгын ажлын гүйцэтгэл 60 хувь | 42,925.8 | **АЗБХЗГ:** Өмнөговь аймгийн зүгээс өөрсдийн хөрөнгөөр гүйцэтгүүлэхээр Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн 302.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг гүйцэтгэх гэрээг “Дардангоьв” ХХК-тай байгуулсан бөгөөд 2016 онд нийт **56 км** авто замыг барьж ашиглалтад оруулсан. 2017 онд орон нутгийн зүгээс уг замыг үргэлжлүүлэн **25 км** авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж, 09 дүгээр сарын 06-ны өдөр ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатараас цаашид орон нутгийн хөрөнгөөр зам барилгын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй тул улсын төсвийн хөрөнгөөр үргэлжлүүлэх хүсэлт ирүүлсний дагуу тус чиглэлд үргэлжлүүлэн 40 км авто зам барих хөрөнгийг МУ-ын 2019 оны төсвийн тухай хуулинд тусгуулахаар 2018.08.10-ны өдрийн 01/3822 тоотоор Сангийн яаманд санал хүргүүлсэн.<br>2019 оны төсвийн төсөлд уг төслийг **хэрэгжүүлэх хөрөнгө тусгагдаагүй**. Шаардлагатай санхүүжилтийг 2020 оны төсвийн тухай хуульд тусгуулахаар Сангийн яаманд санал мөн хүргүүлсэн. | - |
| 20 | | 23.Олон улсын шинэ нисэх онгоцны буудал-Улаанбаатар чиглэлийн 32 км хурдны авто замыг барьж дуусгах | 2016-2018 | Гадаад зээл | 154 000,0 | Барилгын ажлыг дуусгах | 2017 онд 83 700,0 зарцуулсан<br><br>40 430,1<br><br>2018 онд Зарцуулсан<br><br>103,462.3 | **АЗБХЗГ:** Улаанбаатар-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн 32.226 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Төмөр замын 4-р групп” компани шалгарч 2015.09.18-ны өдөр түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр нийт 140,335,893.00 ам.долларын барилгын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан бөгөөд гэрээний дагуу 2018 онд авто замын барилгын ажлыг 90 хувьд хүргэж, 2019.04.18-ны өдөр ашиглалтад оруулна.<br>Хяналтын зөвлөхөөр БНХАУ-ын “Гуанжоу Ванан Констракшн Супервишн” компани шалгарч 2016.05.18-ны өдөр 7,207,921.00 ам.долларын зөвлөхийн үйлчилгээний гэрээг мөн байгуулсан.<br>2017 онд **нийт ажлын явц 54.2%-тай**. 7.8%-ийн хоцролттой.<br>2018 онд: Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 368 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2018.02.06-ны өдрийн 45 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн.<br>Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2018.04.15-ны өдөр эхлүүлсэн бөгөөд талбай Талбай дээр хөрс хуулалт 100%, далангийн дүүргэлт 100%, хөлдөлтөөс хамгаалах үе 100%, буталсан суурийн ажил 100%, цементээр бэхжүүлсэн суурийн ажил 100%, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | | | | | | | 2019 онд Зарцуул-сан<br><br>90,258.5 | харлуулсан дайрга 100%, хучилтын ажил 100%, гүүрийн ажил 100%, хиймэл байгууламжийн ажил 99.97%, туузан хашлага 90.6% тус тус хийгдээд байна. **Нийт ажлын явц 96.19%-тай** байна.<br>2019 онд: Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 60 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2019.02.20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2019.04.01-ний өдөр эхлүүлсэн. Нийт **ажлын явц 100%-тай**. Улсын комисс 2019.07.03-ны өдөр ажиллаж, ашиглалтад хүлээн авсан. Комиссын 10/07/19 дүгээр дүгнэлтээр баталгаажуулсан. | |
| 21 | | 24. Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн 52.57 км хатуу хучилттай авто замыг барих | 2018-2019 | Улсын төсөв | 32,500.0 | Барилгын ажлыг дуусгах | 22,750.0 | **АЗБХЗГ:** Инженерийн нарийвчилсан зураг төслийг 2017 онд "Ар Си Эс Си" ХХК боловсруулсан. **2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй.**<br>2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 32,5 тэрбум төгрөгийг тусган 2019-2020 онд хэрэгжүүлэхээр 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>2019 оны төсвийн төсөлд уг төслийг **хэрэгжүүлэх хөрөнгө тусгагдаагүй.** | - |
| 22 | | 25. Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замыг Мөрөн-Тариалан чиглэлийн замтай холбох 120 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх | 2018-2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 14,230.0 | Барилгын ажлын гүйцэтгэл 50 хувь | 6,000.0 | **АЗБХЗГ:** "Шинжиан шин-фа" ХХК барилгын ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулсан. Зам барилгын ажлыг эхлүүлэх 06/18/2017 дугаартай зөвшөөрлийг 2017.12.26-ны өдөр олгосон. Үндэсний хөгжлийн газраас өгсөн тайлбараар концессын гэрээний дагуу Зөвлөхийн зардлыг холбогдох дансанд байршуулаагүй тул Зөвлөх барилгын ажлын талбайд гараагүй байна. Концесс эзэмшигчээс далан, ухмал, хиймэл байгууламжийн ажил гүйцэтгэж байгаа бөгөөд ойролцоогоор нийт ажлын 20%-ийг хийж гүйцэтгэсэн талаар Үндэсний хөгжлийн газарт мэдээ өгсөн боловч эдгээр ажил нь Зөвлөхөөр баталгаажаагүй байна. Эрх бүхий байгууллагаас шалгалт хийж байгаа бөгөөд 2019 онд зам барилгын ажил хийгдээгүйг тогтоосон ба зам барилгын ажлыг эхлүүлэх талаар тодорхой тов гараагүй. | - |
| 23 | | 26. Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замыг Мөрөн-Тариалан чиглэлийн замтай холбох 112.7 км хатуу хучилттай авто замын барилгын | 2019-2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 133,700.0 | Барилгын ажлын гүйцэтгэл 20 хувь | 26,740.0 | **АЗБХЗГ:** "Барих-шилжүүлэх" нөхцөлтэйгөөр хэрэгжих концессын зүйлийн жагсаалтыг Улсын Их Хурал тухайн жилийн төсвийн тухай хуулийн хавсралтаар батлахаар 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Төсвийн тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тус яамнаас 2018.08.10-ны өдрийн 01/3822 тоотоор Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулинд тусгуулахаар Сангийн яаманд санал хүргүүлсэн боловч **2019 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй.**<br>2020 оны төсвийн тухай хуульд тусгуулахаар Сангийн яаманд санал хүргүүлсэн. | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажлыг эхлүүлэх | | | | | | | |
| 24 | | 27. Чоно харайхын голын 37.68 урт метр гүүрийг барих /Ховд аймаг Дөргөн сум/ | 2018-2019 | Улсын төсөв | 1,400.0 | Барилгын ажлыг дуусгах | 140.0 | **АЗБХЗГ: 2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй** учраас төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон.<br>Сангийн яаманд 2018.06.13-ны өдрийн 01/2777 тоот албан бичгээр "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны төсвийн хязгаарыг батлах тухай" тогтоолын төсөлд тусгуулахаар хүргүүлсэн.<br>Мөн 2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 1,56 тэрбум төгрөгийг тусган 2019-2020 онд хэрэгжүүлэхээр 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Чоно харайхын голын 37.68 урт метр гүүрийг барих **хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй** учраас уг төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон.<br>Чоно харайхын голын 37.68 урт метр гүүрийн барилгын ажлын хөрөнгө оруулалтыг 2020 оны төсөвт тусгуулсан, хэрэгжилтийн хуваарийн дагуу зохион байгуулна. | - |
| 25 | | 28. Даланжаргалан-Бор-Өндөр чиглэлийн 45 км хатуу хучилттай авто замыг барих | 2018-2019 | Улсын төсөв | 14,600.0 | Барилгын ажлыг дуусгах | 8,760.0 Санхүүжүүлсэн 2019 он 5,0 тэрбум төг | **АЗБХЗГ:** Концессын гэрээгээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгүүлэх концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан Даланжаргалан сумаас Бор-Өндөр чиглэлийн 45 км хатуу хучилттай замыг Эдийн засгийн хүндрэлтэй байгаа нөхцөл байдалтай уялдуулан төсөвт ирэх ачааллыг бууруулах зорилгоор улсын хөгжлийн төлөвлөлттэй нийцээгүй, нийгэм эдийн засгийн ач холбогдол багатай тул одоогоор хэрэгжүүлж эхлээгүй байна.<br>Мөн цаашид концессын “барих-шилжүүлэх” төрлөөр авто замын төслийг хэрэгжүүлэхгүй гэсэн чиглэлийг УИХ-аас гаргасан. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар 2017.08.15-ны өдрийн 01/3569 тоот албан бичгээр Сангийн яаманд санал хүргүүлсэн боловч **2018 оны улсын төсвийн тухай хуульд тусгагдаагүй.**<br>Төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга батыг сайжруулах зорилгоор “Барих-шилжүүлэх” нөхцөлтэйгээр хэрэгжих концессын зүйлийн жагсаалтыг тухайн жилийн төсөвт тусгаж байхаар Төсвийн тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тус төслийг төсөвт тусгуулахаар Үндэсний хөгжлийн газраас Сангийн яаманд санал хүргүүлсэн боловч, хасагдаж концессын "Барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэх боломжгүй болсон.<br>"Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны төсвийн хязгаарыг батлах тухай" тогтоолын төсөлд тусгуулахаар 2018.06.13-ны өдрийн 01/2777 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Мөн 2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 49,4 тэрбум төгрөгийг тусган 2019-2020 хэрэгжүүлэхээр 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>ТНБД-ын 2019 оны 41 дүгээр тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг 2019.02.22-ны өдөр зарласан бөгөөд 2019.03.25-ний өдөр нээсэн. Тендерийг үнэлж хамгийн сайн үнэлэгдсэн оролцогчид гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлж, “Билэгт зам” ХХК-тай | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | гэрээ байгуулж, барилгын ажлыг эхлүүлсэн. **Барилга угсралтын ажлын явц 70%-тай байна**. | |
| | | 29. Дархан-Шарын гол чиглэлийн 47.97 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх | 2020 | Улсын төсөв | 5,640.0 | Барилгын ажлыг эхлүүлэх | 2019 онд 6,316.5 сая төгрөг | Тендерийг 2019.03.07-ны өдөр зарласан бөгөөд 2019.04.08-ны өдөр нээсэн. Тендерийг үнэлж “Төгс зам” ХХК-тай 2019.06.14-ний өдөр 142 тоот гэрээг байгуулсан. Барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.Хөрс хуулалт, ухмалын ажил хийгдсэн. Суурийн доод үе, далангийн ажил, бетон суурийн ажил хийгдсэн. Энэ жилийн барилга угсралтын **ажлын явц 45.68%-тай.** | 100% |
| 26 | | 30. Сайншанд-Хамрын хийд чиглэлийн авто замаас Зүүнбаян уул чиглэлийн 16 км хатуу хучилттай авто замыг барих | 2019 | Улсын төсөв | 10,000.0 | Барилгын ажлыг дуусгах | 10,000.0 | **АЗБХЗГ:** 2019 оны төсвийн төсөлд уг **төслийг хэрэгжүүлэх хөрөнгө тусгагдаагүй.**<br>Уг төслийн барилгын ажлын санхүүжилтийг төсвийн төсөлд тусгуулахаар 2019.08.14-ний өдрийн 01/4326 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2020 оны улсын төсвийн тухай хуульд тусгагдаагүй. | - |
| 27 | | 31.Хатгал-Жанхай-Тойлогт чиглэлийн 32.4 км хатуу хучилттай авто замыг барих | 2019-2020 | Улсын төсөв | 20,400.0 | Барилгын ажлын гүйцэт-гэл 40 хувь | 8,160.0 | **АЗБХЗГ:** Орон нутгаас зураг төсөл хийлгэсэн. АХБ-ны төслийн хүрээнд хэрэгжүүлж буй Хөвсгөл нуурын тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийн хүрээнд уг замыг барихаар урьдчилсан судалгааны ажлыг 2018 онд хийж дуусгасан.2019 онд төслийг хэрэгжүүлэх **хөрөнгө тусгагдаагүй.**<br>Уг замын асуудлыг Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл /МОН 3787/3788/-ийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хариуцаж хэрэгжүүлж байгаа бөгөөд 2020 онд зураг төсөл, барилгын хяналтыг гүйцэтгэх Зөвлөх компанийг шалгаруулахаар төлөвлөөд байна. | - |
| 28 | | 32.Увс аймгийн Ховд сумын Шивэрийн голын 72.8 урт метр төмөр бетон гүүрийг барих | 2016-2017 | Улсын төсөв | 3 100,0 | Гүүрийг барьж ашиглалтад оруулах | 3 100,0<br>2017 онд зарцуул-сан<br>1 000,0 | **АЗБХЗГ:** Ерөнхий гүйцэтгэгчээр "Эйч Кэй Би интернэшнл холдинг" ХХК ажиллаж, Увс аймгийн Ховд сумын Шивэрийн голын 72.8 урт метр төмөрбетон гүүрийн барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн. 2016.10.01-ний өдөр комисс ажиллаж, 2016.11.25-ны өдрийн 7/19/2016 дугаар актаар ашиглалтад авсан. | 100% |
| 29 | | 33. Тавантолгой, Сайншанд чиглэлийн бетонон хучилттай, хүнд даацын | 2018 | - | - | Хөрөнгө оруулалтын нөхцөлийн тохирол цоо, | - | **АЗБХЗГ:** ТЭЗҮ-ийг боловсруулах санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй. Тус төслийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор 2018.03.22-23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Монголын эрдэс баялаг-Уул уурхай-2018” хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад танилцуулсан.<br>Засгийн газрын 2018.05.23-ны өдрийн 139 дүгээр тогтоолоор Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төслийг "Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхээр | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 500 км авто зам барих ТЭЗҮ-ийг боловсруулж, хөрөнгө оруулалтын нөхцөлийн тохиролцоо, судалгаа хийх | | | | судалгааны ажлыг хийх | | Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад "Шууд гэрээ байгуулах"-аар тусгасан. Мөн ЗГ-ын 2018.05.23-ны 153 дугаар тогтоолоор "Зүүнбаян төмөр зам" ХХК-тай Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг концессын "Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр барьж байгуулах хэлэлцээ хийж, гэрээний төслийг ЗГ-ын хуралдаанд танилцуулахыг Үндэсний хөгжлийн газарт даалгасан. **Иймээс уг төмөр замтай зэрэгцүүлэн хүнд даацын цементбетон хучилттай 500 км авто зам барих нь эдийн засгийн хувьд ашиггүй гэж үзсэн.** Харин эхний ээлжид Тавантолгойн нүүрсийг экспортлох шинэ гарц бий болгох, коксжих нүүрсээ Бугатын төмрийн үйлдвэр буюу эцсийн хэрэглэгчид шууд хүргэх боломжтой Тавантолгой-Ханги чиглэлийн хүнд даацын авто замын төслийг хэрэгжүүлэх нь улс орны эдийн засагт үр өгөөжөө өгөхөөс гадна замын барилгын ажилд зарцуулсан хөрөнгө оруулалтаа зам ашигласны хураамжаас нөхөх боломжтой. Оюутолгой болон бусад замын дагуух уурхайнууд уг замын төслийг дэмжиж байна гэдгээ илэрхийлээд байгаа. Засгийн газраас эрх олгосны дагуу ҮХГ-аас "Тавантолгой-Ханбогд-Ханги чиглэлийн авто зам төсөл"-ийг хэрэгжүүлэх "Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" гэрээг 2019 оны 7 сард "Тахилт хайрхан транс" ХХК-тай байгуулсан. | |
| 30 | | 34. Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто замыг барих /Ховд, Увс аймаг/ | 2018-2020 | Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | 106,820.9 | Барилгын ажлын гүйцэтгэл 60 хувь | 53,410.5 | **АЗБХЗГ:** Инженерийн нарийвчилсан зураг төслийг 2012 онд "Гео зураглал" ХХК боловсруулсан. **2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй** учраас төслийг хэрэгжүүлэх боломжгүй байна**.**<br>"Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны төсвийн хязгаарыг батлах тухай" тогтоолын төсөлд тусгуулахаар 2018.06.13-ны өдрийн 01/2777 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 155,6 тэрбум төгрөгийг тусган барилгын ажлыг 2019 онд эхлүүлэхээр төлөвлөж 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 155,6 тэрбум төгрөгийг тусган барилгын ажлыг 2019 онд эхлүүлэхээр төлөвлөж 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн боловч **2019 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй**.<br>Шаардлагатай санхүүжилтийг 2020 оны төсвийн тухай хуульд тусгуулахаар Сангийн яаманд санал хүргүүлсэн. | - |
| 31 | | 35. Алтай-Улиастай чиглэлийн 138 км хатуу хучилттай авто замыг барих /Говь-Алтай, Завхан аймаг/ | 2018-2020 | Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | 99,457.0 | Барилгын ажлын гүйцэтгэл 60 хувь | 49,728.5 | **АЗБХЗГ:** Инженерийн нарийвчилсан зураг төслийг 2012 онд "Ар Си Эс Си" ХХК боловсруулсан. **2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй** учраас төслийг хэрэгжүүлэх боломжгүй байна**.**<br>Энэ чиглэлийн авто замын 134 км авто замын батлагдсан зураг төсөвтэй, 56 км авто зам дээр зураг төсөв боловсруулах шаардлагатай юм.<br>"Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны төсвийн хязгаарыг батлах тухай" тогтоолын төсөлд тусгуулахаар 2018.06.13-ны өдрийн 01/2777 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад нгийт 194 км авто замын барилгын ажилд 180,5 тэрбум төгрөгийг тусган | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | барилгын ажлыг 2019 онд эхлүүлэхээр төлөвлөж 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад нгийт 194 км авто замын барилгын ажилд 180,5 тэрбум төгрөгийг тусган барилгын ажлыг 2019 онд эхлүүлэхээр төлөвлөж 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн боловч **2019 оны төсвийн тухай хуульд тусгагдаагүй.**<br>Уг төслийн барилгын ажлын санхүүжилтийг төсвийн төсөлд тусгуулахаар 2019.08.14-ний өдрийн 01/4326 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2020 оны улсын төсвийн тухай хуульд тусгагдаагүй. | |
| 32 | 2.108. “Тавантолгой-Гашуун сухайт”, “Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулна. | 1.“Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замыг барих | 2016-2018 | Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | 2 386 380,0 | Барил-гын ажлыг дуусгах<br><br>1,073,870.0 | 1 312 510,0<br><br>2017 онд зарцуул-сан<br><br>-<br>2018 онд зарцуул-сан | **ТЗДТБХЗГ, “МТЗ” ТӨХК:** Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг БНХАУ-аас МУ-д хөнгөлөлттэй зээлээр олгох 1 (нэг) тэрбум ам.доллараас 400 сая ам.доллар олгохоор ЗГ-ын 2017 оны 222 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Үүнээс ЗГ-ын 2013 оны 82 дугаар тогтоолоор эхний ээлжинд шаардагдаж байгаа 200 сая ам.доллартай тэнцэх төгрөгийг Хөгжлийн банкаар дамжуулан Бондын санхүүжилтээс олгосон. ЗГ-ын 2017 оны 312 дугаар тогтоолоор дээрх 400 сая ам.доллар олгох тогтоолыг хүчингүй болгосон. Уг ажлын хүрээнд “Энержи ресурс рейл” ХХК-аас 74.6 сая ам.доллар, Хөгжлийн банкнаас 1.76 сая ам.долларын зээлээр тус тус санхүүжүүлж, өнөөгийн байдлаар нийт 279.2 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байдаг бөгөөд **барилгын ажлын явц 51.8 хувьтай зогссон.** Уг төслийн ажил удаан зогссон тул дахин үргэлжилсэн тохиолдолд барилгын ажлын чанар байдлыг үнэлж байж гүйцэтгэх шаардлагатай ажлын тоо хэмжээ, зураг төслийг гаргах шаардлага үүссэн. Ерөнхий сайдын 2018.04 дүгээр сард БНХАУ-д хийх айлчлалын бэлтгэл ажлыг хангах зорилгоор ЗТХС Ж.Бат-Эрдэнэ 2018.01 дүгээр сард БНХАУ-д айлчилсан. Айлчлалын үеэр Хятадын Тээврийн яамтай Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх талаар хамтран ажиллах асуудлыг хэлэлцэж, Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замын холболтын цэгийг тогтоохоор тохиролцсон **холболтын цэг тодорхой бус байгаагаас шалтгаалан ПК 208+500 -аас Монгол-БНХАУ-ын хил хүртэл төмөр замын ажлын зураг төслийг эцэслэн боловсруулах боломжгүй нөхцөл байдал үүссэн.**<br>Тус яамнаас хилийн холболтын цэг тогтоох тухай албан хүсэлтийг ГХЯ-нд 2 удаа хүргүүлээд байна.<br>Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг барьж байгуулахад нүүрсний төлбөр, нүүрсний урьдчилгаа төлбөр эсхүл нүүрсээр урт хугацаанд эргүүлэн төлөх нөхцөлөөр хэлэлцээ хийх УИХ-ын тогтоолын төслийг УУХҮЯ-аас боловсруулж, УИХ-ын 2018.06.29-ний өдрийн 73 дугаар тогтоол батлуулсан.<br>Дээрх тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗГ-ын 2018.08.08-ны өдрийн хуралдаанаар “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай” 242 дугаар тогтоол батлуулж, төмөр замын | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | барилгын ажлыг үргэлжлүүлэхэд шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн барилгын ажлыг эхлүүлэх шийдвэр гарсан.<br>Засгийн газрын 2018 оны 242 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж “Тавантолгой төмөр зам” ХХК байгуулагдсан. Тус компани Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг гүйцэтгэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Тус төслийн санхүүжилтийг шийдвэрлэх, цаашид авах арга хэмжээг тодорхойлохоор ЗТХС-ын тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. ТЭЗҮ, зураг төсөл шинэчлэх асуудлаар МТЗ ТӨХК ажиллаж байна. ЗТХС-ын 2019 оны 185 дугаар тушаалаар ЗГ-ын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг нь төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэлбэрийг тодорхойлон ЗГ-ын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэх санал гарган Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Засгийн газрын 2019.07.24-ний өдрийн хуралдаанаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх санхүүжилт болон “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувь эзэмшлийг Засгийн газрын 304 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд барилгын ажил эхлүүлэх бэлтгэл ажлын Ерөнхий төлөвлөгөө гарган ажиллаж байна. Тус тогтоолыг хэрэгжүүлж Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн "Монголын төмөр зам" ТӨХК-ийн эзэмшилд байсан эд хөрөнгө, тоног төхөөрөмж, баримт бичгийг "Тавантолгой төмөр зам" ХХК-д шилжүүлэх ажил хийгдсэн. Тус төслийн барилгын ажлын Ерөнхий гүйцэтгэгчээр "Бодь интернэшнл" ХХК-г сонгож гэрээ байгуулаад байна. | |
| 33 | | 2. “Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулах, төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх | 2016-2020 | Гадаад зээл, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | 2 386 380,0 | Барилгын ажлын гүйцэтгэл 90 хувь | 954,552.0 | **ТЗДТБХЗГ, “МТЗ” ТӨХК:** УИХ-ын 2014 оны 64 дүгээр тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д тодотгол хийж, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн царигийн өргөнийг 1435 мм байхаар шийдвэрлүүлсэн.<br>Орос-Монгол-Хятад гурван улсын төрийн тэргүүн 2016.06.23-ны өдөр “Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридор байгуулах тухай хөтөлбөр”-ийг хамтран баталсан. Энэхүү хөтөлбөрийн хавсралтад Орос-Монгол-Хятадын төмөр замын зүүн коридор буюу “Эрээнцав-Чойбалсан-Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замыг барьж байгуулахаар тусгасан.<br>Тус чиглэлийн төмөр замын шугамын чигийг ЗГ-ын 2016 оны 146 дугаар тогтоолоор батлуулсан.<br>“Хөөт-Бичигт” чиглэлийн 234 км төмөр зам барих төслийг түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээгээр хөрөнгө оруулагч өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2017 оны эхний улиралд багтаан гэрээ байгуулан ажил эхлүүлэх тухай ЗГ-ын 2016 оны 180 дугаар тогтоол гарсан.<br>Эдийн засгийн коридорыг хөгжүүлэх хүрээнд "Төмөр замын зүүн коридор бүс нутаг ба уул уурхайн хөгжил" олон улсын зөвлөлдөх уулзалтыг 2018.01.22-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Зөвлөлдөх уулзалтын үеэр талууд төмөр замын зүүн коридороор тээвэрлэх ачаа эргэлт хангалттай бий бөгөөд Забайкальскийн төмөр | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | замын ачааг хуваалцах нөхцөл байдал үүсэхгүй гэж үзсэн. “Монголын төмөр зам” ТӨХК нь Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулахаар БНХАУ-ын “Башинь төмөр зам” ХХК-тай санамж бичиг байгуулж ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг “Башинь төмөр зам” ХХК-ийн санхүүжилтээр Хятадын Төмөр замын зураг төслийн гуравдугаар хүрээлэн гүйцэтгэсэн. **Тус ТЭЗҮ үр ашиг багатай гарсан тул** Хөөт орчимд нүүрс боловсруулах, нүүрснээс хий, шингэн түлш гаргах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах аж үйлдвэрийн парк байгуулж төмөр замтай уялдуулан цогцоор нь хөгжүүлэх, ачааны эх үүсвэрийг нэмэгдүүлж ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулж байна. ТЭЗҮ бэлэн болмогц зураг төслийг боловсруулна. Монгол Улсын Уул, уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2019.09.13-ны өдрийн А/188 дугаар тушаалаар Хөөт аж үйлдвэрийн парк төсөл санаачлагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу ТЭЗҮ, төсөл хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, холбогдох санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулсан. | |
| 34 | 2.109. “Тавантолгой-Гашуун сухайт” чиглэлийн төмөр замаас Оюутолгойн салбар төмөр зам, “Шивээ хүрэн-Сэхэ” чиглэлийн боомтын төмөр замыг барьж дуусгана. | 1. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замаас Оюутолгой чиглэлийн салбар төмөр замыг барих | 2019-2020 | Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | 260,330.0 | Барилгын ажлын гүйцэтгэл 40 хувь | 104,130.0 | **ТЗДТБХЗГ, “МТЗ” ТӨХК:** Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх санхүүжилтийг шийдвэрлэн, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувь эзэмшлийг тогтоосон 304 дүгээр тогтоол батлагдсан. **Тус төслийн барилгын ажил эхэлснээр** Оюутолгойн гэрээний дагуу Засгийн газрын шийдвэр гарч тус салбар төмөр зам баригдах юм. | - |
| 35 | | 2.“Шивээхүрэн-Сэхэ” боомтын төмөр замыг барих | 2017 | Гадаад зээл, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | 156 200,0 | Барил-гын ажлыг дуусгах 2017 | 156 200,0<br><br>2017 онд зарцуул-сан<br><br>-<br>2018 онд зарцуул-сан | **ТЗДТБХЗГ, “МТЗ” ТӨХК:** Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын шугамын чигийг ЗГ-ын 2017 оны 126 дугаар тогтоолоор батлуулсан. БНХАУ-ын Зураг төслийн 3 дугаар хүрээлэн боловсруулсан Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төслийг “МАК” ХХК “Мөнгөн зөрлөг” ХХК-тай 2017 оны 05 дугаар сард гэрээ байгуулан шинэчлүүлсэн.<br>Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын геологи, геодези, археологи, палентологийн судалгаанууд болон Техникийн зураг төслийг боловсруулсан.<br>2017 онд “МАК” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Өмнийн говийн элс” ХХК, “Чинхуа МАК Нарийнсухайт” ХХК нар хамтран “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-ийг байгуулсан.<br>“Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2018.08.01-ний өдрийн 232 тоот тогтоолоор “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-тай хамтарсан төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг хууль тогтоомжийн дагуу байгуулахыг даалгасан.<br>Тогтоолыг хэрэгжүүлэх, төмөр замын суурь бүтцийн барилгыг эрчимжүүлэх үүднээс ЗТХ-ийн дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 2018.08.24-ний өдөр ажлын нарийвчилсан төлөвлөгөө баталж, биелэлтийг 7 хоног бүр шинэчлэн гаргаж, танилцуулан ажиллаж байна.<br>ЗГ-ын 2018.10.24-ний өдрийн хуралдаанаар Шивээхүрэн-Сэхэ боомтын чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээг УИХ-ын 2014 оны “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 64 дүгээр тогтоолын 1 дэх заалтад нэмэлт оруулахыг дэмжиж, 44 дүгээр тэмдэглэлээр албажуулж, УИХ-аар өргөн барьсан. УИХ-ын 2019 оны Хаврын чуулганаар хэлэлцүүлэх явцад тус төслийн ТЭЗҮ, тооцоо судалгааг дахин нягтлах гэсэн шалтгаанаар ЗГ-ын 2019:05.12-ны өдрийн 21 дүгээр тэмдэглэлээр эргүүлэн татсан.<br>Тус чиглэлийн төмөр замын **царигийн өргөний хэмжээг УИХ-аар тогтоогүй үед барилгын ажил эхлүүлэх боломжгүй** тухай хөрөнгө оруулагч талаас албан ёсоор мэдэгдээд байна.<br>Мөн тус чиглэлийн төмөр зам барих нь “Ар Ди Си Си” ХХК-ийн барьж байгуулсан Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто замын “барих-ашиглах-шилжүүлэх” концессын гэрээний холбогдох зүйл, заалттай зөрчилдөн **шүүх байгууллагад шалгагдаж байгаа болно.** | |
| 36 | 2.110. “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ. | 1. “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах, суурь бүтэц барих ажлыг эхлүүлэх | 2016-2020 | Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | 2 295 540,0 | Барилгын ажлын гүйцэтгэл 60 хувь | 918,216.0 | **ТЗДТБХЗГ, “МТЗ” ТӨХК:** Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төслийг Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод нэмэлтээр оруулах УИХ-ын тогтоолын төслийг ЗГ-ын 2018.05.30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, хуралдааны 23 дугаар тэмдэглэлээр албажуулсан. Тогтоолын төслийг УИХ-д өргөн барьсан.<br>Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын царигийн хэмжээг тогтоолгохоор өмнө нь УИХ-д өргөн барьсан тогтоолын төслийг **ЗГ-ын 2017.12.06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлээр эргүүлэн татсан.** Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-г боловсруулахаар “МТЗ” ТӨХК, БНХАУ-ын “Си Ар И Си” компани хооронд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан ТЭЗҮ-ийг боловсруулсан бөгөөд Монгол хэл рүү орчуулах ажил хийгдэж дууссан.<br>Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам барих төслийн эцсийн тайлан, ТЭЗҮ боловсруулах ажлын хэсэг ЗТХС-ын 2018.07.24-ний өдрийн 158 дугаар тушаалаар байгуулагдан ажиллаж байна.<br>Одоогоор Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих тусгай зөвшөөрөл эзэмшигчийг шийдүүлэхээр ажиллаж байна.<br>Ханги-Мандал боомтод төмөр замын хил нэвтрэх цэгийг тодорхойлж “УБТЗ” ХНН-ээс ӨМӨЗО-ны Төмөр замын зураг төслийн байгууллагатай поротокол зурж баталгаажуулсан байна.<br>“Зүүнбаян-Ханги” чиглэлийн 281 км төмөр замын царигийг тодорхойлох судалгааны ажил хийгдэж байна. | - |
| 37 | 2.111. Улаанбаатар төмөр замын техникийн шинэчлэлт хийж | 1.Улаанбаатар төмөр замын галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах | 2016-2018 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр, бусад эх үүсвэр | 120 000,0 | УБТЗ-ын тээх, нэвтрүүлэх хүчин чадал нэмэгдэх | 60 000,0<br><br>2017 онд зарцуул-сан | **ТЗДТБХЗГ, “УБТЗ” ХНН:** “УБТЗ” ХНН-ийн дохиолол, хориглол, төвлөрүүлэлтийн шинэчлэлийн ажлын хүрээнд хэсгийн нэвтрүүлэх чадварыг 20 хос галт тэргээр, тээх чадварыг 33 сая тонн хүртэл нэмэгдүүлэх, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй ажиллагааг дээшлүүлэх, ашиглалтын зардлыг бууруулах “Хойд-Улаанбаатар-Замын-Үүд”-ийн чиглэлд нэг замт хоорондын замыг радио сувгаар галт тэрэгний | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлж, “Богд Хан” төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ. | автомат хориглолын систем, диспетчерийн төвлөрүүлэлт нэвтрүүлэх | | | | | УБТЗ өөрийн хөрөнгөөр 59 942,525 $<br><br>60 000,0 2018 онд зарцуул-сан<br><br>8,340,410 $ | хөдөлгөөнийг хоорондын зай, хугацаагаар зохицуулах системээр тоноглох, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулагчийн төвлөрүүлэлт, тоон радио холбоо, тоон технологийн холбооны системийг шинэчлэх УБТЗ-ын 65 өртөө, зөрлөгт дохиолол төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн угсралт, суурилуулалтын ажлыг гүйцэтгүүлэхээр 2015 оны 10 сарын 29-ний “Элтеза” компанитай гэрээ байгуулж ажилласан ба гэрээний дагуу төслийг 2019 оны 08 дугаар сарын 30-нд хэрэгжүүлж дууссан.<br>Захиалагч Техникийн комисс ажиллуулсны дараа Улсын комисс хүлээж авах болно. | |
| 38 | | 2.Улаанбаатар төмөр замын гол замын их засварын ажлыг гүйцэтгэх /200 км/ | 2016-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр, бусад эх үүсвэр | 149 100,0 | Гол замд 150 км их засварын ажил гүйцэтгэх | 37,275.0 | **ТЗДТБХЗГ, “УБТЗ” ХНН:**<br>2016 онд гол замын 1**7 км** замд их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>2017 онд гол замын **50 км** замд их засвар хийж дууссан.<br>2018 онд гол замын **50.1 км** замд их засварын ажил хийсэн.<br>2019 онд 50км төмөр замд их засварын ажил хийгдэхээр төлөвлөсөн.<br>Их засварын ажлыг хойд, урд чиглэлүүлэд 37 км, Сүхбаатар, Аршаант өртөөдөд 13км өргөтгөлийн ажил, нийт **50 км** их засварын ажил хийж гүйцэтгээд байна. Нийт **167,1 км замд их засвар** хийсэн. | 100% |
| 39 | | 3.“Богдхан” төмөр замын трассыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулан барилгын ажлыг эхлүүлэх | 2017-2020 | Гадаад зээл, төр, хувийн хэвшлийн түншлэл | 1 125 000,0 | Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь | 447,000.0 | **ТЗДТБХЗГ:** Богдхан төмөр замын төслийг хэрэгжүүлэхээр ЗТЯ болон АХБ хооронд 2014 онд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд АХБ-ны техникийн туслалцаагаар Богдхан төмөр замын чигийн судалгааны ажлыг “Ай Си Ти Интернэшнл” ХХК тэргүүтэй түншлэл гүйцэтгэсэн.<br>Зөвлөх компани “Богдхан” төмөр замын чигийн 5 хувилбарыг 2017.09.22-ны өдөр ЗТХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, улмаар 5 дахь чигийн хувилбарыг дэмжиж, координат болон солбицлыг ЗГ-ын хуралдаанаар батлуулах шийдвэр гарсан. Зөвлөх компани чигийн судалгааны эцсийн тайланг 2017.11.14-ний өдөр ЗТХЯ-нд хүлээлгэж өгсөн.<br>Үлдэгдэл техникийн туслалцааны хүрээнд уг төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах санхүүжилтийг АХБ-ны 2018-2020 оны Монгол улс дахь үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөнд тусгуулах саналыг 2018.05.01-ний 01/1944 тоот албан бичгээр СЯ руу хүргүүлсэн.<br>Мөн ЗТХЯ-ны ТНБД АХБ-ны төлөөлөлтэй 2018.03.12-ны өдөр уулзаж АХБ-наас үзүүлж буй техникийн туслалцааны төслийг цаашид үргэлжлүүлэн “Богдхан” төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэх саналыг тавьж. 2018.04.03-ны өдрийн албан бичгээр хүргүүлсэн.<br>ЗГ-ын 2017 оны 277 дугаар тогтоолоор “Богдхан төмөр зам төслийг “Ар богдын төмөр зам” ХХК-иас Концессын зүйлийн жагсаалтын $53^2$–т | 40% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 40 | | | | | | | | нэмэлтээр оруулсан байгааг хүчингүй болгох саналыг Үндэсний хөгжлийн газарт 2017.11.14-ний өдрийн 01/4971, 2018.09.07-ны өдрийн 02/4327 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>“Богдхан” төмөр замын төслийн хүрээнд хэрэгжиж буй техникийн туслалцааг үргэлжлүүлэн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгүүлэх саналыг ТНБД-ын 2019.02.26-ны өдрийн 03/825 тоот албан бичгээр АХБ-нд хүргүүлсэн.<br>АХБ-аас зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт 5 жил тутам шинэчлэгддэг бөгөөд “TA-8935 MON: Богдхан төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, “Хөшигийн хөндийн холимог тээврийн логистикийн төвийн төсөл”-ийг энэхүү жагсаалтад ахин тусган хэрэгжүүлэх саналыг тус банканд уламжлуулахаар ЗТХ-ийн дэд сайдын 2019.05.09-ний өдрийн 02/2386 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>“Ар богдын төмөр зам” ХХК-ны оруулсан төслийг Концессын зүйлийн жагсаалтаас хасуулах саналыг ЗТХ-ийн сайдын 2019.06.12-ны өдрийн 01/3149 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>ЗГ-ын 2019.06.28-ны өдрийн 260 дугаар тогтоолоор Концессын зүйлийн жагсаалтын $53^2$ дахь заалт болох “Богдхан төмөр замын төсөл”-ийг /трасс алдаатай/ хүчингүй болгосон. “Богдхан” төмөр замын төслийн хүрээнд хэрэгжиж буй техникийн туслалцааг үргэлжлүүлэн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгүүлэх саналыг ТНБД-ын 2019.02.26-ны өдрийн 03/825 тоот албан бичгээр АХБ-нд хүргүүлсэн. Азийн хөгжлийн банкны зүгээс тус төслийн ТЭЗҮ, зураг төсөл хийж гүйцэтгэх санхүүжилтийг техникийн туслалцааг үргэлжлүүлэн олгох сонирхолтой байгаагаа илэрхийлсэн тул Зам, тээврийн яам /хуучнаар/, Азийн хөгжлийн банк хооронд 2014 онд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд ТЭЗҮ боловсруулах санхүүжилтийг шийдвэрлэсэн. Азийн хөгжлийн банкнаас зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт 5 жил тутам шинэчлэгддэг бөгөөд “TA-8935 MON:Богдхан төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг энэхүү жагсаалтад ахин тусган хэрэгжүүлэх саналыг АХБ-нд уламжлуулахаар 2019.05.09-ний өдрийн 02/2386 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Азийн хөгжлийн банкнаас Техникийн туслалцааны хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад 1 жилийн хугацаатай сунгасан бөгөөд, ТЭЗҮ боловсруулах тендерийн сонгон шалгаруулалтыг 2019.08.20-ноос 09.03-ны өдрийн хооронд зарлаж Зөвлөх үйлчилгээний багийг шалгаруулсан. | |
| 40 | | 4.“Улаанбаатар төмөр зам” ХНН байгуулах тухай 1949 оны хэлэлцээрийг | 2016-2020 | - | - | - | - | **ТЗДТБХЗГ:**<br><u>2017 онд:</u> МУ-ын Ерөнхий сайдын 2016 оны 71 дүгээр захирамжаар байгуулагдсан Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинэчлэх талаар оросын талтай хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн дэд сайдаар ахлуулж, холбогдох яамдыг төлөөлсөн 17 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажлын | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | шинэчлэх яриа хэлэлцээрийг үргэлжлүүлэх | | | | | | хэсгийн 2017.05.25-ны өдрийн ажлын хэсгийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу Оросын талтай хэлэлцээ хийх ажлын хэсгийн удирдамжийн төслийг боловсруулах хурлыг тус яамны гишүүдийн түвшинд 3 удаа хуралдаж, 2017 оны 3 дугаар улирлад хэлэлцээрийг шинэчлэх талаар Оросын талтай яриа хэлэлцээнд баримтлах удирдамжийн төслийг боловсруулж бэлэн болгосон.<br>2018 онд: "Улаанбаатар төмөр зам" ХНН өөрийн хэрэгцээнд импортолсон авто бензин болон дизелийн түлшинд 1998-2015 онуудад 76 195 156 000 төгрөгийн албан болон онцгой албан татвар төлсөн бөгөөд Гаалийн ерөнхий газар 2016 онд 31.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт төлүүлэхээр нэхэмжилж байгаа болно.<br>"Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн Оросын талын хувь нийлүүлэгчийн зүгээс дээрх албан татварыг төлж байгаа асуудал нь 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр зөрчиж буй асуудал гэж үзэн, авто бензин, дизелийн түлшинд онцгой албан татвар төлөлтийг зогсоож, урьд төлсөн татварыг зээлийн өрийн төлбөрт тооцох талаар 2009 оноос эхлэн холбогдох бүх шатанд хүсэлт, шаардлагыг тавьж эхэлсэн.<br>Энэ асуудлаар "Монгол-Зөвлөлтийн Хувь нийлүүлсэн нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай" 1949 оны хэлэлцээрийн наймдугаар зүйлийн "ж" заалтыг үндэслэн "УБТЗ" ХНН-ийн 1998-2015 онуудад төлсөн дизелийн түлшний онцгой албан татварын 73.8 тэрбум төгрөгийг Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банкнаас төмөр замын тээврийг сэргээн сайжруулахад зориулж авсан МОНП-1, МОНП-2 хөнгөлөлттэй зээл, зээлийн хүү, алдангиас суутгуулан тооцуулах асуудлыг ЗГ-ын 2018.02.22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, УИХ-аар шийдвэрлүүлэхээр тогтсон.<br>2019 онд: "УБТЗ" ХНН-ийн 1998-2015 онуудад төлсөн дизелийн түлшний онцгой албан татварын 73.8 тэрбум төгрөгийг Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банкнаас төмөр замын тээврийг сэргээн сайжруулахад зориулж авсан МОНП-1, МОНП-2 хөнгөлөлттэй зээл, зээлийн хүү, алдангиас суутган тооцох асуудлыг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэн 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр шийдвэрлэсэн. Түүнчлэн МОН-П1, МОН-П2 зээлийн үлдэгдэл төлбөрийг хувь нийлүүлэгч Оросын талтай хэлэлцэн, нийгэмлэгийн дүрмийн санг нэмэгдүүлэх замаар шийдвэрлэх тухай УИХ-ын Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хорооны 2019 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 22 дугаартай тэмдэглэл гарсан. | |
| 41 | 2.112. "Эрдэнэт-Овоот" чиглэлийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ. | 1."Эрдэнэт-Овоот" чиглэлийн төмөр замыг барих ажлыг эхлүүлэх | 2016-2020 | Гадаад зээл, төр, хувийн хэвшлийн түншлэл | 2 820 250,0 | Барилгын ажлын гүйцэтгэл 90 хувь | 987,090.0 | **ТЗДТБХЗГ, Концесс эзэмшигч "Нортерн рейлвейс" ХХК:**<br>Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, техникийн зураг төслийг СМЕК компани боловсруулж, Концесс эзэмшигч "Нортерн рейлвэйс" ХХК-д хүлээлгэн өгсөн.<br>Тус чиглэлийн төмөр замын чигийг ЗГ-ын 2017 оны 10 дугаар тогтоолоор батлуулсан.<br>"Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" нөхцөлтэй концессоор хэрэгжиж буй Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын төслийн концесс эзэмшигч "Нортерн Рэйлвэйс" ХХК нь уг төмөр замын төслийн | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | олон улсын банк, санхүүгийн байгууллагын шаардлага хангасан ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг гүйцэтгүүлэх, цаашид хамтран ажиллахаар БНХАУ-ын “Чайна гэжуба групп” корпорацитай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.<br>Санамж бичгийн дагуу “Чайна гэжуба групп” корпораци нь тус төмөр замын төслийн олон улсын банк, санхүүгийн байгууллагын шаардлага хангасан ТЭЗҮ-ийг боловсруулж дууссан. Эрдэнэт-Овоотын 547,7км төмөр замын нарийвчилсан ТЭЗҮ-г боловсруулан ЗТХЯ-нд ирүүлсэн.<br>УИХ-ын 2018.06.29-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор Эрдэнэт-Арцсуурь чиглэлийн 780 км төмөр замыг Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод нэмэлтээр оруулсан.<br>**Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас УИХ-аар "Зарим газар нутгийг Улсын тусгай хамгаалалтад авах тухай" тогтоолоор Булнайн нурууг байгалийн цогцолборт газрын ангилалаар тусгай хамгаалалтанд авсанаар батлагдсан чигээс 100 гаран км дайран өнгөрсөн, мөн Ханжаргалантын байгалийн нөөц газартай давхцсанаар төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг эхлэх боломжгүй болсон**. Ханжаргалантын чиглэлийн төмөр замын чигийн асуудлаар ЗТХС-ын 2018.12.14-ний 293 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг 2019.06.13-ны өдөр хуралдан трассын дагуу газар дээр нь очиж дүгнэлт гаргах үүрэг бүхий ЗТХЯ, БОАЖЯ, ЭХЯ, "Нортерн рэйлвэйс" ХХК, "Эгийн голын УЦС" ТӨХХК нарын хамтарсан Ажлын хэсгийг байгуулахаар шийдвэрлэсэн. ЗТХС-ын 2019.07.02-ны өдрийн 282 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Булган аймгийн Бугат суманд 2019.07.02-05-ны өдрүүдэд ажиллаж “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замын төслийг Хужирын голын хөндийгөөр зэрэгцүүлэн явуулах боломжийг судалж, батлагдсан чигийн дагуу 47 км газарт Эгийн голын усан цахилгаан станц төслийн цахилгаан дамжуулах агаарын шугамын төмөр замын трасстай огтлолцох 6 цэгийг газар дээр нь үзэж Хужирын голын хөндийгөөр уялдуулан явуулах боломжтой гэж үзэн Ажлын хэсгийн 2019.07.16-ны 19/228/07 дугаартай дүгнэлтийг гаргасан.<br>“Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замын Концессын гэрээний хугацаа 2020 оны 4 сард дуусахтай холбогдуулан Үндэсний хөгжлийн газраас 2019.08.26-ны өдрийн 01/2255 дугаартай албан бичгээр ажлын хэсэг байгуулах санал ирүүлсэн. Уг саналын дагуу концесс эзэмшигч "Нортерн рэйлвэйс" ХХК-ны захирал н.Ган-Очиртой уулзалт зохион байгуулж Хөвсгөл аймгийн Мөрөн чиглэлээр трассыг өөрчлөх боломжийг судлах, өмнөх шийдвэр, мэдээллийг яамны удирдлагуудад танилцуулах чиглэл өгсөн. | |
| 42 | 2.113. Үндэсний болон олон улсын тээвэр, ложистикийн сүлжээг | 1.Хөшигийн хөндийд тээвэр логистикийн төв байгуулах | 2017-2020 | Гадаад эх үүсвэр | 216 940,0 | Барилгын ажлын гүйцэтгэл 60 хувь | 65,080.0 | **БТГ, АТБХЗГ, ТЗДТБХЗГ, АЗБХЗГ, АТБХЗХ:**<br>Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөл, Шинэ нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын ерөнхий төлөлөгөөний тодотголд Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийг тусгуулаад байна.<br>Тус яамны зүгээс | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлж, “Хөшиг”-ийн хөндийд холимог тээвэр ложистикийн төв байгуулна. | | | | | | | - 2018 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Хөгжлийн банкны төлөөлөлтэй уулзах уулзалт, Азийн хөгжлийн банкны Эдийн засгийн судалгаа, бүс нутгийн асуудал хариуцсан захирал, төлөөлөгчтэй уулзсан уулзалтад уг төслийн талаар танилцуулан санал тавьсан.<br>- БНСУ-ын “Yooshin Engineering Corporation”-ний дэд ерөнхийлөгч Кимтэй 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан уулзалт “Хөшигийн хөндийн холимог тээврийн логистикийн төв байгуулах төсөл”-ийг танилцуулсан.<br>- Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн танилцуулгыг бэлдэн Үндэсний хөгжлийн газрын санхүүжилт шаардлагатай төслүүдийн танилцуулга бүхий сайтад тавиулахаар хүргүүлсэн.<br>- БНСУ-ын “Мэдлэг хуваалцах хөтөлбөр”-ийн хүрээнд 2020 онд хэрэгжүүлэх бодлогын зөвөлгөө авах төсөлд оруулахыг хүсч, Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах төслийн танилцуулгыг 03/4646 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>- Экзим банкны төслийн менежер Minjung PAK-т “Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах” төслийн талаарх нэмэлт мэдээлэл ирүүлэх тухай хүсэлтийн дагуу мэдээллийг 2019.02.22-ны өдөр цахим шуудангаар хүргүүлсэн.<br>- Японы JICA-гийн "Үндэсний хөгжлийн цогц төлөвлөгөө боловсруулах төсөл"-д уг төслийн санхүүжилтийг шийдвэрлүүлэх санал хүргүүлсэн.<br>- АХБ-аас зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт 5 жил тутам шинэчлэгддэг бөгөөд “TA-8935 MON: Богдхан төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, “Хөшигийн хөндийн холимог тээврийн логистикийн төвийн төсөл”-ийг энэхүү жагсаалтад ахин тусган хэрэгжүүлэх саналыг тус банканд уламжлуулахаар ЗТХ-ийн дэд сайдын 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 02/2386 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>- Зам, тээврийн салбарын урт хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах ажлын хүрээнд Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн төслийг 2020-2045 онд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад оруулсан.<br>**Азийн хөгжлийн банкнаас Техникийн туслалцааны хүрээнд Богдхан төмөр замын ТЭЗҮ боловсруулах тендер зарлагдсан. Богдхан төмөр замын ТЭЗҮ-д логистикийн төвийн тооцоо судалгаа хамаарагдах тул Хөшгийн хөндийд байгуулагдах тээвэр логистикийн төвийн урьдчилсан судалгаа уг ТЭЗҮ-ийн хүрээнд хийгдэнэ.** | |
| 43 | | 2.Замын-Үүдэд тээвэр логистикийн төв байгуулах | 2016-2019 | Гадаад эх үүсвэр | 155 330,0 | Барилгын ажлыг дуусгах | 124 264,0<br><br>2017 онд зарцуул-сан 31 244,8<br><br>2018 онд | **БТГ, АТБХЗГ, ТЗДТБХЗГ, АЗБХЗГ:**<br>Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх МОН 2719/0240 төсөл” нь АХБ-ны хөнгөлөлттэй зээл 40 сая ам.$, АХБ-ны буцалтгүй тусламж 5 сая ам.$, МУ-ын ЗГ-ын 26.64 сая ам.$-ын санхүүжилтийн эх үүсвэртэй.<br>Барилга угсралтын ажлыг 2018.04.01-ний өдрөөс эхлүүлсэн. ЗГ-ын 2018 оны 72 дугаар тогтоолоор гадаадаас ажиллах хүч авахаар шийдвэр гарч | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зээл-13’701’331’000$<br>Улсын төсөв-1’271’900.0 мян₮<br><br>Нийт Зээл-29’750’820’80$<br>Улсын төсөв-16’142’480.3 мян₮<br><br>Барилгын зөвлөх 2018 онд 578’041.19$<br>Нийт 1’067’942.97$ | тус логистикийн төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх 230 ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн.<br>АХБ-ны санхүүжилтээр: Логистикийн төвийн барилга угсралт, төмөр замын дохиолол холбооны ажлыг “Хятадын төмөр замын 21-р товчоо групп” компани;<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: Авто зам, гүүрэн байгууламж, Хамгаалалтын хашааны, Логистикийн төвийг хангах эрчим хүчний шугам, дэд станцын, Логистикийн төвийг хангах цэвэр усны шугамын барилга угсралтын ажил, Логистикийн төвийн гадна холбоо интернетийн шилэн кабель суурилуулах ажил, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ, Логистикийн төвийн зураг төсөлд магадлал хийх ажил, Цахилгаан хангамжийн зураг төсөл, төсөв боловсруулах ажил, 50 тн даацтай 2 вандан краны нийлүүлэх, угсралт, суурилуултын ажлуудыг “Ийстерн роуд” ХХК, “Ви Эйч энд Би” ХХК, “Катод гал” ХХК, “Хангилцаг” ХХК, “Лийд линк” ХХК, “Монвеком” ХХК, Барилгын хөгжлийн төв, “Баясалтгс” ХХК, “Багануур Энерги” ХХК, “Хэнань Дафан Хүнд Машин механизм” компани тус тус гүйцэтгэж, 2018.12.04-ний өдрийн байдлаар ажил дууссан.<br>Ложистикийн төвийн 50 тн даацтай 2 ширхэг иж бүрэн вандан краны тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд холбогдох журмын дагуу МХЕГ-аас дүгнэлт гаргасан.<br>**Зам, тээвэр хөгжлийн сайдын тушаалаар байгуулагдсан Улсын комисс 2018.12.28-31-ний өдрүүдэд ажиллаж, дээрх ажлуудыг 18/432/02 дугаар актаар ашиглалтад хүлээн авсан.**<br>Тус яамнаас байгуулагдсан ажлын хэсэг 2019.04.10-12-ны өдрүүдэд ажиллан логистикийн төвийн хөрөнгө хүлээлцсэн акт үйлдэж ТӨБЗГ-т хүргүүлсэн. ТӨБЗГ-ын 2019.05.21-ний өдрийн "Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай" 218 дугаар тогтоол батлагдсан.<br>“Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх МОН2719/0240 төсөл”-ийн Замын-Үүд логистикийн төвийн өмчлөгч “Монголын төмөр зам” ТӨХК, ашиглагч “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн хооронд түрээсийн гэрээ байгуулсан.<br>Өмчлөгч болох “МТЗ” ТӨХК 2019.07.16-нд ашиглагч байгууллага болох “УБТЗ” ХНН-тэй “Бүс нутгийн логистикийн төвийг түрээслүүлэх түрээсийн гэрээ”-г байгуулж, үйл ажиллагааг эхлүүлээд байна.<br>ТНбД-ын 2019.02.10-ны өдөр баталсан 376 дугаар тушаалын дагуу Улсын комисс 2019.12.12-13-ны өдрүүдэд ажиллаж, “Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд баригдсан 1.184 километр урттай салбар төмөр замыг 10/25/19 дүгээр дүгнэлтээр, 4,3 км хатуу хучилттай авто замыг 10/23/19 дүгээр дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан. | |
| 44 | | 3.Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг | 2017-2018 | - | - | Төрөөс логисти-кийн талаар | - | **БТГ, АТБХЗГ, ТЗДТБХЗГ, АЗБХЗГ, АТБХЗХ:**<br>Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах Зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан “Монголын логистикийн холбоо” ТББ-тай 2017 оны 267 дугаар гэрээ байгуулсан. | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах судалгаа хийх, батлах | | | | баримт-лах бодлогын баримт бичгийг батлуу-лах | | Үндэсний тээвэр, логистикийн төв байгуулах судалгаа хийж, зураглалыг боловсруулах ажлыг “Монгол логистикийн холбоо” ТББ бүрэн гүйцэт хийж тайланг 2018 оны 12 дугаар сард хүлээн авсан.<br>Дээрх судалгаанд үндэслэн “Төрөөс тээвэр логистикийн талаар баримтлах бодлогын баримт бичиг” боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ЗТХ-ийн сайдын 2019.оны 104 дүгээр тушаалаар байгуулсан.<br>Зам, тээврийн салбарын урт хугацааны бодлого боловсруулах ажлын хүрээнд тээвэр логистикийн бодлогыг хамруулах нь зүйтэй гэж үзсэн тул Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 265 дугаар тушаалаар Зам, тээврийн салбарын урт хугацааны бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгтэй Төрөөс тээвэр, логистикийн талаар баримтлах бодлого боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг нэгтгэн шинэчлэн байгуулсан.<br>Ажлын хэсгийн зүгээс Зам, тээврийн салбарын урт хугацааны бодлогын гол зорилтод тээвэр логистикийг хөгжүүлэх бодлогыг нэмж тусган боловсруулж Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөлд туссан болно. | |
| 45 | 2.114. Төрөөс агаарын тээврийн салбарт баримтлах бодлогод тулгуурлан орон нутгийн болон олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих замаар тус салбарт үнэ тарифыг бууруулна. | 1.Олон улсын нислэгийн сүлжээг өргөжүүлэн тогтворжуулахад чиглэсэн агаарын харилцааны хэлэлцээ хийх, хэлэлцээр байгуулах, шинэчлэх, холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах | 2016-2020 | - | - | - | - | **АТБХЗХ:**<br>**<u>Шинээр байгуулсан хэлэлцээр:</u>**<br>1. МУ, Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээрт ЗТХСайд 2017.05.25-ны өдөр Улаанбаатар хотод гарын үсэг зурсан.<br>2. МУ, Бүгд Найрамдах Мальта Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээрийг 2016.07 дугаар сард Улаанбаатар хотноо байгуулсан.<br>3. МУ, Люксембургийн Их Вант Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээрт 2017.06.01-ний өдөр ХБНГУ-ын Лайпциг хотод зохион байгуулагдсан "Олон улсын тээврийн форум"-ын үеэр гарын үсэг зурсан.<br>4. МУ, БНАУ-ын ЗГ хоорондын "Агаарын харилцааны тухай хэлэлцээр” байгуулах асуудлыг Засгийн газрын 2019.05.12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн. МУ-ын Ерөнхий сайдын 2019. 05.12-ны өдрийн 56 дугаар захирамжаар Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Азербайжан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг ЗТХ-ийн сайд Б.Энх-Амгаланд олгосон.<br>5. МУ, Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээр, МУ, Камбожийн Вант Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээрт 2017.09.26-28-ны өдрүүдэд БНИУ-ын Бали хотод зохион байгуулагдсан Ази, Европын тээврийн сайд нарын 4 дүгээр хурлын үеэр гарын үсэг зурсан. Дээрх 2 хэлэлцээрийг батлах асуудлыг Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Засгийн газрын 151, 152 дугаар тогтоолоор батлуулсан.<br>6. МУ, БНГУ-ын Засгийн газар хооронд "Агаарын харилцааны тухай хэлэлцээр” байгуулах асуудлыг 2019.05.12-ны өдрийн ЗГ-ын | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн. МУ-ын Ерөнхий сайдын 2019.05.12-ны өдрийн 55 дугаар захирамжаар Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Грек Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг ЗТХ-ийн сайд Б.Энх-Амгаланд олгосон.<br>**<u>Шинэчилсэн, нэмэлт өөрчлөлт оруулсан хэлэлцээр:</u>**<br>1. МУ, Швейцарийн Холбооны Улсын Засгийн газар хооронд 2000 онд байгуулсан Агаарын харилцааны тухай хэлэлцээрийг Европын холбооны хууль тогтоомжид нийцүүлэх зорилгоор хэлэлцээрт өөрчлөлт оруулах асуудлыг МУ-ын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлээд байна.<br>2. 2017.04.18-2017.04-21-ний хооронд МУ-аас Тайландын Вант Улсад ЗТХЯ, ИНЕГ, МИАТ ТӨХК-ийн төлөөллүүд ажиллаж, Тайландын Вант Улсын Засгийн газартай байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулж давтамж, багтаамж, нэг шугамд нэг агаарын тээвэрлэгч зэрэг өөрчлөлтүүдийг шинэчлэн тогтоосон. Энэхүү хэлэлцээрийн дагуу “МИАТ” ХК УБ-Бангкок-УБ чиглэлд нислэг гүйцэтгэж байна.<br>3. БНСУ-ын талтай 2017.06.28-29-ний өдрүүдэд агаарын харилцааны асуудлаар уулзалт, хэлэлцээ хийсэн.<br>4. БНТУ-ын Тээвэр, далай, холбооны яам, МУ-ын ЗТХЯ, ИНЕГ, “МИАТ” ХК-ийн төлөөлөгчид 2018.06.20-ны өдөр уулзалт хийсэн. Уулзалтаар хоёр талаас томилогдсон агаарын тээвэрлэгчид өмнө байгуулсан “SPA” гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар тохиролцож, цаашид “SPA” гэрээний үр дүнг харгалзан “code sharing” гэрээ байгуулах асуудлыг авч үзэхээр тогтсон.<br>5. ОХУ-ын ачаа тээврийн “Авиастар-ТУ” компани Екатеринбург-Улаанбаатар-Ордос чиглэлд агаарын тээврийн 5 дугаар эрх эдлэн 7 хоногийн 2 удаагийн давтамжтай нислэг үйлдэх тухай Харилцан ойлголцлын санамж бичгийг ОХУ-ын Тээврийн яамтай 2018.05.04-ний өдөр байгуулсан.<br>6. Гадаадын агаарын тээвэрлэгчид ОХУ-ын Улаан-Үд хотын нисэх буудлаас агаарын тээврийн 5 дугаар эрх эдлэн гуравдагч улс руу нислэг үйлдэх боломжтой болсонтой холбогдуулан БНХАУ-ын Иргэний нисэхийн захиргаанаас хоёр улсын хооронд байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрийн хавсралт Маршрутын хуваарьт Улаан-Үдийг дундын цэгээр нэмж, хоёр улсаас томилогдсон агаарын тээвэрлэгчид дундын цэг Улаан-Үдэд агаарын тээврийн 5 дугаар эрх эдлэн долоо хоногийн дөрөв (4) хүртэлх удаагийн давтамжтайгаар нислэг үйлдэх, үүнээс Монголын тал Улаанбаатар-Улаан-Үд-Манжуур, Улаанбаатар-Улаан-Үд-Хайлаар чиглэлд тус бүр долоо хоногийн хоёр (2) удаагийн давтамжтайгаар нислэг үйлдэх боломжтой тухай 2018.05.10-ны өдрийн MHJH(2018)139, 2018.06.11-ний 01/67 тоот албан бичгүүдийг хоёр улсын иргэний нисэхийн байгууллагууд солилцож хоёр улсын хооронд байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрт өөрчлөлт оруулсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 7. Канад Улс, Испанийн Вант Улстай агаарын харилцааны хэлэлцээр байгуулахаар хоёр талаас төсөл солилцож, 2018.12 дугаар сард Бүгд Найрамдах Кени Улсын Найроби хотноо зохион байгуулагдах Олон улсын агаарын харилцааны хэлэлцээрийн үеэр үзэглэхээр тохиролцсон.<br>8. Нидерландын Вант Улстай аялалын дугаар хамтран ашиглах зохицуулалтын санамж бичгийг 2018.12 дугаар сард Бүгд Найрамдах Кени Улсын Найроби хотноо зохион байгуулагдах Олон улсын агаарын харилцааны хэлэлцээрийн үеэр байгуулахаар санамж бичгийн төслийг ГХЯ-нд хүргүүлсэн.<br>9. Агаарын харилцааны тухай Монгол Улс БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хоёр улсын хоорондын агаарын тээврийн зах зээлийг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор талууд хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр уг хэлэлцээрт 2019.01.17-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. | |
| 46 | | 2.Орон нутгийн нислэгийг сэргээн тогтворжуулахад агаарын тээврийн компаниудыг татварын бодлогоор дэмжих | 2016-2020 | - | - | Хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувь | - | **АТБХЗХ:** ЗТХС-ын 2016 оны 93 дугаар тушаалаар Орон нутгийн агаарын тээврийг сэргээн тогтворжуулах, агаарын тээврийн үнэ тарифыг бууруулах талаар судалгаа хийж санал боловсруулах, дүгнэлт гаргах ажлын хэсгийг томилон ажиллуулж байна. Орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ болон орон нутгийн нисэх буудлын үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хувиар тогтоолгох эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх зорилгоор холбогдох хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулан Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон боловч МУ ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдсантай холбогдуулан асуудлыг түр хойшлуулсан.<br>Аймгууд руу тогтмол нислэг хийх асуудлыг шийдвэрлүүлэхээр Сангийн яаманд ЗТХ-ийн сайдын 2017.10.27-ны өдрийн 01/4689 тоот албан бичгийг хүргүүлсэн.<br>Сангийн яамнаас 2017.11.16-ны өдрийн 4-3/6325 тоот албан бичгээр дотоодын агаарын тээвэрлэгчдийн нислэгийн татаасыг нэг удаагийн нислэгийн суудал дүүргэлтийн 30% хүртэлх хэмжээнд дүйцүүлж нөхөн олговортой нислэгийг гүйцэтгүүлэхийг дэмжиж, тус агаарын тээвэрлэгчдийн ИНЕГ-т төлөх өр төлбөрөөс хасах замаар шийдвэрлэх чиглэл өгсөн. Улаанбаатар-Алтай чиглэлд Агаарын тээвэрлэгчдийн ИНЕГ-т төлөх өр төлбөрөөс суутгах зарчмаар нөхөн олговортой нислэгийг гүйцэтгүүлэх гэрээг “Хүннү Эйр” ХХК-тай байгуулаад байна.<br>Орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ, орон нутгийн нисэх буудлын үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийн үр нөлөөг судлах, үр нөлөөг үнэлэх, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зэрэг ажлууд хийгдэж байна.<br>Орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ болон нисэх буудлын үйлчилгээний НӨАТ-ыг чөлөөлүүлэх тухай хүсэлтийг ЗТХС-ын 2018.04.20-ны өдрийн 01/1758 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ болон орон нутгийн нисэх буудлын үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвар хураамжаас чөлөөлүүлэх талаар судалгааг хийж, хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг боловсруулжсан. Дотоодын агаарын тээвэрлэгчдийг оролцуулсан хэлэлцүүлгийг 2018.09.14-ний өдөр зохион байгуулсан. “Аргачлал батлах тухай” ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын хавсралтын дагуу НӨАТ-ын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулан төслийг санал авахаар Сангийн Яаманд хүргүүлээд байна.<br>ИНЕГ-аас ирүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахад шаардлагатай хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааг хянаж, үзэл баримтлалын төслийг батлуулахаар ЗТХЯ-ны 2018.11.27-ны өдрийн 01/5645 тоот албан бичгээр СЯ, ХЗДХЯ руу хүргүүлсэн боловч дахин боловсруулах чиглэл өгсөн. Хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулсан, батлуулахаар ажиллаж байна.<br>Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөрийн төслийг боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авч, хөтөлбөрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. /2019.06.18-ны өдрийн 01/3276 тоот/<br>Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөрийг Засгийн газрын 2019.07.03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж "Хөтөлбөр батлах тухай" 283 дугаар тогтоолоор баталсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулан ЗТХЯ-ны 2019.08.30-ны өдрийн 03/4611 тоотоор Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас санал авсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ЗТХСайдын 2019.10.03-ны өдрийн “Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 309 дүгээр тушаалаар баталсан. Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |
| 47 | | 3.Агаарын тээврийн салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өрсөлдөөнт орчныг бүрдүүлэх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх | 2017-2020 | - | - | Өрсөлдөөнт орчныг бүрдүүлэхэд чиглэсэн ажлууд хийгдэх | - | **АТБХЗХ:** Агаарын тээврийн салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өрсөлдөөнт орчныг бүрдүүлэх чиглэлээр судалгаа хийсэн. Уг судалгаанд **а**гаарын навигацийн болон нисэх буудлын үйлчилгээний өнөөгийн байдал, ирээдүйн чиг хандлага, буулт хөөрөлт болон өнгөрөлтийн тоог нэмэгдүүлэх боломж, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, агаарын тээврийн салбарын дотоод гадаадын зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн чиг хандлага, агаарын хөлгийн парк шинэчлэл, зорчигчийн тоо, нислэгийн тоо /чиглэлийн/, давтамжийг нэмэгдүүлэх боломж, зах зээлийг өргөтгөх боломж, өрсөлдөөнт орчныг бүрдүүлэх зэрэг асуудлуудыг хамруулсан.<br>- Агаарын тээврийн салбарын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өрсөлдөөнт орчныг бүрдүүлэх зорилттой холбогдуулан “Агаарын тээврийн либералчлал-Иргэний нисэхийн салбарын шинэчлэл” сэдэвт зөвлөгөөнийг 2018.03.19-ний өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөнөөс | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр зөвлөмж гаргасан.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын “Төлөвлөгөө батлах тухай” 2018.05.15-ны өдрийн 105 дугаар тушаалаар Иргэний нисэхийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнөөс гарсан Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулсан.<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулж, биелэлтийг ханган ажиллаж байна. Үүнд:<br>- “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичигт нэмэлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын 2018.06.29-ний хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-ын 72 дугаар тогтоолоор батлуулсан. Ингэснээр Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичгийн 3.8-д "агаарын тээврийн зах зээлийг үе шаттай чөлөөлөх бэлтгэлийг хангах зорилгоор үндэсний агаарын тээвэрлэгчийн олон улсын үндсэн нислэгийн чиглэлд (Улаанбаатар-Сөүл-Улаанбаатар, Улаанбаатар-Бээжин-Улаанбаатар) хоёрдогч тээвэрлэгчийг оруулахгүй байх, бусад тээвэрлэгчийг олон улсын бусад шугамд, орон нутаг, бүс нутгийн шугамд хуваарилах зарчмаар агаарын тээврийн зах зээлийг эдийн засгийн хувьд зохицуулах чиглэл баримтална" гэж, 3.9-д "гадаад улсын үндсэн нислэгийн чиглэлээс Монгол Улс руу хуваарьт нислэг үйлдэх тээвэрлэгчийн тухайд "нэг шугам-нэг тээвэрлэгч" бодлого баримталж, үндэсний компанийн өрсөлдөх чадварыг сайжруулж, ижил тэнцүү орчинд өрсөлдөх боломжийг бүрдүүлнэ" гэж заасан байсныг өөрчлөн Улаанбаатар-Сөүл-Улаанбаатар, Улаанбаатар-Бээжин-Улаанбаатар чиглэлд бусад агаарын тээвэрлэгчид орох боломж бүрдүүлсэн.<br>Бодлогын баримт бичигт өөрчлөлт орсонтой холбогдуулан Монгол-Солонгосын агаарын харилцааны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг ойрын хугацаанд хийхээр төлөвлөн ажиллаж байна. Монгол-Солонгосын агаарын харилцааны талаар уулзалт хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.09.11-ний өдрийн 199 дүгээр тушаалаар шинэчилсэн. Агаарын харилцааны тухай Монгол Улс БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрт 2019.01.17-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.<br>- Дэлхийн худалдааны байгууллагын “Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр”-т нэгдэн орох асуудлыг Засгийн газрын 2018.06.27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн. Засгийн газраас УИХ-д 2018.07.06-ны өдөр өргөн мэдүүлсэн. Уг хэлэлцээрийг 2018.10.10-ны өдөр УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэн дэмжиж, улмаар УИХ-ын 2018.10.12-ны өдрийн чуулганаар хэлэлцэж, Хэлэлцээрт нэгдэн орох тухай” хуулийг соёрхон баталсан.<br>- “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2018.05.02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 120 дугаар тогтоолоор батлуулсан. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.08.09-ний өдрийн 170 | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дугаар тушаалаар “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан.<br>Агаарын хөлгийн шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан бууруулах боломжийн талаарх судалгааг хийж, санал боловсруулсан. | |
| 48 | | 4.Авиакомпаниудын бизнесийн тогтвортой ажиллагааг хангах, өртөг зардлыг бууруулах чиглэлээр хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, өрсөлдөөн, хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих | 2017-2020 | - | - | Хөрөнгө оруулалтыг дэмжсэн ажлууд хийгдэх | - | **АТБХЗХ:** ИНЕГ-ын даргын 2017.04.24-ний өдрийн А/256 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг агаарын харилцааны хэлэлцээрийн талаарх баримтлах бодлого, үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК-ийн нислэгийн үйл ажиллагаанд санал, дүгнэлт боловсруулан, ИНЕГ-ын даргын зөвлөлд танилцуулж, дахин хянан боловсруулсан.<br>“Аэромонголиа” ХХК, “Хүннү Эйр” ХХК-ийн 2016 оны санхүүгийн тайлан, 2017 оны хагас жилийн тайланд шинжилгээ хийж, авиакомпаниудын бизнесийн тогтвортой ажиллагааг хангах, өртөг зардлыг бууруулах чиглэлээр хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, өрсөлдөөн, хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих судалгаа хийсэн.<br>“МИАТ” ТӨХК, “Хүннү Эйр” ХХК, “Аэро Монголиа” ХХК-уудаас 2017.06.12-ны өдрийн 06/2201 тоот албан бичгээр санал авч, үнэ тарифын талаар цаашид авах арга хэмжээ, бууруулах боломжийн талаар санал боловсруулав.<br>Агаарын тээвэрлэлтийн өртөг зардлыг бууруулах чиглэлээр хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, өрсөлдөөн, хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих ажлыг хэрэгжүүлэх хүрээнд ИНЕГ-ын даргын 2017 оны А/531 дүгээр тушаалаар шинэ чиглэлд нислэг үйлчилгээ эхлүүлж байгаа “Хүннү Эйр” ХХК-ийн Улаанбаатар-Улаан-Үүд-Улаанбаатар чиглэлийн нислэгийн агаарын навигацийн үйлчилгээний хураамжийг аялал жуулчлалын оргил үе болох зуны улиралд буюу 2017.08.16-ны өдрөөс мөн оны 10.28-ны өдрийг дуустал хугацаанд чөлөөлсөн. 2017.06-08 дугаар сар хүртэлх хугацаанд УБ-Говь-Алтай-УБ чиглэлд 7 хоногт 1 удаагийн давтамжтай нөхөн олговортой нислэг гүйцэтгүүлэх харьцуулсан тендер зарлаж, “Хүннү Эйр” ХХК-ийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан 10 удаагийн нислэг гүйцэтгүүлсэн. Мөн “Хүннү Эйр” ХХК-ийн ирүүлсэн саналыг үндэслэн холбогдох яамдаас санал авч, тус агаарын тээвэрлэгчийн хуримтлагдсан өр төлбөрөөс нийт 45 сая төгрөг суутган тооцож, 2017.11.17-12.15 хүртэлх хугацаанд 9 удаагийн нислэг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан, УБ-Говь-Алтай-УБ-ын чиглэлд долоо хоногт 2 удаагийн давтамжтай нислэг үйлдэж байна.<br>Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөрийн төслийг шинэчлэн, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн нөлөөллийн шинжилгээ хийж, үндэслэл, шаардлага, орон нутгийн нислэгийн статистик мэдээлэл, агаарын тээврийн зайлшгүй үзүүлэх чиглэлүүд, хөтөлбөрийн төсөлд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбоотой хавсралтуудыг тус тус боловсруулаад байна.<br>“Хүннү Эйр” ХХК-ийн ирүүлсэн Улаанбаатар-Улаан-Үүд-Улаанбаатар чиглэлийн нислэгийн агаарын зам ашигласны хураамж, навигацийн болон нисэх буудлын буулт, хөөрөлтийн хураамж, зорчигчдын такс, бүртгэх | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | цэгийн хураамж, карго терминалын хураамжуудаас эхний жилд 100 хувь чөлөөлүүлэх, Улаанбаатар-Улаан-Үд-Улаанбаатар, Улаанбаатар-Манжуур-Улаанбаатар, Улаанбаатар-Бугат-Улаанбаатар, Улаанбаатар-Эрээн-Улаанбаатар чиглэлийн нислэгийн агаарын зам ашигласны хураамж, нисэх буудлын буулт, хөөрөлтийн хураамж, зорчигчдын такс, бүртгэх цэгийн хураамж, карго терминалын хураамжуудыг олон улсын бус орон нутгийн нислэгийн үнэлгээгээр тооцуулах тухай хүсэлтийг судалж байна.<br>“Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулан ИНЕГ-аас 2018.11.22-ны өдрийн 01/4053 тоот албан бичгээр ирүүлснийг хянаж, яамдаас санал авсан. /2019.03.15-ны өдрийн 01/1181 тоот/. Зайлшгүй үйлчилгээний хөтөлбөрийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. /2019.06.18-ны өдрийн 01/3276 тоот/. Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөрийг Засгийн газрын 2019.07.03-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж "Хөтөлбөр батлах тухай" 283 дугаар тогтоолоор баталсан.<br>Дотоодын агаарын тээврийн байгууллагуудад агаарын хөлгийн парк шинэчлэлттэй холбоотой эхлэлтийн зардлыг бууруулан нисэх баг, инженер техникийн ажилтануудад сургалтын зардлыг 2016.05.16-ны 4 талт “Хамтын ажиллагааны санамж” бичгийн дагуу хэрэгжүүлж байна. 2016 онд “Хүннү Эйр” ХХК-д 400 сая төгрөгийн, “Аэромонголиа” ХХК-д 200 сая төгргийн дэмжлэг үзүүлсэн. Мөн 2018 онд санамж бичгийн хүрээнд “Аэромонголиа” ХХК-д 405 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр гэрээ байгуулсан.<br>Агаарын тээвэрлэгчдийн шатахууны зардлыг бууруулах нөхцөл боломжуудыг судлан, ИНЕГ-ын удирдлагуудад танилцуулсан. Иргэний нисэхийн салбарт хувийн хэвшлийг дэмжих чиглэлээр суурь судалгаа хийж, иргэний нисэхийн салбарт хувийн хэвшлийн оролцоог дэмжих чиглэлээр 2018-2020 онд хийх ажлын төлөвлөгөөг ИНЕГ-ын тэргүүн Дэд дарга даргаар батлуулсан.<br>МУ-ын Засгийн газар ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ, БНТУ–ын Засгийн газар хооронд байгуулсан агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу хуваарьт нислэг үйлдэж буй агаарын тээвэрлэгчдийн зах зээлийн судалгаа, зорчигч тээвэрлэлтийн судалгаа, өрсөлдөгч гадаадын тээвэрлэгчдийн харьцуулсан судалгааг хийж, тус чиглэлүүдэд үүсээд байгаа эрэлтийг хангахуйц нийлүүлэлтийг хийх арга хэмжээг авч байна.<br>“МИАТ” ХК, “Хүннү Эйр”ХХК, “Аэромонголиа”ХХК-иудын 2017 оны санхүүгийн тайланд шинжилгээ хийж, агаарын тээвэрлэгч нартай санал солилцож, санал зөвлөмж өгсөн.<br>Агаарын тээврийн Улаанбаатар-Хонг Конг, Улаанбаатар-Бээжин чиглэлийн зах зээлийн судалгааг хийж, дүгнэлт гаргасан. Судалгааг үндэслэн “Изинис Эйрвэйз” ХХК-ийг Улаанбаатар-Хонг Конг-Улаанбаатар нислэгийн чиглэлд /ЗТХ-ийн Сайдын 2019.03.12-ны 72 дугаар тушаал/, “Хүннү Эйр” ХХК-ийг Улаанбаатар-Бээжин (Daxing airport)-Улаанбаатар | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нислэгийн чиглэлд /ЗТХ-ийн Сайдын 2019.03.15-ны 85 дугаар тушаал/ тус тус томилж, холбогдох журмын дагуу баталгаажуулахаар ГХЯ-д хүргүүлсэн. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэл ИНЕГ болон агаарын тээвэрлэгчдэд өгсөн. /2019.03.18-ны 09/1221, 2019.03.19-ний 09/1227 тоот албан бичиг/ Мөн "МИАТ" ТӨХК-ийг ЗТХСайдын 2019.01.22-ны өдрийн 17 дугаар тушаалаар Улаанбаатар-Шанхай-Улаанбаатар чиглэлд, ЗТХ-ийн Сайдын 2019.02.01-ний өдрийн 27 дугаар тушаалаар Улаанбаатар-Гуанжоу-Улаанбаатар чиглэлд нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр тус тус томилсон. ЗТХС-ын 2019.07.25-ны өдрийн 248 дугаар тушаалаар агаарын тээврийн “Аэромонголиа” ХХК-ийг Улаанбаатар-Фукуока-Улаанбаатар, Улаанбаатар-Токио-Улаанбаатар, Улаанбаатар-Осака-Улаанбаатар нислэгийн чиглэлд тус тус нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр томилсон. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019.07.25-ны өдрийн 249 дүгээр тушаалаар агаарын тээврийн “Изинис Эйрвэйз” ХХК-ийг Улаанбаатар-Екатеринбург-Улаанбаатар нислэгийн чиглэлд, 250 дугаар тушаалаар агаарын тээврийн “Изинис Эйрвэйз” ХХК-ийг Улаанбаатар-Истанбул-Улаанбаатар нислэгийн чиглэлд, 251 дүгээр тушаалаар агаарын тээврийн “Изинис Эйрвэйз” ХХК-ийг Улаанбаатар-Макао-Улаанбаатар нислэгийн чиглэлд, 252 дугаар тушаалаар Агаарын тээврийн “Хүннү Эйр” ХХК-ийг Улаанбаатар- Алма-Ата- Улаанбаатар нислэгийн чиглэлд нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр тус тус томилсон. | |
| 49 | | 5.Иргэний нисэхийн салбарын бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх | 2017-2018 | - | - | Бүтцийн өөрчлөлт бүрэн хэрэгжих | - | **АТБХЗХ:** "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг ЗТХС-ын 2017.02.21-ний өдрийн 38 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.<br>Сайдын 2017.10.27-ны өдрийн 220 дугаар тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалтыг менежментийн түвшинд сайжруулах судалгаа хийж, санал боловсруулж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж ажилласан.<br>ЗТХС, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 147/165 дугаар тушаалаар Үйлдвэрлэлийн албадын орон тооны дээд хязгаарыг 2431 болгон баталсан. Батлагдсан орон тооны дээд хязгаарт багтаан ИНЕГ-ын даргын тушаалаар тус газрын харьяа үйлдвэрлэлийн салбар, нэгжүүдийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог тус тус шинэчлэн баталж, ажилтнуудыг томилсон.<br>Улаанбаатар хотноо 2018.03.19-20-ны өдрүүдэд зохион байгуулсан “Агаарын тээврийн либералчлал, иргэний нисэхийн салбарын шинэчлэл”, “Иргэний нисэхийн салбарын шинэчлэл” сэдэвт салбарын удирдах ажилтны зөвлөгөөнөөс иргэний нисэхийн салбарын бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, шинэчлэлийг хэрэгжүүлэх талаар гаргасан санал, зөвлөмжийг хэрэгжүүлэхээр ЗТХС-ын 2018.05.15-ны өдрийн 105 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөөнд иргэний нисэхийн салбарын бүтцийн шинэчлэлтийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн оруулж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд: | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | - Иргэний нисэхийн салбарт бүтцийн шинэчлэлт хийх<br>- Нисэх буудлууд бие даан ажиллах боломж бүрдүүлэх, зах зээлийн зарчмаар ажиллах бүтэц, зохион байгуулалтыг хэрэгжүүлэх<br>-Иргэний нисэхийн судалгаа, шинжилгээний төв байгуулан ажиллуулах зэрэг ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан.<br>Үүний дагуу ЗТХС-ын 2018.07.04-ний өдрийн 151 дүгээр тушаалаар ИНЕГ-ын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, нисэх буудлуудыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах төрийн өмчит компани байгуулах бэлтгэлийг хангах зорилгоор Нисэх буудлуудын удирдах газрыг шинээр байгуулж, ЗТХС-ын 2018.09.24-ний өдрийн 215 дугаар тушаалаар ИНЕГ-ын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг баталсан. Мөн ИНЕГ-ын зохион байгуулалтын бүтцээр “Мэдээллийн технологи, инноваци, судалгаа хөгжлийн алба” шинээр байгуулагдсан.<br>Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлуулсны дараа Иргэний нисэхийн салбарын бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх боломжтой болно. | |
| 50 | | 6.Олон улсын нислэгийн сүлжээг өргөжүүлэн тогтворжуулахад чиглэсэн агаарын харилцааны хэлэлцээр байгуулах, шинэчлэх, холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах | 2017-2020 | - | - | Агаарын харилцааны хэлэлцээрийн хэлцлүүд хийгдэх | - | **АТБХЗХ:**<br>**<u>Шинээр байгуулсан хэлэлцээр:</u>**<br>1. МУ, Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээрт ЗТХСайд 2017.05.25-ны өдөр Улаанбаатар хотод гарын үсэг зурсан.<br>2. МУ, Бүгд Найрамдах Мальта Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээрийг 2016.07 дугаар сард Улаанбаатар хотноо байгуулсан.<br>3. МУ, Люксембургийн Их Вант Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээрт 2017.06.01-ний өдөр ХБНГУ-ын Лайпциг хотод зохион байгуулагдсан "Олон улсын тээврийн форум"-ын үеэр гарын үсэг зурсан.<br>4. МУ, БНАУ-ын ЗГ хоорондын "Агаарын харилцааны тухай хэлэлцээр” байгуулах асуудлыг Засгийн газрын 2019.05.12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн. МУ-ын Ерөнхий сайдын 2019. 05.12-ны өдрийн 56 дугаар захирамжаар Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Азербайжан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг ЗТХ-ийн сайд Б.Энх-Амгаланд олгосон.<br>5. МУ, Мьянмарын Холбооны Бүгд Найрамдах Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээр, МУ, Камбожийн Вант Улсын Засгийн газар хоорондын Агаарын харилцааны тухай хэлэлцээрт 2017.09.26-28-ны өдрүүдэд БНИУ-ын Бали хотод зохион байгуулагдсан Ази, Европын тээврийн сайд нарын 4 дүгээр хурлын үеэр гарын үсэг зурсан. Дээрх 2 хэлэлцээрийг батлах асуудлыг Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Засгийн газрын 151, 152 дугаар тогтоолоор батлуулсан.<br>6. МУ, БНГУ-ын Засгийн газар хооронд "Агаарын харилцааны тухай хэлэлцээр” байгуулах асуудлыг 2019.05.12-ны өдрийн ЗГ-ын | 2.114.1-тэй ижил<br><br>100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн. МУ-ын Ерөнхий сайдын 2019.05.12-ны өдрийн 55 дугаар захирамжаар Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Грек Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг ЗТХ-ийн сайд Б.Энх-Амгаланд олгосон.<br>**<u>Шинэчилсэн, нэмэлт өөрчлөлт оруулсан хэлэлцээр:</u>**<br>1. МУ, Швейцарийн Холбооны Улсын Засгийн газар хооронд 2000 онд байгуулсан Агаарын харилцааны тухай хэлэлцээрийг Европын холбооны хууль тогтоомжид нийцүүлэх зорилгоор хэлэлцээрт өөрчлөлт оруулах асуудлыг МУ-ын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлээд байна.<br>2. 2017.04.18-2017.04-21-ний хооронд МУ-аас Тайландын Вант Улсад ЗТХЯ, ИНЕГ, МИАТ ТӨХК-ийн төлөөллүүд ажиллаж, Тайландын Вант Улсын Засгийн газартай байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулж давтамж, багтаамж, нэг шугамд нэг агаарын тээвэрлэгч зэрэг өөрчлөлтүүдийг шинэчлэн тогтоосон. Энэхүү хэлэлцээрийн дагуу “МИАТ” ХК УБ-Бангкок-УБ чиглэлд нислэг гүйцэтгэж байна.<br>3. БНСУ-ын талтай 2017.06.28-29-ний өдрүүдэд агаарын харилцааны асуудлаар уулзалт, хэлэлцээ хийсэн.<br>4. БНТУ-ын Тээвэр, далай, холбооны яам, МУ-ын ЗТХЯ, ИНЕГ, “МИАТ” ХК-ийн төлөөлөгчид 2018.06.20-ны өдөр уулзалт хийсэн. Уулзалтаар хоёр талаас томилогдсон агаарын тээвэрлэгчид өмнө байгуулсан “SPA” гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар тохиролцож, цаашид “SPA” гэрээний үр дүнг харгалзан “code sharing” гэрээ байгуулах асуудлыг авч үзэхээр тогтсон.<br>5. ОХУ-ын ачаа тээврийн “Авиастар-ТУ” компани Екатеринбург-Улаанбаатар-Ордос чиглэлд агаарын тээврийн 5 дугаар эрх эдлэн 7 хоногийн 2 удаагийн давтамжтай нислэг үйлдэх тухай Харилцан ойлголцлын санамж бичгийг ОХУ-ын Тээврийн яамтай 2018.05.04-ний өдөр байгуулсан.<br>6. Гадаадын агаарын тээвэрлэгчид ОХУ-ын Улаан-Үд хотын нисэх буудлаас агаарын тээврийн 5 дугаар эрх эдлэн гуравдагч улс руу нислэг үйлдэх боломжтой болсонтой холбогдуулан БНХАУ-ын Иргэний нисэхийн захиргаанаас хоёр улсын хооронд байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрийн хавсралт Маршрутын хуваарьт Улаан-Үдийг дундын цэгээр нэмж, хоёр улсаас томилогдсон агаарын тээвэрлэгчид дундын цэг Улаан-Үдэд агаарын тээврийн 5 дугаар эрх эдлэн долоо хоногийн дөрөв (4) хүртэлх удаагийн давтамжтайгаар нислэг үйлдэх, үүнээс Монголын тал Улаанбаатар-Улаан-Үд-Манжуур, Улаанбаатар-Улаан-Үд-Хайлаар чиглэлд тус бүр долоо хоногийн хоёр (2) удаагийн давтамжтайгаар нислэг үйлдэх боломжтой тухай 2018.05.10-ны өдрийн MHJH(2018)139, 2018.06.11-ний 01/67 тоот албан бичгүүдийг хоёр улсын иргэний нисэхийн байгууллагууд солилцож хоёр улсын хооронд байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрт өөрчлөлт оруулсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 7. Канад Улс, Испанийн Вант Улстай агаарын харилцааны хэлэлцээр байгуулахаар хоёр талаас төсөл солилцож, 2018.12 дугаар сард Бүгд Найрамдах Кени Улсын Найроби хотноо зохион байгуулагдах Олон улсын агаарын харилцааны хэлэлцээрийн үеэр үзэглэхээр тохиролцсон.<br>8. Нидерландын Вант Улстай аялалын дугаар хамтран ашиглах зохицуулалтын санамж бичгийг 2018.12 дугаар сард Бүгд Найрамдах Кени Улсын Найроби хотноо зохион байгуулагдах Олон улсын агаарын харилцааны хэлэлцээрийн үеэр байгуулахаар санамж бичгийн төслийг ГХЯ-нд хүргүүлсэн.<br>9. Агаарын харилцааны тухай Монгол Улс БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хоёр улсын хоорондын агаарын тээврийн зах зээлийг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор талууд хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр уг хэлэлцээрт 2019.01.17-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. | |
| 51 | | 7.Үндэсний агаарын тээвэрлэгчийн менежментийг концессоор гүйцэтгүүлэх замаар бүтэц, менежментийг шинэчлэх | 2016-2017 | - | - | Үндэсний агаарын тээвэрлэгчийн менежментийг концессоор гүйцэтгүүлэх | - | **АТБХЗХ:** Засгийн газрын бүтэц, зохион байгуулалт, зарим яам, агентлагийн чиг үүрэг шинэчлэгдсэнтэй холбоотойгоор “МИАТ” ТӨХК-ийн менежментийг концессоор хэрэгжүүлэх ажлыг ЗГ-ын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д нэмэлтээр оруулах асуудлыг хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлүүлж өгөхийг хүсч, ЗТХС-ын 2016.12.06-ны өдрийн 01/2003 тоот албан бичгээр ҮХГ-т шилжүүлсэн.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас боловсруулан ирүүлсэн “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөлд “МИАТ” ТӨХК-ийн удирдлагын болон санхүүгийн засаглалыг сайжруулах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, техник, технологийг шинэчлэх зорилгоор тус компанийн төрийн мэдлийн хувьцааны тодорхой хувийг хувьчлах урьдчилсан бэлтгэл хангах ажлыг 2018 онд эхлүүлэх санал өгсөн. “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг 2018.05.23-ны өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн. “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2018.06.27-ны өдрийн хурлаар хэлэлцэн дэмжиж, УИХ-д өргөн мэдүүлсэн.<br>“Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулалт хийх үндсэн чиглэл”-ийн төсөлд “МИАТ” ТӨХК-ийн 49 хүртэлх хувийг хувьчлах асуудлыг 2020 оноос судлан шийдвэрлэх зорилт тусгасан бөгөөд УИХ-д өргөн мэдүүлсэн уг асуудлыг 2019.05.17-ны өдөр Засгийн газар буцаан татсан. | 70% |
| 52 | | 8.Говь-Алтай аймгийн “Алтай” нисэх буудлын хөөрч буух хатуу хучилттай | 2016-2017 | Улсын төсөв | 500,0 | Бүрэн ашиглалтад орох 2017 | 500,0<br>2017 онд зарцуулсан | **АТБХЗХ:** “Заабар” ХХК нь Говь-Алтай аймгийн “Алтай” нисэх буудлын хөөрч, буух хайрган болон хатуу хучилттай зурвас, явгалах зам, агаарын хөлгийн зогсоол, үерийн далан барих ИНЕГ.ТББ/БУ-55-07 гэрээт ажлын 2900х30м хатуу хучилттай зурвас, 2300х35м хайрган хучилттай зурвас, 635х15м хайрган болон хатуу хучилттай явгалах замууд, 120м*85м бетонон перрон талбай, 3620у/м үерийн усны хамгаалалтын далан шуудуу барих ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн. Зам, тээврийн хөгжлийн төв | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зурвас, үерийн далан байгуулах | | | | | 492,1 сая төг төсөвт сууснаас 483,3 сая | 2016.10.19-ний өдөр техник ашиглалтын түвшин тогтоох ажлыг гүйцэтгэсэн. “Аварга зам” ХХК-аас ирүүлсэн 2016.10.28-ны өдрийн зохиогчийн хяналтын дүгнэлтийн дагуу Техникийн хяналтын багийн өргөтгөсөн хуралдааныг хийж, Улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэл ажлын хүрээнд 2016.11.18-ны өдөр ИНЕГ-ын даргын А/790 дугээр тушаалаар техникийн комиссыг томилсон. Улсын комисс 2016.12.22-25-ны өдрүүдэд ажиллаж, 2016.12. 28-ны өдрийн 7/23/2016 дугаар Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын актаар улсын ашиглалтад хүлээж авсан. 2017.06.11-ний өдрөөс орон нутгийн нислэгт ашиглаж эхэлсэн. | |
| 53 | | 9.Завхан аймгийн “Доной” нисэх буудлын хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далан байгуулах | 2016-2017 | Улсын төсөв | 2 000,0 | Бүрэн ашиглал-тад орох 2017 | 2 000,0<br><br>2017 онд 344,9 сая төг төсөвт сууснаас 0<br><br>2018 онд зарцуул-сан | **АТБХЗХ:** Завхан аймаг дахь Доной нисэх буудалд хийгдэж буй хөөрч буух хучилттай зурвасын ажлыг гүйцэтгэгч “Хурдны зам” ХХК-ийн ИНЕГ.ТББ/БУ-56-07 дугаар бүхий гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Нисэх буудлын хөөрч буух хатуу хучилттай зурвасыг үргэлжлүүлэн барихад шаардлагатай 2 тэрбум төгрөгийн зардлыг “ИНЕГ-ын 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт”-д тусган ЗТХС-ын 2017 оны 137 дугаар тушаалаар баталсан.<br>Гүйцэтгэгч “Хурдны зам” ХХК-тай байгуулсан ИНЕГ/ТББ/БУ-56-07 тоот гэрээнд 2017.07.05-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулсан. Завхан аймгийн Доной нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвасын ажлын талаар ИНЕГ-ын даргын зөвлөлийн 2018.05.10-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн, гэрээт ажлыг “Хурдны зам” ХХК-аар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн. 2018.05.31-ний өдөр “Хурдны зам” ХХК-тай нэмэлт гэрээ байгуулж, гэрээний дагуу 2018.06.11-10.01-ний өдрүүдэд “Доной” нисэх буудлын аэродромын БУА-ыг гүйцэтгэж, Улсын комисст хүлээлгэн өгөхөөр болсон. Гүйцэтгэгч тал нисэх буудлын аэродромын барилга угсралтын ажлыг гэрээний хугацаанд ашиглалтад хүлээлгэн өгөөгүй тул "Хурдны зам" ХХК-тай 2018.04.01-ний өдөр нэмэлт гэрээг байгуулсан. Гэрээгээр барилга угсралтын ажлыг 2019.07.30-ны өдөр хүлээлгэн өгөхөөр тохиролцсон. "Хурдны зам" ХХК-д банкны урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн 2019.04.29-ний өдөр 799,021,025 төгрөгийн санхүүжилтийг олгосон.<br>Доной нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас барилгын ажил дууссан. ТНБД-ын 2019.08.01-ний өдрийн 247 дугаар тушаалаар Завхан-Доной нисэх буудлын хөөрөх, буух хатуу хучилттай зурваст улсын комисс ажиллаж ашиглалтад авсан. | 100% |
| 54 | | 10.Ховд аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин | 2017-2020 | Гадаад эх үүсвэр | 50 000,0 | Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь | 30,000.0 | **АТБХЗХ:** ЗТХС-ын 2017.07.04-ний өдрийн 137 дугаар тушаалаар батлагдсан “ИНЕГ-ын 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт”-д Ховд аймаг дахь нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга байгууламжийн зураг төсөв хийхэд 60 сая төгрөг, мөн нисэх буудлын аэродромын өргөтгөлийн зураг төслийг шинэчлэхэд 26 сая төгрөгийг тусгуулсан.<br>Нисэх буудлын аэродромын өргөтгөлийн зураг төсвийг шинэчлэхээр “ЭЗТ” ХХК-тай 2017.10.19-ний өдөр ИНЕГ/ЦА/ТББ/ЗҮ-12/17 дугаар гэрээ | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | чадалтай болгох | | | | | | байгуулсан. “ЭЗТ” ХХК-нь гэрээний дагуу аэродромын өргөтгөлийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж дуусган захиалагч талд хүлээлгэн өгсөн.<br>Зорчигч үйлчилгээний барилга байгууламжийн зураг төслийг “Алтайн газрын хүч” ХХК гүйцэтгэж дуусган ИНЕГ-т хүлээлгэн өгсөн. Зураг төслийг экспертизээр батлуулахаар Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн.<br>Нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, аэродромыг 4С болгох ажлыг гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд **санхүүжилтийг эрэлхийлэх ажлыг хийж байгаа боловч амжилтгүй** байна.<br>/2020-2024 онд концессын гэрээ, гадаадын зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт зэргээр санхүүжилтийн боломжтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэхээр тусгаж, он дамжуулж санхүүжүүлэх замаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. | |
| 55 | | 11.Дорнод аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай болгох | 2017-2020 | Гадаад эх үүсвэр | 40 000,0 | Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь | 20,000.0 | **АТБХЗХ:** Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, 4С болгох зураг төсөл хийлгэхэд 250 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай бөгөөд ИНЕГ-ын 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг төслийн санхүүжилтыг тусгуулахаар саналыг ИНЕГ-ын Худалдан авах ажиллагааны хэлтэст хүргүүлсэн.<br>БНПУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийн төсөлд буудлын өргөтгөлийн ажлыг тусгуулах саналыг ЗТХС-ын 2016.05.04-ний өдрийн 01/1883 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Тус нисэх буудлыг өргөтгөх зураг төсөв боловсруулах зардал, барилгын ажлын санхүүжилтийг БНСУ-ын “Эксим” банкны зээлээр санхүүжүүлэхээр санал боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Дорнод аймгийн нисэх буудлыг Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын стандарт шаардлагыг хангасан 4С зэрэглэл бүхий агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром болгох ажлын санхүүжилтыг шийдвэрлүүлэхээр 2018.01.27-ны өдөр Олон Улсын Хөгжлийн банкинд танилцуулсан. 2018.08 дугаар сард тус банкнаас дэмжих боломжгүйгээ мэдэгдсэн. Дорнод аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай болгох төслийн **санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр бүхий л боломжит нөхцлийг эрэлхийлэн ажиллаж байна.** Европын хөрөнгө оруулалтын банк болон Азийн хөгжлийн банкны холбогдох албан хаагчид 2018. 09 дүгээр сард тус яамны удирдлагуудтай уулзалт хийж, санхүүжүүлэх боломжтой төсөл хөтөлбөрийн судалгаа хийсэн. Уг уулзалтуудад Дорнод аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай болгох төслийг танилцуулсан.<br>Тус нисэх буудлын аэродромын зураг, төслийг боловсруулах ажлыг ИНЕГ-ын 2011-2016 оны үйл ажиллагааны үр дүнд бий болсон цэвэр ашгийн хэмнэлтээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад оруулсан. Олон улсын зээл тусламжаар тус буудлыг нөөц нисэх буудал болгох төслийн саналыг ИНЕГ-аас 2018.08.03-ны өдрийн 02/2544 тоот албан бичгээр ирүүлээд байна. | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 56 | | | | | | | | ЗТХС, Сангийн сайдын хамтарсан 2018.12.31-ний өдрийн 305/313 дугаар тушаалаар Дорнод аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай болгох ажилд ИНЕГ-ын 2019 оны өөрийн орлогоос 1 тэрбум төгрөг санхүүжүүлэхээр баталсан. Улмаар Иргэний нисэхийн ерөнхий газар болон "Некстстеп инженеринг" ХХК хооронд "Зорчигч үйлчилгээний цогцолборыг цагт 300 зорчигчид үйлчлэх хүчин чадалтай болгон өргөтгөх болон бусад инженерингийн барилга байгууламжуудын ажлын зураг төсөл, төсвийг /Дорнод/ хийж гүйцэтгэх ИНЕГ/ХО/ТББ/ЗҮ-07/19 дугаар гэрээг 2019.10.25-ны өдөр байгуулаад байна. Гэрээт ажлын явц 30%-тай байна. | - |
| 56 | | 12.Өмнөговь аймаг дахь нисэх буудлыг 4D ангиллын, олон улсын нөөц нисэх буудал болгох | 2017-2020 | Гадаад эх үүсвэр | 300 000,0 | Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь | 148,000.0 | **АТБХЗХ:** ЗТХС-ын 2017.07.04-ний өдрийн 137 дугаар тушаалаар батлагдсан “ИНЕГ-ын 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт”-д Өмнөговь аймаг дахь нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад 60 сая төгрөг тусгасан. Зураг төсвийг хийх компаниудын дэлгэрэнгүй жагсаалтыг 2017.10.20-нд гаргасан. 2017.11.15-нд хураангуй жагсаалт гаргаж, тендерийн саналын урилга, ажлын даалгаврыг тендерт оролцогчдод хүргүүлсэн. 2017.12. 15-ны өдөр тендер нээсэн. Тендерт “Алтайн газрын хүч" ХХК шалгарч ИНЕГ ИНЕГ тус компанитай /ЦА/ТББ/ЗҮ-13/17 дугаар гэрээг байгуулсан. Зураг төсөв боловсруулах ажил 80%-тай байна.<br>Нисэх буудлыг 4D ангиллын, олон улсын нөөц нисэх буудал болгох Зам,тээврийн хөгжлийн сайдын 2 дугаар сарын 01-ний өдрийн 35 дугаар тушаалаар батлуулсан “ИНЕГ-ын 2011, 2013, 2015, 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн зарцуулагдаагүй үлдэгдэл хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-д тус нисэх буудлыг 4D ангиллын нисэх буудал болгох, өртгөтгөх зураг, төсөв боловсруулахад 300.0 сая төгрөгийг тусгасан. Улмаар Иргэний нисэхийн ерөнхий газар болон “ЭЗТ” ХХК хооронд “Өмнөговь аймгийн Гурвансайхан нисэх буудлыг 4D ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадал бүхий нисэх буудал болгох, өргөтгөх зураг, төсөл боловсруулах” ИНЕГ/ХО/ТББ/ЗҮ-09/19 дугаар гэрээг 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. Зураг төсөл боловсруулах ажлын явц 40%-тай байна.<br>Нисэх буудлыг өргөтгөн шинэчилэх ажлыг гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд **санхүүжилтийг эрэлхийлэх ажлыг хийж байгаа боловч амжилтгүй байна.** /2020-2024 онд концессын гэрээ, гадаадын зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт зэргээр санхүүжилтийн боломжтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэхээр тусгаж, он дамжуулж санхүүжүүлэх замаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. | - |
| 57 | | 13.Хэнтий аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг | 2017-2019 | Гадаад эх үүсвэр | 4 900,0 | 3С ангиллын агаарын хөлөг хүлээн авах | 3,087.0 | **АТБХЗХ:** Арабын Нэгдсэн Эмират Улсын Кувейтын хөгжлийн сангаас буцалтгүй тусламжаар баригдах хатуу хучилттай зурвас болон терминалын барилгын зураг төслийн тендерийг Хэнтий аймгийн ЗДТГ-аас зарлаж, ”Ростов” компани шалгарч, ТЭЗҮ, зураг төслийг 2017.02 сард боловсруулж дууссан бөгөөд англи хэл рүү хөрвүүлсэн. | 40% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хүлээн авах 3С хүчин чадалтай болгох | | | | боломжтой болох | | Аэродромын зураг төсвийг 2017.01.31, барилгын зураг төсвийг 2017.02.14-ний өдөр улсын экспертизээр батлуулж, Хэнтий аймгийн Засаг дарга Н.Ганбямбад 2017.02.15-ны өдөр хүлээлгэн өгсөн. Баримт бичгийг 2017.04.12-ны өдөр Кувейтын талд хүргүүлсэн.<br>“Өндөрхаан нисэх буудал”-ын хөөрч, буух шороон зурвас, явгалах зам, зорчигч үйлчилгээний болон бусад инженерингийн барилга байгууламж, аэродромын хашаа хамгаалалтын ажлыг 3.5 сая ам долларт багтаасан төсвийг 2018.05.09-ны 03/2106 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Ерөнхий сайдын 2018.07.04-ний өдрийн 131 дугаар захирамжаар “Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор “Кувейт Улсаас Монгол Улсад буцалтгүй тусламж олгох тухай Монгол Улсын Засгийн газар, Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сан хоорондын 2007.04.24-ний өдрийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Монгол Улсаас Кувейт Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд З.Чинтүшигт олгосон. Төслийг хэрэгжүүлэх буцалтгүй тусламжийн хэлэлцээрт 2018.07.18-ны өдөр гарын үсэг зурсан.<br>Сангийн сайд, ЗТХ-ийн сайдын хамтарсан 2018.10.24-ний өдрийн 249/233 дугаар тушаалаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц орон тоог баталсан.<br>ЗТХСайдын 2019.01.11-ний өдрийн 13 дугаар тушаалаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтныг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулагдсан. ТХН-ийн ажилтнуудын сонгон шалгаруулалтыг явуулж, Төслийн зохицуулагч, Аэродромын инженер, Санхүүгийн ажилтнуудыг холбогдох гэрээг байгуулан ажиллуулж байна. ТХН-ийн ажлын даалгаврыг холбогдох журамд нийцүүлэн боловсруулсан. Төслийн удирдах хороог ЗТХСайдын 2019.06.05-ны өдрийн 177 дугаар тушаалаар байгуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 05 дугаар сарын 02-ны “Ажлын хэсэг байгуулах тухай” 151 дүгээр тушаал /2019.05.31-ний 191 дүгээр тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон/-аар үнэлгээний хороог байгуулж, барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2 Багц /1.Барилга 2.Аэродром/ болгон 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдөр зарласан. Тендерийг 2019.09.05-ны өдрийн 10.00 цагт нээхээр байсныг Дадалын сумын “Дэлүүн болдог” нисэх буудлын хөрөнгийн эх үүсвэрийн талаарх Кувейт Улсын Элчин сайдтай хийх уулзалтаас шалтгаалан тодорхойгүй хугацаагаар түр хойшлуулж, үргэжлүүлэн явуулсан.<br>Тендерийг 2019.09.18-ны өдөр нээсэн боловч 1-р багц буюу барилгын ажлын тендерт 1 ч оролцогч оролцоогүй тул үнэлгээний хороо шалтгаан нөхцөлийг судалж тендерийг дахин зарлахаар ажиллаж байна. Харин 2-р багц буюу аэродромын ажлын тендерт оролцогчоос ШӨХТГ-т гомдол ирүүлсэн байсан тул тендерийг түр зогсоосон. | |
| 58 | | 14.Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх буудлыг | 2017 | Улсын төсөв | 42 800,0 | Олон улсын шинэ нисэх | 42 800,0 | **АТБХЗХ:**<br>МУ-ын ЗГ болон Японы Олон улсын хамтын ажиллагааны банк хооронд 2008.05.01-ний өдөр 28,8 тэрбум иенийн үнийн дүнтэй MON-P8 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | барьж дуусган ашиглалтад оруулах | | | | буудлыг ашиглаж эхлэх 2017 | 2017 онд зарцуул-сан<br><br>14 376,3 төсөвт сууснаас 8 105,1 сая төг<br><br>2018 онд зарцуул-сан 40,862.6 сая төгрөг, | “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төслийн зээлийн үндсэн гэрээ”,<br>2015.04.16-ны өдөр 36,8 тэрбум иенийн үнийн дүнтэй MON-P12 “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төслийн зээлийн нэмэлт гэрээ”-г тус тус байгуулсан.<br>ИНЕГ болон ЯУ-ын “Мицүбиши-Чиёода” хамтарсан түншлэл хооронд 2013.05.10-ны өдөр байгуулсан “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн барилгын ажлыг гүйцэтгэх гэрээ” байгуулсан.<br>“Ви Эйч энд Би” ХХК, “Есүй ордон” ХХК-ийн түншлэл Зам, тээврийн яамтай /хуучин нэрээр/ 2016.04.27-ны өдөр 113/14 тоот гэрээ, 2017.02.15-ны өдөр 29 тоот нэмэлт гэрээг тус тус байгуулсан боловч урьдчилгаа санхүүжилт болон гүйцэтгэлийн санхүүжилтийг цаг тухайд нь олгоогүйн улмаас гэрээт хугацаанд ажлыг бүрэн дуусгах боломжгүй болсон.<br>ЗТХЯ-наас гүйцэтгэгчийн гэрээг дүгнэсний үндсэн дээр гэрээг сунгахаар шийдвэрлэж 2017.12.28-ны өдөр 326 дугаартай нэмэлт гэрээг байгуулж хугацааг 2018.08.31-ний өдрийг хүртэл сунгасан.<br>1. 2017 онд “Улаанбаатар хотын Олон Улсын нисэх онгоцны шинэ буудал барих барилгын ажлын гэрээ”-ний хүрээнд баригдсан барилга, байгууламжуудад Улсын комисс ажиллуулж ашиглалтад хүлээн авсан.<br>2. 2018 онд “Улаанбаатар хотын Олон Улсын нисэх онгоцны шинэ буудал барих барилгын ажлын гэрээ”-ний нэмэлт өөрчлөлт №1-ийн хүрээнд баригдсан нэмэлт барилга, байгууламжуудад Улсын комисс ажиллуулж ашиглалтад хүлээн авсан.<br>3. Захиргааны барилгыг ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж барилгыг ашиглалтад хүлээн авсан.<br>4. Аэродромын засвар үйлчилгээний барилга болон Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилгад техникийн комисс 2019.09.07-ны өдөр ажилласан. Улсын комиссыг энэ ондоо батгаан ажиллуулахаар ажиллаж байна.<br>5. Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгын ажлын гүйцэтгэл 85%-тай байна.<br>Засгийн газрын “Монгол-Японы хамтарсан компани байгуулах тухай” 2019.06.28-ны өдрийн 261 дүгээр тогтоолоор байгуулсан “Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” хязгаарлагдмал хариуцлагатай компани, Үндэсний хөгжлийн газар хооронд “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцын шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээг 2019.07.05-ны өдөр үзэглэсэн.<br>Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төслийн концессын гэрээ 2019.09.01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон. Концессын гэрээнд заасны дагуу Шинэ нисэх буудлын үйл ажиллагааг концессын гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 10 сарын дараа ашиглалтад оруулна. | |
| 59 | | 15.Чингис Хаан ОУНБ- | 2017-2018 | Улсын төсөв, | 211 000,0 | | 27 000,0 | **АТБХЗХ:** ЗТХС-ын 2016 оны 70 дугаар тушаалаар баталсан ИНЕГ-ын бүтцэд Олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах бэлтгэл | - |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ын үйл ажиллагааг шинэ нисэх буудалд шилжүүлэх, шинэ нисэх буудлын үйл ажиллагааг тогторжуулах | | гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | | Олон улсын шинэ нисэх буудлын үйл ажилла-гааг тогтвор-жуулах | | ажлыг хангах ашиглалтын өмнөх захиргааны албыг байгуулсан. Ашиглалтын өмнөх захиргааны алба нь "Чингис Хаан" ОУНБ-ыг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг Японы консорциумтай хамтран шинэчлэн боловсруулж, ЗТХЯ-ны ТНБД-аар ахлуулсан ажлын хэсэгт 2017.01.23-ны өдөр танилцуулсан. Шинэ нисэх буудлын үйл ажиллагааг эрхлэн явуулах компанийн үйл ажиллагаанд шаардлагатай эхлэлтийн хөрөнгө оруулалт, "Чингис хаан" Олон улсын нисэх буудал болон Газрын тусгай үйлчилгээний албанаас шилжиж ирэх хөрөнгийн жагсаалтыг гарган, ИНЕГ-ын удирдлагуудад танилцуулсан. ИНЕГ-ын даргын 2017 оны А/202 дугаар тушаалаар хил, гааль, агаарын тээвэрлэгч болон бусад холбогдох байгууллагуудын оролцоотой нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах, хамтран зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.<br>Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудал ашиглалтад орсноор дотоодын 3 агаарын тээвэрлэгч, гадаадын 5 агаарын тээвэрлэгч, төрийн тусгай чиг үүргийн 6 байгууллага, ИНЕГ-ын харьяа 6 байгууллага, нийт 20 байгууллага нүүлгэн шилжүүлэлт хийнэ. 2018.01.17-ны өдрийн байдлаар дээрх 8 агаарын тээвэрлэгч байгууллага, 6 төрийн болон хилийн хяналтын байгууллагууд, 3 навигацийн үйлчилгээний нийт 17 байгууллагууд нүүлгэн шилжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг баталгаажуулж ирүүлээд байна. Шинэ нисэх буудалд үйл ажиллагаа явуулах 20 байгууллагын нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг нэгтгэн баталгаажуулж, ИНЕГ-ын тэргүүн дэд даргаар батлуулсан.<br>Нисэх буудлыг нүүлгэн шилжүүлэх нэгдсэн төлөвлөгөөнд 4 бүлэг 159 зүйл ажил багтсан. Үүнээс нисэх буудалд үйл ажиллагаа явуулах байгууллагуудтай гэрээ байгуулах, зай талбай, өрөө тасалгааны хуваарилалтыг баталгаажуулах, үйл ажиллагаа эхлэхэд шаардлагатай худалдан авалт хийх зэрэг тусгай зориулалт оператор компанитай шууд хамааралтай 130 ажил буюу нэгдсэн төлөвлөгөөний 86%-ийг эзэлж байна. "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдийн монголын талд ногдох 49 хувийг эзэмших төрийн өмчит компани байгуулах асуудлыг Засгийн газрын 2018.05.02-ны өдрийн хуралдаанд танилцуулсны дагуу компани байгуулахтай холбогдох тооцоо судалгаа бэлтгэх, шинээр байгуулах компанийн нэрийг тодруулах чиглэл өгсөн. Холбогдох чиглэлийн дагуу компани байгуулах асуудлыг Засгийн газрын 2018.05.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, "Улаанбаатар хотын Олон Улсын нисэх онгоцны шинэ буудлын талаар авах зарим арга хэмжээний тухай" 150 дугаар тогтоолоор монголын талд ногдох 49 хувийг "Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид эзэмшүүлэхээр тогтсон. Тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.06.26-ны өдрийн "Төрийн өмчийн төлөөлөгч томилж, удирдамж батлах тухай" 139 дүгээр тушаал, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2018.06.27-ны өдрийн "Төрийн өмчийн төлөөлөгч томилж, удирдамж | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | батлах тухай” а/203 дугаар тушаалаар Хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг хэрэгжүүлэх албан тушаалтнуудыг томилж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018.06. 28-ны өдөр хийж, компанийн дүрмийг батлаад байна.<br>Нисэх буудлын оператор компани байгуулагдах хугацаа удаа дараа хойшилж байгаатай холбогдон тус төлөвлөгөөний биелэлт удаашралтай байна.<br>Буянт-Ухаа дахь “Чингис хаан” ОУНБ-ын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг нүүлгэн шилжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг ИНЕГ-ын даргын 2019 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А/344 тоот тушаалаар шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгээс “Нүүлгэн шилжүүлэлтийн нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. **Шинэ нисэх буудлын үйл ажиллагааг концессын гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 10 сарын дараа ашиглалтад оруулахаар хэлэлцээ хийгдсэн.** | |
| 60 | | 16. Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежментийг концессын гэрээгээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | 2016-2017 | - | - | Менежментийг гүйцэт-гүүлж эхлэх 2017 | - | **АТБХЗХ, БТГ:** ЕС-ын 2016 оны 63 дугаар захирамжаар байгуулагдсан “УБ хотын ОУНОШБ-ын менежмент төсөл”-ийг санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг, Японы консорциумтай концессын гэрээний хэлэлцээг 2017.01.30-ны өдөр эхлүүлсэн. Ажлын хэсэг дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>Ажлын хэсэг Японы Консорциумын төлөөлөлтэй удаа дараа уулзалт зохион байгуулж, гэрээний хэлэлцээний дараагийн шатанд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, талууд хэлэлцээрийг түргэвчлэх талаар анхаарч, хамтран ажиллах тухай харилцан тохиролцсон.<br>Монгол болон Японы талууд гэрээний хэлэлцээг саадгүй явуулахын тулд харилцан тохиролцох шаардлагатай асуудлуудыг хэлэлцэж эхлэлтийн хөрөнгө оруулалтын тооцоо судалгааг боловсруулсан. Төслийн саналын техникийн болон санхүүгийн үнэлгээг нэгтгэн дүгнэж, шаардлага хангасан гэж үзсэн тухайгаа Мицубиши корпорацид албан бичгээр хүргүүлсэн;<br>Японы Консорциумын хүсэлтээр Ажлын хэсэг “Хүннү эйр” ХХК болон “Аэромонголиа” ХХК-ийн удирдлагуудтай 2017.02.23-ны өдөр шинэ нисэх буудалд шилжин ажиллах бэлтгэл ажлын талаар хэлэлцсэн. Японы Консорциумын хамтаар дотоодын агаарын тээвэрлэгчидтэй шинэ нисэх буудалд шилжин ажиллах бэлтгэл ажлын талаар 2017.03.28-29-ний өдрүүдэд уулзалт зохион байгуулж, тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэв.<br>Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэхэд тулгамдаж буй асуудлууд болон шинэ нисэх буудлын үйл ажиллагааг Японы Консорциумтай хамтран хэрэгжүүлснээр үүсч болох эрсдэлүүд зэрэг асуудлуудыг тусгасан ажлын хэсгийн тайланг 2017.04.29-ний өдөр Ерөнхий сайдад танилцуулсан.<br>Японы Консорциум Монголын тал болон Японы талын эзэмших хувь хэмжээг нарийвчлан тооцоолсон нэмэлт хувилбаруудыг боловсруулсан.<br>Японы Консорциум дэх Мицубиши Корпорацын санхүү хөрөнгө оруулалт хариуцсан төлөөлөгч, ИНЕГ болон ЗТХЯ-ны төлөөлөлтэй 2017.09.04-08- | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ны өдрүүдэд ажиллаж, МУ зээлийг эргэн төлөх санхүүгийн тооцоо судалгаа, Монгол, Япон талууд ямар хувь хэмжээгээр хөрөнгө оруулснаар эргэн төлөлтийг барагдуулах талаар тооцооллыг нягталж, ЗТХЯ-ны ТНБД-д танилцуулсан.<br>“УБ хотын ОУНОШБ-ын менежмент төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэх санал тавьсан Японы талын түншлэлийн төлөөлөлтэй ЗТХС 2017.08.15-ны өдөр уулзаж, шинэ нисэх буудлын барилга байгууламж, бэлтгэл ажлын явц болон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар санал солилцсон.<br>Японы талын түншлэл, ЗТХЯ, ИНЕГ, Төсөл хэрэгжүүлэх нэгж, ИНЕГ-ын Ашиглалтын өмнөх захиргааны албаны төлөөллийг оролцуулсан хамтарсан уулзалтыг 2017.09.04-07-ны өдрүүдэд зохион байгуулж, “УБ хотын ОУНОШБ-ын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх санхүүгийн саналын төслийг хэлэлцэж, хувилбар тус бүрийн сул, давуу тал, тайлбар, судалгааг хийсэн. “УБ хотын ОУНОШБ-ын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээд байгуулах, хувь эзэмшлийг тогтоох талаар ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Ажлын хэсэг менежментийн төслийг хэрэгжүүлэх санал тавьсан этгээдтэй уулзалт, хэлэлцээ хийж Монгол, Япон талуудын эзэмших хувь болон хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг хэрхэн барагдуулах тооцооллыг хэлэлцсэн. Хэлэлцээний үр дүнд талууд 33 жилийн хугацаатайгаар Монголын тал 49, Японы тал 51 хувиар тус тус хувиар концесс эзэмших хувилбарыг сонгон ЗГХЭГ-т 2017.11.16-ны 01/5025 тоот албан бичгээр бичгээр хүргүүлж, ЗГ-ын 2017.11.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжүүлсэн.<br>МУЗГ-ын 2018.01.10-ны өдрийн хуралдаанаар шинэ нисэх буудлын менежмент төслийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулахаар хийж байгаа хэлэлцээний явцын талаар танилцуулсан. Монголын талын 49%-г эзэмших Чингис хаан Олон улсын нисэх буудлын статусыг өөрчлөн зохион байгуулах, менежмент хийх компанийн удирдлага зохион байгуулалттай холбоотой Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газрын 2018.05.02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЗГ-аас холбогдох тооцоо судалгааг бэлтгэх, шинээр байгуулах компанийн нэрийг тодруулах чиглэл өгч материалыг буцаасан. Шаардлагатай тооцоо, мэдээллийг тодорхой болгож, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр дахин хүргүүлсэн. Засгийн газрын 2018.05.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн ЗГ-ын 150 дугаар тогтоолоор баталсан.<br>Тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗТХС-ын 2018.06.26-ны өдрийн “Төрийн өмчийн төлөөлөгч томилж, удирдамж батлах тухай” 139 дүгээр тушаал, ТӨБЗГ-ын даргын 2018.06. 27-ны өдрийн “Төрийн өмчийн төлөөлөгч томилж, удирдамж батлах тухай” а/203 дугаар тушаалаар Хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг хэрэгжүүлэх албан тушаалтнуудыг томилж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018.06.28-ны өдөр хийж, компанийн дүрмийг баталсан. Компанийг 2018.07.08-ны өдөр улсын | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээг авсан. 2018.07.09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн бүтэц, энэ оны төсвөө баталсан.<br>ЕС-ын 2018.05.21-ний өдрийн 102 дугаар захирамжаар “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэхээр санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, хавсралтаар Ажлын хэсгийн удирдамжийг батлуулсан.<br>Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Японы консорциумтай 2018.05.24, 25-нд Концессын зүйлийн жагсаалт, 2018.06.08, 06.13-нд Концессын гэрээний санхүүгийн загвар, 2018.06.11- 2018.06.14 Концессын зүйлийн захиргаа удирдлагын нарийвчилсан хуваарилалт, Хувьцаа эзэмшигчдийн гэрээний талаар хэлэлцээг хийсэн.<br>Мөн Монголын талын 49 хувийг эзэмшигч “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХК болон Японы консорциум хооронд хамтран ажиллах түншлэлийн гэрээг байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.<br>Монголын талаас концессын гэрээний төслийг эхний байдлаар боловсруулан Японы консорциумд 2018.07.17-ны өдөр хүргүүлсэн. Японы консорциумаас уг концессын гэрээний төсөлтэй холбогдуулан 2018.07.10-ны өдөр албан бичгээр 6/Санхүүгийн загвар, газрын үйлчилгээ, аюулгүй байдал, газрын асуудал, гэрээний хэл, хувьцаа шилжүүлэх хязгаарлалт/ асуудлыг шийдвэрлүүлэхээр ирүүлснийг санхүүгийн болон хуулийн зөвлөхийн саналыг үндэслэн хянан үзэж холбогдох хариуг 2018.08.15-ны өдрийн 03/3872 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн 2018.08.08-ны өдөр Японы консорциумаас концессын гэрээний төсөлтэй холбогдуулан дахин 12/Нэр томьёоны тодорхойлолт, гэрээний талууд, талуудын хүлээх үүрэг, гэрээ хүчинтэй болох болон түүний урьдчилсан нөхцөл, концессын зүйлийг буцаан шилжүүлэх төлөвлөгөө, концессын төлбөр, концесс эзэмшигчийн гүйцэтгэлд хяналт дүгнэлт хийх, онцгой байдал, хувьцаа шилжүүлэх, эрх бүхий этгээдийн зөвшөөрөл, арилжааны боломжийг ашиглах, гэрээг хэрэгжүүлээгүй, зөрчсөн үеийн хохирлыг барагдуулах, маргаан шийдвэрлэх, гэрээний хэл/ асуудлыг шийдвэрлүүлэхээр ирүүлснийг хянан үзэж холбогдох хариуг 2018.09.11-ний өдрийн 03/4394 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>ЗГ-ын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын шатахуун хангамжийн байгууламжийн менежмент төсөл”-ийг “ашиглах-шилжүүлэх” төрлөөр нэмэлтээр оруулах саналыг 2018.06.15-ны өдрийн 01/2842 тоот албан бичгээр ҮХГ-т хүргүүлсэн.<br>Концессын гэрээний хэлэлцээрийг 2018.05.21-ний өдрөөс эхлүүлсэн бөгөөд Япон талаас ирүүлсэн гэрээний төсөлд саналаа тусган богино хугацаанд япон талтай хэлэлцээ хийж дуусгахаар ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Япон талаас 12 дугаар сард багтаан Концессын гэрээг байгуулах боломжгүй гэдгээ мэдэгдсэн тул МУ-ын ЕС-ын 12 дугаар сард Япон улсад хийх айлчлалын үеэр талууд хамтарсан мэдэгдэл хийгээд байна.. Концессын гэрээг байгуулах ажлыг түргэвчлэх зорилгоор | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дэд ажлын хэсгүүд томилогдож, японы талтай хэлэлцээ хийж байна. Түншлэлийн гэрээ байгуулсан.<br>"Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэхээр санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг 2018 оны 6 дугаар сараас өнөөдрийг хүртэл концессын гэрээний 9 багц хэлэлцээг хийгээд байна.<br>Концессын гэрээний хэлэлцээний явцын талаар 2019.03.21-ний өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд Ерөнхий сайдын 2018 оны 102 дугаар захирамжид холбогдох өөрчлөлтийг оруулахаар ЗГХЭГ-т хүргүүлсэн./2019.04.02-ны өдрийн 01/1501 тоот/<br>Хэлэлцээрийн төслийг эцэслэж дууссан бөгөөд 2019.07.05-ны өдөр Концессын гэрээнд гарын үсэг зурах ажлыг төлөвлөөд байна.Улмаар Ерөнхий сайдын 2019 оны 43 дугаар захирамжаар Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон удирдамжийг шинэчлэн баталсан. Ажлын хэсэг концессын гэрээний хэлэлцээг хийж дууссан бөгөөд Концессын гэрээний төсөлд тохиролцсон голлох нөхцөлүүдийн талаар Засгийн газрын 2019.06.05-ны өдрийн хуралдаанд танилцуулан дэмжүүлсэн. Тус хуралдаанаар "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэхээр санал тавьсан этгээдтэй байгуулах концессын гэрээний төслийг эцэслэн боловсруулж, гэрээ байгуулах эрх олгох тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Үндэсний хөгжлийн газарт даалгасан. "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэх концессын гэрээний төсөл, ажлын хэсгийн дүгнэлт, Засгийн газрын тогтоолын төслийг Үндэсний хөгжлийн газарт 2019.06.18-ны өдрийн 01/3177 тоот албан бичгээр хүргүүлсэн. Концессын гэрээг 2019.07.05-ны өдөр байгуулсан бөгөөд гэрээ 2019.09.01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон.<br>"Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол-Японы хамтарсан төрийн өмчийн 49 (дөчин есөн) хувийн оролцоотой хамтарсан компани байгуулах асуудлыг 2019.06.28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, "Монгол-Японы хамтарсан компани байгуулах тухай" 261 дүгээр тогтоолоор баталсан. Монгол-Японы хамтарсан "Нью Улаанбаатар Интернэйшнл эйрпорт" ХХК нь үйл ажиллагаагаа явуулж эхлээд байна. | |
| 61 | | 17.Иргэний нисэхийн үйлчилгээнд олон улсын стандарт, аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан | 2016-2020 | Улсын төсөв | 68 000,0 | Техник технологи нэвтрүүлэх чиглэлээр холбогдох шийдвэр гаргуулах | 16,000.0 | **АТБХЗХ:**<br>- Бүсийн нислэгийн хөдөлгөөн удирдлагын төвийг үйл ажиллагаанд ашиглаж эхлэхтэй холбоотойгоор агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмжийн тоноглолын болон агаарын навигацийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нөөц төлөвлөгөөний дагуу хоёрдогч бүсийн нислэгийн хөдөлгөөн удирдлагын төвийн байрны тоноглолын талаарх судалгааг хийсэн.<br>- Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас бүс нутгийн агаарын навигацийг ижил түвшинд хөгжүүлэх зорилгоор боловсруулан гаргасан GANP /Global air navigation plan/ төсөл болон түүнийг хэрэгжүүлэх | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх | | | | | | загварчилсан хөтөлбөр болох ASBU /Air navigation system block upgrade/-ын модулиудыг судлан, үйлдвэрлэгч байгууллагуудын дэвшилтэт техник технологитой уялдуулан Агаарын навигацийг 2018-2020 он хүртэлх хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулж, ИНЕГ-ын даргын 2017.09.05-ны өдрийн А/605 дугаар тушаалаар баталсан.<br>Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоог нэмэгдүүлэх зорилгоор ЗТХС-ын 2017.01.13-ны өдрийн "Агаарын замуудыг шинэчлэн тогтоох тухай" 09 дүгээр тушаалаар МУ-ын агаарын зайн үзүүлэлтэд тулгуурласан навигаци бүхий замуудыг шинэчлэн тогтоож, 2017.03.30-ны өдрөөс нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж эхлээд байна. Үзүүлэлтэд тулгуурласан навигацийг хэрэгжүүлснээр агаарын зайн багтаамжийг нэмэгдүүлэх, агаар газрын холбоо болон ажиглалтын удирдлага ашиглан чиглэл өгөх үйл ажиллагааны хэрэгцээг багасгаж, нисгэх баг болон нислэгийн удирдагчийн ажлын ачааллыг бууруулан нислэгийн аюулгүй ажиллагааг сайжруулах, газрын навигацийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, шалгалтын нислэгийн зардлуудыг багасгах, агаарын тээвэрлэгчдэд түлш хэмнэх боломж олгох зэрэг давуу талуудтай.<br>- Мөн ОХУ-ын нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвд өгөгдөл дамжуулах сүлжээ байгуулах ажлын хүрээнд шаардлагатай туршилт тохируулгын ажлыг хийж дууссан бөгөөд 2017.06.01-ний өдрөөс ашиглаж эхлэв.<br>- Өнгөрөлтийн нислэгийн тоог нэмэгдүүлэх, агаарын навигацийн хураамжийн аргачлалыг боловсронгуй болгох чиглэлээр Агаарын тээвэрлэгчийн олон улсын байгууллагын гишүүн агаарын тээвэрлэгчидтэй зөвлөлдөх уулзалтаар МУ-ын агаарын навигацийн хураамжийг тогтоох шинэчилсэн аргачлалын талаар танилцуулсан бөгөөд уг аргачлалыг 2017.07.01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн. "Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого"-д тусгасан агаарын навигацийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, нисэх буудал, ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, технологийн дэвшлийн талаарх судалгааг урьдчилсан байдлаар гаргаж, ИНЕГ-ын дунд хугцааны /2018-2020 оны/ стратеги төлөвлөгөөний төсөлд тусгасан. Энэхүү стратеги төлөвлөгөө хянагдаж, батлагдах, жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдаж төлөвлөлтийг нарийвчлан гаргахаар ИНЕГ-ын хэмжээнд судалгааны шатанд байна. ЗГ-ын 2018 оны 120 дугаар тогтоолоор батлуулсан "Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг боловсруулах, батлуулах шатанд ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэхэд шаардлагатай сургалт, дадлагын тоног төхөөрөмж, агаарын хөлгийн засвар үйлчилгээний техник, технологийн шинэчлэлтийн талаарх 2022 он хүртэл төлөвлөлт хийгдсэн.<br>Автомат хамааралтай ADS-B системийг ИНЕГ-ын даргын А/322 дугаар тушаалаар 2018.06.21-ний өдрөөс нислэгийн хөдөлгөөний удирдлагын зайчлалд ашиглаж эхэлсэн.<br>Уг системийг ашигласанаар нислэгийн аюулгүй ажиллагаа, үр ашигтай байдал сайжрах бөгөөд агаарын зайн багтаамжийг нэмэгдүүлэх нөхцөл | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бүрдсэн. Мөн нислэгийн хөдөлгөөний удирдлагын автомат системийн програм хангамжид шинэчлэл хийсэн.<br>Бүсийн нислэгийн хөдөлгөөн удирдлагын шинэ байрны агаарын навигацийн үйлчилгээний тоноглол болон нислэгийн хөдөлгөөн удирдлагын автомат системийн техникийн даалгавар, харьцуулсан судалгааны ажлуудыг хийж техникийн тодорхойлолтын төслийг боловсруулсан. Төвийн болон орон нутгийн нисэх буудлуудад хэрэгцээ шаардлагатай аэродромын болон газрын үйлчилгээний техник тоног төхөөрөмжийг авч, парк шинэчлэлт хийх зардлыг “ИНЕГ-ын 2019 оны орлогоос санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт”-д тусгасан. | |
| 62 | 2.115. Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлж, гамшгаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ, иргэний агаарын тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр ашиглана. | 1.“Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг батлуулж хэрэгжүүлэх | 2016-2020 | Улсын төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл | 18 000,0 | Хөтөлбөр хэрэгжиж эхлэх | 6,000.0 | **АТБХЗХ:** Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн судалгаа, тооцоог хийж, төслийг боловсруулан яамдаас санал авч, ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2017.09.21-ний өдрийн 01/4165 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нийцүүлэн дахин боловсруулж, нөхцөл байдлын дүн шинжилгээний хамт ирүүлэх нь зүйтэй гэж үзэж буцаасан.<br>Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд нийцүүлэн дахин боловсруулж, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, ЗТХС-ын 2017.09.21-ний өдрийн 01-4165 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн бөгөөд Засгийн газар шинээр эмхлэгдэн байгуулагдсантай холбогдуулан дахин буцаагдсан.<br>“Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд Сангийн сайдын зөвшөөрлийн дагуу “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар 2018.04.13-ны өдрийн 01/1642 тоот албан бичгээр ХЭГ-т хүргүүлсэн. ЗГ-ын 2018.05.02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, 2018 оны 120 дугаар тогтоолоор батлуулсан.<br>“Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний **төлөвлөгөөний хэрэгжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар 42% тай** хэрэгжиж байна.<br>Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхээр дараах арга хэмжээг аваад байна. Үүнд:<br>1.Бага оврын агаарын хөлөг угсарч үйлдвэрлэх төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд ОХУ-ын Новосибирск хотын “СибНИА” (Сибирийн нисэхийн эрдэм шинжилгээний хүрээн)-гийн зохион бүтээсэн ТВС-2МС агаарын хөлгийг МИАТ ТӨХК-ийн АХЗҮГ-т угсрах ажлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 28-ны 263 дугаар тушаалаар “Төсөл хэрэгжүүлэх ажлын хэсэг” байгуулагдаж, агаарын хөлөг угсарч, үйлдвэрлэх үйлдвэр байгуулах ажлыг зохион байгуулэ байна. Хоёр агаарын хөлгийн их биений их засварын ажил, далавчны бүрлэг болон далавчны хөндийд байрлах түлшний бак бусад хэрэглэлүүдийн засвар, хөл ангийн хүчилсэн эд анги, шпангоутуудыг үл эвдэх сорилын аргаар шалгаж батлагаажуулан, их бие, далавчны будгийн ажил зэргүүдийг | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төлөвлөгөөний дагуу бүрэн хийж дуусгасан. СибНИА хүрээлэнгийн мэргэжилтнүүд агаарын хөлгийн хөдөлгүүр, түүний хяналтын хэрэглэл, нисэгчийн хянах самбарыг шинэчлэн орчин үеийн навигацийн "Garmin" хэрэглэлүүдийг суурилуулж, сэнсний эд ангиудыг угсран гүйцэтгэлийн ажил 98 хувьтай байна. Манай талын агаарын хөлгийн хөдөлгүүр түүний дагалдах эд анги, сэнс түүний эд анги, навигацийн хэрэглэлүүдийн татан авалт нь санхүүжилт хүлээж байна. ОХУ-ын мэргэжилтэнүүд өөрийн агаарын хөлгийг 2019 оны 02 дугээр сарын 13 нд газарт шалган нислэгт гарахад бэлэн болгосон.<br>2. Словени Улсад 2019 оны 02 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд айлчлан Пипистрел компаний SW-121 агаарын хөлөгтэй танилцсан. Улмаар харилцан хамтын ажиллагааг эхлүүлж, Монгол Улсад SW-121 агаарын хөлгийг угсрах бүрэн боломжтойг тус компанийхан илэрхийлээд байна.<br>3. Ерөнхий зориулалтын агаарын хөлгөөр алслагдсан сум, суурин газарт агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бий болгох ажлын ажлын хүрээнд хуучин ашиглагдаж байсан нисэх буудал, хөөрч, буух зурвасын судалгааг гарга,н Цессна-208Б агаарын хөлгөөр нислэг үйлдэх техник, эдийн засгийн тооцоо судалгааг боловсруулсан. | |
| 63 | | 2.Ерөнхий зориулалтын нисэхийн олон улсын стандартыг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх | 2017-2020 | Улсын төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл | 18 000,0 | Дэд бүтцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр хэрэгжих | 6,000.0 | **АТБХЗХ:**<br>ЗГ-ын 2018 оны 120 дугаар тогтоолоор баталсан "Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг "Төлөвлөгөө батлах тухай" ЗТХС-ын 2018.08.09-ний өдрийн 170 дугаар тушаалаар батлуулсан. Төлөвлөгөөнд "Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн 2 дугаар зорилт "Ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийг хөгжүүлэх, нийгэм эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх"-ийн хүрээнд 5 чиглэлээр 9 арга хэмжээ, 5 дугаар зорилт "Бага оврын агаарын хөлгийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээний сүлжээ бий болгох"-ын хүрээнд 4 чиглэлээр 5 арга хэмжээ, 6 дугаар зорилт "Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн шатахуун хангамжийн сүлжээ бий болгох"-ын хүрээнд 2 чиглэлээр 3 арга хэмжээ тус тус 2018-2022 онд хэрэгжүүлэхээр тусган баталгаажуулсан. Төлөвлөгөөний дагуу бага оврын агаарын хөлөг хөөрч буух 56 зурвас барьж байгуулах, сэргээн засварлахаар 1.176 сая төгрөгийг төсөвт тусгасан, зураг төсвийн ажил хийгдэж байна. Орон нутагт шатахуун хангамжийн сүлжээ, зурвас байгуулах газрын байршлыг тогтоох ажлууд хийгдэж байна.<br>Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын Хавсралт 14-ын 2-р хэсгийг орчуулж, хелипортын стандартын төслийг боловсруулж, 2018.11.21-ний өдрийн 01/4044 тоот албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн.<br>Стандарт, хэмжил зүйн газрын иргэний нисэхийн стандарчлалын техникийн хорооны хурлаар стандартын төслийг хэлэлцүүлэхэд бэлэн болсон.<br>ИНЕГ-ын даргын 2019.08.21-ний өдрийн А/677 дугаар тушаалаар Ерөнхий зориулалтын нисэхийн дэд бүтцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг батлуулсан. Дэд хөтөлбөрийг 2020-2021 онуудад хэрэгжүүлэхээр | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | баталсан бөгөөд арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан биелэлтийг ханган ажиллаж байна. | |
| 64 | | 3.Еренхий зориулалтын нисэхэд хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих, бага оврын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хялбаршуулах | 2017-2020 | - | - | Гэрчилгээ жүүлэлт, хяналтын шинэ зохицуулалтыг хэрэгжүүлж эхлэх | - | **АТБХЗХ:** Ерөнхий зориулалтын нисэхэд хувийн хөрөнгө оруулалтыг дэмжих, бага оврын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хялбаршуулах чиглэлээр:<br>1.Эрх зүйн орчны чиглэлээр: Ерөнхий зориулалтын нисэхтэй холбоотой хууль дүрмүүдийн талаар судалгаа, ОХУ-ын ерөнхий зориулалтын нисэхийн эрх зүйн орчны судалгаа, гадаадын орнуудын болон Монгол Улсын агаарын зайн бүтэц, зохион байгуулалтын судалгаа,<br>2.Бусад орны туршлагыг судлах чиглэлээр:<br>Чех Улсын агаарын хөлөг болон түүний сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг компаниудын судалгаа, Ерөнхий зориулалтын агаарын тээвэр хөгжсөн улс орнуудад ерөнхий зориулалтын нисэх тухайн орны эдийн засагт үзүүлж үр нөлөөний талаар судалгаа, гадаадын орнуудад бага оврын агаарын хөлөг болон нисдэг тэргийг иргэний нисэхээс бусад салбарт ашиглаж байгаа талаар судалгаа, ОХУ болон БНХАУ-ын Ерөнхий зориулалтын нисэхийн цаашдын чиг хандлагын талаарх судалгаа<br>3.Бусад:<br>Чингис Хаан" ОУНБ-ын цаашдын ашиглалтын чиг хандлагыг тодорхойлох, нисгэгч бэлтгэх сургалтын төв байгуулах тооцоо, судалгаа, Ерөнхий Зориулалтын нисэхийн зориулалтаар ашиглагдах нислэгийн зурвас, талбайн бүртгэлийн судалгаа, Монгол Улсын аялал жуулчлалын баазуудын байршил, баазуудын ойр байрлалтай аэродромуудын талаарх судалгаа, онцгой байдлын үед болон хөдөө аж ахуй, байгаль орчны салбарт ерөнхий зориулалтын нисэхийг ашиглах боломжийн судалгаа, аялал жуулчлалын салбарт агаарын спортыг хөгжүүлэх боломжийн судалгаа зэрэг Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх бодлого боловсруулах зорилгоор нийт 13 төрлийн судалгаа хийсэн.<br>ЗТХС-ын "Төлөвлөгөө батлах тухай" 2018.08.09-ний өдрийн 170 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд "Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн 1 дүгээр зорилт "Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх эдийн засаг, эрх зүйн орчныг бүрдүүлэх"-ийн хүрээнд ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох үнэмлэхжүүлэх, нислэгийн захиалга, төлөвлөлтийг хялбаршуулах, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний дүрэм журмыг боловсронгуй болгох чиглэлээр 4 арга хэмжээ, ерөнхий зориулалтын агаарын хөлөг авч ашиглах, хувийн хөрөнгө оруулалт хийх эрх зүйн зохицуулалт бүрдүүлэх, татварын дэмжлэг үзүүлэх чиглэлээр 2 арга хэмжээ тусган хэрэгжүүлж байна.<br>Энэ хүрээнд дэлхийн худалдааны байгууллагын "Иргэний агаарын хөлгийн худалдааны хэлэлцээр"-т нэгдэн орох хуулийн төслийг УИХ-ын 2018.10.18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлснээр иргэний нисэхийн агаарын хөлөг, сэлбэгийг гааль, худалдааны татвараас чөлөөлөх зохицуулалт бүрдүүлсэн. | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ИНБД-ийн шинэчлэлийн хүрээнд 50 дүрэм шинээр буюу шинэчлэн боловсруулахаас ерөнхий зориулалтын агаарын тээвэрт хамааралтай 26, 47, 95, 101, 103 104, 105, 106, 108, 109, 140, 145, 148, 149 дүгээр дүрмүүдийг шинээр болон шинэчлэн боловсруулах юм. Үүнээс 26, 47, 101, 104, 105, 106, 149 дүгээр дүрмүүдийг шинэчлэн боловсруулсан боловч ХЗЯ-аас "Иргэний нисэхийн тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалт, "Захиргааны ерөнхий хууль"-ийн холбогдох шаардлагын дагуу ИНД-ийг багцаар нь ЗТХС-ын 1 тушаалаар батлуулж, Улсын бүртгэлд нэг дугаарт бүртгүүлэх гэсэн шаардлага тавьж байгаа бөгөөд нийт 50 дүрмээс одоогийн байдлаар батлуулахад 34 дүрэм бэлэн болсон байна.<br>Чикагогийн конвенцийн Хавсралт 4-ийн бүлэг 16 "Дэлхийн нислэгийн газрын зураг-1:1,000,000"-д тавигдах шаардлагын дагуу **Ил харааны нислэгийн газрын зураг"**-ыг боловсуулсан. Тус зургийг дижитал хэлбэрт шилжүүлэх website (цахим хуудас) –ны техникийн ажлын даалгаварыг боловсруулан үнэлгээний хороонд хүргүүлсэн бөгөөд 2019.05.17-ны өдөр тендер ИНЕГ/ ХО/ТББ/Б-58/19 зарласан.<br>ИНЕГ-ын даргын 2018.10.15-ны А/654 дугаар тушаалаар "Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам"-д хэт хөнгөн агаарын хөлөг хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэхэд нислэгийн зөвшөөрөл олгохгүй байх талаар нэмэлт өөрчлөлт оруулсан. Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх журмын төслийг боловсруулж байна. Төсөлд 5700 кг-аас доош жинтэй агаарын хөлөг хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэхэд нислэгийн зөвшөөрөл олгохгүй байх зохицуулалтыг тусгаж байна. | |
| 65 | | 4.Иргэний нисэхийн багц дүрэмд нийцүүлэн агаарын зайн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох | 2017-2018 | - | - | Агаарын зайн бүтэц зохион байгуулал тад өөрчлөлт оруулах | - | **АТБХЗХ:** "Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх журам"-ын төслийг эцэслэн боловсруулж, хэлэлцүүлгийг 2018.08.17-ны өдөр зохион байгуулсан. Уг хэлэлцүүлэгт ИНЕГ-ын харвяа байгууллага, хэлтсүүд, мэргэжлийн холбоо, нисгэгч нарын төлөөлөл 40 орчим хүмүүс оролцсон. Хэлэлцүүлгээс тусгайлсан журам байх шаардлагагүй гэж үзэн, энэ журмын төсөлд тусгагдсан зохицуулалтыг "Нислэгийн хөдөлгөөнийг төлөвлөх, зөвшөөрөл олгох журам"-д тусгаж, уг журамд нэмэлт өөрчлөлт оруулахаар болсон. Иймд хэлэлцүүлгээс гарсан санал, тэмдэглэлийг Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын газарт 2018.08.29-ний өдрийн 11/11 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн хэлэлцүүлгээс гарсан саналын дагуу Хяналтгүй агаарын зайн мэдээллийн гарын авлагын эхний хувилбарыг боловсруулж, хэрэглэгчдээс санал авч, төсөлд тусгаж байна.<br>МУ-ын агаарын зайн ангилал, нисэх буудлуудын хяналттай агаарын зайн ангилал, босоо болон хэвтээ хязгаарыг шинэчлэн тогтоож, ЗТХС-ын 2018.03.30-ны өдрийн 59 дүгээр тушаалаар батлуулж, энэ оны 09.13-ны өдрөөс мөрдөж эхэлсэн.<br>"Агаарын зайг нисэхэд ашиглах тухай ерөнхий журам"-ын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ХЭГ-т хүргүүлсэн боловч Засгийн газар шинээр эмхлэгдэн байгуулагдсантай холбогдуулан буцаагдсан. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Журмын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр дахин хүргүүлж, ЗГ-ын 2018.02.14-ний өдөр хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж Засгийн газрын 52 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Улмаар Монгол Улсын агаарын зайн ангилал болон нисэх буудлуудын хяналттай агаарын зайн ангиллыг “Агаарын зайн ангиллыг шинэчлэн тогтоох тухай” ЗТХС-ын 2018.09.12-ны өдрийн 202 дугаар тушаалаар, үзүүлэлтэд тулгуурласан навигаци бүхий агаарын замын үндсэн цэгийн нэрийн өөрчлөлт, дээд ба доод агаарын замын үндсэн цэг болон солбицлын өөрчлөлтийг мөн өдрийн “Үндсэн цэгүүдийн нэр болон солбицол өөрчлөх тухай” 203 дугаар тушаалаар тус тус батлуулсан. Монгол Улсын агаарын зайд иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын замуудыг ЗТХСайдын 2019.03.04-ний өдрийн 60 дугаар тушаалаар тогтоож, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 4282 дугаарт бүртгүүлсэн. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019.10.16-ны өдрийн "Агаарын зам шинэчлэн батлах тухай" 317-р тушаалыг батлуулж, ХЗДХЯ-ны улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. | |
| 66 | 2.116. Тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, бүс нутгийн дэд бүтэц, тээврийн интеграцид нэгдэн орох замаар дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлнэ. | 1.Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдсан тээврийн салбарын төсөл, арга хэмжээг судалж хэрэгжүүлэх | 2016-2020 | - | - | Эрэлтэд нийцсэн төсөл, арга хэмжээний судалгааг хэрэгжүүлэх арга хэмжээ авах | - | **АТБХЗГ:** Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт Азийн авто замын сүлжээний АН3, АН4 авто замыг идэвхтэй ашиглах, “Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэрлэлт гүйцэтгэх тухай ОХУ, МУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулахад дэмжлэг үзүүлэх зэрэг төслүүд туссан.<br>“Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан бөгөөд уг хэлэлцээрийг хэрэгжүүлэх Хамтарсан хорооны анхдугаар хурлыг 2019 оны 07 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд зохион байгуулсан. Хамтарсан хорооны хурлаар уг хэлэлцээрийн хүрээнд тээвэрлэлт гүйцэтгэх 200 ширхэг зөвшөөрлийн бичгийг талууд хүлээн авснаар Азийн авто замын сүлжээний АН-3, АН-4 коридорыг идэвхтэй ашиглах нөхцөл бүрдсэн. “Монгол-Орос-Хятадын хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-т туссан автотээврийн салбарын төслүүд хэрэгжсэн.<br>2020 оны эхний улиралд багтаан гурван улсын хамтарсан ажлын хэсэг байгуулах уулзалт зохион байгуулах, хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурах, дэд ажлын хэсгийн ажлын төлөвлөгөөний төслийг хэлэлцэх асуудлыг ГХЯ-аар дамжуулан урьчилсан байдлаар тохиролцсон. | 70% |
| 67 | | 2.Азийн авто замын сүлжээгээр автотээвэр гүйцэтгэх тухай ЗГ хоорондын хэлэлцээрийг эцэслэн | 2016-2017 | - | - | Хэлэл-цээрийг эцэслэн байгуулах | - | **АТБХЗГ:** “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдөр байгуулж, 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр УИХ соёрхон баталсан. Уг хэлэлцээрийг хэрэгжүүлэх Хамтарсан хорооны анхдугаар хурлыг 2019 оны 07 дугаар сарын 3-4-ний өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд хэлэлцээрийн хүрээнд тээвэрлэлт гүйцэтгэх 200 ширхэг зөвшөөрлийн бичгийг талууд хүлээн авснаар хэлэлцээр хэрэгжиж эхэлсэн. Одоогийн байдлаар “Карпорт” ХХК тээвэрлэлт гүйцэтгэх зөвшөөрлийн бичгийг авч ашигласан байна. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулж, хэрэгжүүлэх | | | | | | | |
| 68 | 2.117. Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлж, дотоодын гол, мөрөн нууруудад байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын аюулгүй усан замын тээврийг хөгжүүлнэ. | 1. Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх | 2017-2020 | - | - | Дагалдах дүрэм, журмыг боловсруулах | - | **ТЗДТБХЗГ, /Далайн захиргаа/:**<br>Энэ хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1. Далайн олон улсын байгууллагаас 2016 онд МУ-ын далайн салбарт хийсэн аудитын шалгалтын дүгнэлт, зөвлөмж (*тухайлбал, далайн чиглэлээр Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын конвенцийн заавал хэрэгжүүлэх шаардлагатай холбогдох заалтыг үндэсний хууль тогтоомждоо тусгасан байх шаардлага*)-ийн дагуу МУ-ын далайн салбарын олон улсын гэрээ, конвенцийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг ЗГ-ын 2018.06.27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 201 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд холбогдох байгууллагуудад үүрэг болгон хүргүүлээд байна.<br>2. Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг ЗТХС-ын 2018.07.23-ны өдрийн 157 дугаар тушаалаар байгуулж, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Далай ашиглах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг 2018.01.15-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран батласан.<br>Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг ЗГ-ын 2019.05.22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх шийдвэр гарсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу ХЗДХЯ-ны 1-1/2593, СЯ-ны 6/3678 дугаартай албан бичгээр УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл тус тус авч Засгийн газрын хэрэг эрхлэх газарт УИХ-д өргөн мэдүүлэхээр хүргүүлсэн.<br>2019 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн Эдийн засгийн байнгын хорооны хурлаар хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг хэлэлцэж дэмжсэн.<br>3. “Хөлөг онгоц бүртгэх журам”-д хөлөг онгоцны мэдээллийг төрөл, даацаар нь ангилах, “Монголын хөлөг онгоцны бүртгэл” компаниас олгож буй хөлөг онгоцны гэрчилгээний загварыг олон улсын холбогдох конвенцийн дагуу шинэчлэн Австрали, Бахама, Шинэ Зеланд, Өмнөд Африкийн хөлөг онгоцны бүртгэлийн журамтай харьцуулан судалж боловсруулсан. Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсаны дараа ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлнэ. Журмыг төслийг боловсруулан дуусгасан.<br>4. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай олон улсын конвенцийг соёрхон батлах хуулийн төслийн үзэл баримтлалийг ХЗДХЯ, ГХЯ-тай хамтран батлуулсан.<br>Хуулийн төслийн Засгийн газрын 2019.04.10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэх шийдвэр гарсан.<br>Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл ХЗДХЯ, ГХЯ-аас авч УИХ-д хүргүүлээд байна. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар конвенцийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай төслийг хэлэлцэн дэмжсэн. 11дүгээр сарын 21-ний өдрийн УИХ-ын хуралдаанаар хэлэлцэж баталсан.<br>5. ОУДБ-ын "Дипломтой далайчдыг бэлтгэх болон ээлжийн ажиллагааны тухай" 1978 оны конвенцийн 2010 оны Манилагийн нэмэлт, өөрчлөлтийн орчуулгыг Монгол Улсын олон улсын гэрээний орчуулга хийх, хянан баталгаажуулах журмын дагуу боловсруулж, Олон улсын гэрээний тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу ХЗДХЯ-аар хянуулсан. Тус конвенцийн нэмэлт, өөрчлөлтийн орчуулгыг ГХЯ-ны 2019.05.31-ний өдрийн 09/3240 дугаартай албан бичгээр баталгаажуулсан.<br>Тус конвенцийн нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар ГХЯ-ны холбогдох мэргэжилтэнтэй холбогдон ажиллаж байна. 10 дугаар сарын 01-ны өдөр ГХЯ-ны Олон улсын гэрээ, эрхзүйн газарт конвенцийн нэмэлт өөрчлөлтөд нэгдэх орох талаар чиглэл хүссэн 08/5190 дугаартай албан бичиг хүргүүлсэн.ГХЯ-аас 2019.10.31 өдрийн 09/6405 албан бичгээр конвенцийн нэмэлт, өөрчлөлтийг Засгийн Газрын хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж чиглэл өгсөн. Чиглэлийн дагуу конвенцийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төслийг боловсруулан бусад яамдаас санал авахаар ажиллаж байна | |
| 69 | | 2. Далбааны эзэн улсын үүрэг, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож, Монголын хөлөг онгоцны бүртгэлийн чанарыг сайжруулах, өргөжүүлэх | 2017-2020 | Бусад эх үүсвэр | 800,0 | Хяналтыг хэрэгжүүлэх үндэсний мэргэжилт энг бэлтгэх | 200.0 | **ТЗДТБХЗГ, /"Далайн захиргаа" УТҮГ/:**<br>Энэ зорилгын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1. Далбааны эзэн улсын үүрэг, хариуцлагын тогтолцоог үе шаттайгаар боловсронгуй болгох 2 жилийн төлөвлөгөөг Далайн олон улсын байгууллагатай 2017.08.11-ний өдөр хамтран баталж, хэрэгжүүлэн жил бүрийн төлөвлөгөөний биелэлтийг хангаг Олон улсын далайн байгууллагад хүргүүлэн байна. Аудитын шалгалтын мөрөөр Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцонд техникийн хяналт тавьж үзлэг оношлогоо хийх "Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын үйл ажиллагаанд далбааны эзэн улсаас хяналт тавих журмын төсөл"-ийн танилцуулга, төсөлд нөлөөллийн шинжилгээ хийсэн. "Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын үйл ажиллагаанд далбааны эзэн улсаас хяналт тавих журмын төслийг боловсруулан дуусгасан.<br>2. Хөлөг онгоцны бүртгэлийн чанарыг сайжруулах, өргөжүүлэх хүрээнд Хөлөг онгоцыг алсын зайнаас хянах /LRIT/ системд холбогдох туршилт хийж, Олон улсын хиймэл дагуулын байгууллагын /IMSO/ системд албан ёсоор холбогдож, хөлөг онгоцны бүртгэл хариуцсан ажилтнууд системийн программд нэвтрэх эрхээ 2017.11 дүгээр сард авсан. Хөгжүүлж буй програмыг ашиглалтад оруулах бэлтгэлийг хангаж, МУ-ын хөлөг онгоцны бүртгэлийн мэдээллийг тус програмд оруулсан бөгөөд МУ-ын хөлөг онгоцны бүртгэлийг Улаанбаатар боомтоос явуулах бүрэн боломжтой болсон.<br>3. МУ-ын бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцны дуудлагын болон радио холбооны дугааруудыг Далайн захиргаанаас олгож байгаа бөгөөд нийт 92 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хөлөг онгоцонд холбогдох дугааруудыг олгоод байна. Хөлөг онгоцны бүртгэлийн програм monfleet.com цахим системийг хөгжүүлэгч “Инэкст” ХХК-иас тус системийг ашиглах эрхийг Далайн захиргаанд шилжүүлэн авснаар бүртгэлийн гэрчилгээг Улаанбаатар боомтоос олгон ажиллаж байна.<br>4. МУ-ын нэрийн өмнөөс хөлөг онгоцны бүртгэл хийх боломжит агентуудыг сонгон шалгаруулах журмыг Далайн захиргааны даргын 2018 оны 47 тоот тушаалаар баталж, сонгон шалгаруулалтыг зарыг 2018.06.15-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын болон “МХОБ” компанийн цахим хуудсанд байрлуулан зарласан бөгөөд шалгаруулалтаар БНСУ-ын Пусан боомтод байрлах "Космос марине бюро"ХК-г сонгогдоод байна. Мөн БНСВеУ-тай далайн салбарт хамтран ажиллах санамж бичиг байгуулж, агент томилон ажиллуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна.<br>5. “Үндэсний Дата төв” ТӨҮГ-т хөлөг онгоцыг алсын зайнаас хянах системийн нийцлийн туршилтыг хийх зорилгоор МУ-ын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй болон шинээр бүртгүүлж буй хөлөг онгоц эзэмшигчдэд оператортай холбогдож нийцлийн туршилт (conformance test) хийлгүүлэх мэдэгдлийг хүргүүлээд байна.<br>6. Далайн олон улсын байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн МУ-ын бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцонд хяналт шалгалт хийх байгууллагатай хийх гэрээг боловсруулж, олон улсын техникийн үзлэг шалгалт хийдэг 16 байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна. 2019 онд 2003 оноос хойш хийсэн нийт 17 гэрээг судлан үзэж гэрээний хугацаанд нэг ч хөлөг онгоцны ангилал хийгээгүй гурван Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын гэрээг цуцалж GISIS системийн жагсаалтыг шинэчилсэн. Гэрээ байгуулсан нийт ХЗБ-уудад гэрээ шинэчлэн байгуулах талаар мэдэгдэл хүргүүлээд байна. Мөн шинээр байгуулах гэрээний загварыг бэлтгэн гэрээ байгуулахад ашиглаж хэрэглэж байна.<br>Шинэчилсэн гэрээгээр 5 хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна.<br>7. БНСУ-ын Далайн тээвэр, загас агнуур, технологийн институт (KIMFT)-тэй МУ-ын далайн тээврийн салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх чиглэлээр хамтран ажиллаж байгаа ба мөн үндэсний далайчид бэлтгэх, далайн салбарт хамтран ажиллах чиглэлээр 2018.01.29-ний өдөр БНХАУ-тай, 2018.08. 08-ны өдөр Вьетнам улстай тус тус харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан ажиллаж байна. | |
| 70 | | 3. Байгаль орчинд ээлтэй усан замын тээврийг хөгжүүлэхэд анхаарч төрийн байгууллагуу | 2017-2020 | - | - | Хууль, дүрэм, журмын хэрэгжилт ийг хангаж ажиллах | - | **ТЗДТБХЗГ, “Далайн захиргаа” УТҮГ:**<br>1. Усан замын тээврийн тухай хуулийг шинэчлэн найруулан боловсруулж УИХ-ын нэгдсэн чуулганы 2017.05.25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулав. Шинэчилсэн хууль 2017.07.01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байгаа.<br>2. Усан замын тээврийн тухай шинэчлэн батлагдсан хуулийг дагалдан гарах “Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм”, “Усан замын тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм”, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | д, хувийн хэвшил, иргэд хоорондын уялдаа холбоог сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх | | | | | | “Усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрэм”-үүдийг шинээр боловсруулан Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу төсөлд нөлөөллийн шинжилгээ хийж, эрх ашиг нь хөндөгдөж болох этгээдүүд-завьчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулан ЗТХС-ын 263 ба 2018.12.11-ний өдрийн 277 дугаар тушаалаар тус тус батлуулж, улсын нэгдсэн бүртгэлийн 3861 ба 4080 дугаарт тус тус бүртгүүлэв.<br>3. Мөн хуулийг дагалдан гарах “Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг шинэчлэн боловсруулж Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу төсөлд нөлөөллийн шинжилгээ хийж, эрх ашиг нь хөндөгдөж болох этгээдүүд-завьчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулан ЗТХС-ын 2018.06.05-ны өдрийн 119 дугаар тушаалаар батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн Улсын нэгдсэн бүртгэлийн 3957 дугаарт бүртгүүлэв.<br>4. Хуульд заасан “Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам”-ыг шинээр боловсруулж, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу төсөлд нөлөөллийн шинжилгээ хийж, эрх ашиг нь хөндөгдөж болох этгээдүүд-завьчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан. “Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам”-ыг ЗТХС-ын 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 78 дугаар тушаалаар батлуулав. Журмыг өдрийн 01/1136 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4283 дугаарт бүртгүүлсэн.<br>5. “Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам, сургалтын жишиг хөтөлбөр”-ийг боловсруулж Зам, тээврийн хөгжлийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан **269/А/271** дугаар тушаалаар батлуулав. Уг журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4466 дугаарт бүртгүүлэн улс даяар дагаж мөрдүүлж байна.<br>6. "Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа" сэдэвт семинарыг 2019.06.17-18-ны өдрүүдэд Хөвсгөл нуурт зохион байгуулж усан замын тээврийн үйлчилгээ эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудыг хамруулан усан замын тээврийн салбарт шинээр гарсан дээр дурдсан дүрэм, журмыг сурталчилсан.<br>7. Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл сунгуулах, шинээр авах хүсэлт ирүүлсэн 5 иргэний материалын иж бүрдлийг хянаж, ЗТХС-ын 2019.07.19-ний өдрийн 243 дугаар тушаалаар “усан замын тээврийн үйлчилгээ” эрхлэх тусгай зөвшөөрлийг хуульд заасан хугацаагаар олгон төр хувийн хэвшлийн ажлын уялдаа холбоог хангаж, эрх зүйн орчинг бүрдүүлэн хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | |
| 71 | | 4. Хөвсгөл нуурт усан замын төв зогсоол, дэд бүтцийг | 2016-2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 4 250,0 | Барилгын ажлыг эхлүүлэх | 1,000.0 | **ТЗДТБХЗГ, “Далайн захиргаа” УТҮГ:**<br>Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1. Холбооны Герман улсын Олон улсын эрэн хайх авран хамгаалах байгууллагаас буцалтгүй тусламжаар өгсөн усан орчинд эргүүл хийх, аврах ажиллагааны зориулалттай тусгай тоноглогдсон катерыг МУ-д | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөгжүүлж, аюулгүй, байгаль орчинд ээлтэй усан замын тээврийн үйл ажиллагааг сайжруулах | | | | | | оруулж ирэх тээврийн зардлын 160 сая төгрөгийг Далайн захиргааны санхүүжилтээр шийдвэрлэж, тээвэр зуучийн байгууллагуудын дунд сонгон шалгаруулалт зарлаж, хамгийн бага үнийн санал буюу 120 сая төгрөгөөр тээвэрлэх санал ирүүлсэн Нью сенчюри Ложистик компаниар катерыг тээвэрлүүлж, 2018.11.22-ны өдөр МУ-д оруулж ирснийг Далайн захиргааны холбогдох ажилтнууд Хөвсгөл аймгийн Хатгал тосгон-нуурын эрэгт хүлээн авч өвлийн хадгалалтад хадгалсан. Энэхүү тусгай зориулалтын завийг жолоодох, засвар үйлчилгээ хийх сургалтад тус яамны ХШҮДАГ-ын Зам, тээврийн хяналтын хэлтсийн мэргэжилтэн, усан замын тээврийн хяналтын улсын байцаагч, харъяа Далайн захиргааны дотоодын усан замын асуудал хариуцсан ахлах ажилтан, усан замын тээврийн хяналтын улсын байцаагч нарыг 2019.04.05-наас ХБНГУ-ын Бремен хотод хамруулах ажлыг зохион байгуулав. Үүний үр дүнд усан замын тээврийн хяналт сайжирч, аюулгүй байдал хангагдан байгаль орчинд ээлтэй усан замын тээврийн үйл ажиллагаа сайжирна.<br>2. БНХАУ-аас буцалтгүй тусламжаар ирүүлсэн катерын тээвэрлэлтийн зардлыг Далайн захиргааны санхүүжилтээр шийдвэрлэж, Хөвсгөл нуурт ажиллуулснаар хяналтын эргүүл хийх, авран туслах зориулалттай нийт 3 катераар усан замын тээврийн аюулгүй байдлыг хангаж байна.<br>3. Мөн усан замын тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тус яамны харьяа байгууллагын ажилтнуудад усан замын тээврийн хяналтын улсын байцаагчийн эрхийг МХЕГ-аар шийдвэрлүүлэн олгож, жил бүрийн хөвөлтийн улиралд Хөвсгөл нуурт 14-21 хоногоор ээлжлүүлэн ажиллуулж хяналт тавьж байна. Эдгээр арга хэмжээ авсны үр дүнд усан замын тээврийн хяналт сайжирч, аюулгүй байдал хангагдан байгаль орчинд ээлтэй усан замын тээврийн үйл ажиллагаа өргөжиж байна.<br>4. Хөвсгөл нуурт усан замын төв зогсоол барих асуудлыг шийдвэрлүүлэхээр Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын 1 дэх хэсгийн 7[4] дэх заалтад “Усан замын тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоол бүхий зорчигч үйлчилгээний төв буудлыг Хөвсгөл нуурын эрэгт барьж байгуулах” арга хэмжээг ЗГ-ын 2015 оны 133 дугаар тогтоолоор нэмэлт оруулсан. Усан замын төв буудал барих газрыг Хөвсгөл аймгийн ЗД-ын 2017.02.24-ний өдрийн 1/542 тоот захирамж, Алаг-Эрдэнэ сумын ЗД-ын 2017.02.16-ны өдрийн А/16 тоот захирамж, Хатгал тосгоны захирагчийн 2017.02.16-ны өдрийн 1/71 тоот захирамжаар тус тус шийдвэрлүүлж, газар зүйн солбицол, координатыг нь тогтоолгосон.<br>5. Усан замын төв буудал барих ажлын даалгавар боловсруулж, холбогдох төрийн байгууллага, орон нутгаас санал авч концесс зарлуулахаар ҮХГ-т 2017.12.13-ны өдрийн 03/5520 тоот албан бичгээр хүргүүлсэн ба тус газрын 2018 оны төлөвлөгөөнд 4-р дүгээр улиралд хэрэгжүүлэхээр тусгагдан хүлээгдэж байна. Энэхүү ажлыг яаравчлуулах шаардлагыг 2018.12.04-ний өдрийн 08/2777 тоот албан бичгээр тус газарт хүргүүлсэн. 2019.02 дугаар сард тус газраас энэ талаар лавлахад концессоор хэрэгжүүлэх ажлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмблэн Засгийн газрын тогтоол гаргуулахаар ажиллаж байна гэв. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Үндэсний хөгжлийн газраас концессын гэрээгээр улсын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг Засгийн газарт оруулж хэлэлцүүлэн ач холбогдлоор нь эрэмблэсний дагуу Хөвсгөл нуурт усан замын төв зогсоолыг концессын гэрээгээр барих асуудал тус газрын төлөвлөгөөнд 2019 оны 4 дүгээр улиралд тусгагдаад байна. Тус газар уг асуудлаар ажлын хэсэг байгуулна, түүнд асуудал хариуцсан тус яамны ажилтнуудыг татан оролцуулахаар тохирсон. Энэхүү төв зогсоол /буудал/ баригдсанаар усан замын зорчигч тээврийн аюулгүй байдал хангагдан байгаль орчинд ээлтэй усан замын тээврийн үйл ажиллагаа сайжирна.<br>6. Концесс эзэмшигч гарч ирээгүй тохиолдолд энэхүү ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зорилгоор **2019 оны Төсвийн тухай хуульд Хөвсгөл нуурын усан замын төв зогсоол барих ажлын зураг төсөл, ТЭЗҮ-г боловсруулах санхүүжилт болох 800 сая төгрөгийг улсын төсөвт тусгах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн боловч хөрөнгө тусгагдаагүй.** | |
| 72 | 2.118. Эрэлтэд нийцсэн, хүрээлэн байгаа орчинд ээлтэй тээврийн ухаалаг систем нэвтрүүлнэ. | 1.Төмөр замын зорчигч, ачаа тээврийн үйлчилгээнд орчин үеийн менежментийн аргуудыг бий болгох, үйлчилгээний чанарыг сайжруулах | 2016-2020 | - | - | - | - | **ТЗДТБХЗГ, “УБТЗ” ХНН:**<br><u>2016 онд:</u> “УБТЗ” ХНН-ийн харьяа “Улаанбаатар дахь зорчигчийн вагон депо”-ийн 482 дугаар вагоныг техникийн зураг, төслийн дагуу сэргээгдэх их засварыг хийж, тусгай зориулалтын вагон болгох хийцийг өөрчлөн тоноглон, туршилтын аяллаар шалгаж №16001, код-О-4-2, РД:2076675 дугаар бүхий “Аюулгүй ажиллагаа”-ны гэрчилгээг олгосон. Тус вагоныг 2016.05.20-ны өдрөөс эхлэн 7 хоногт 2 удаа байнгын тээвэрлэлтэд ашиглаж “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд”-ийг төмөр замаар аюулгүй, ая тухтай зорчих, зорчигч үйлчилгээний стандартын шаардлагыг хангаж ажилласан.<br>Төмөр замын объектыг коджуулах тухай О 920-2, О+920; О+920-1,2; О+914 санамжуудыг MNS 920; MNS920-1,2; MNS914 стандарт болгон батлуулахаар ажиллаж байна.<br><u>2017 онд</u>:<br>1. ЗТХС-ын 2017 оны 16 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм”-ийг боловсруулж, ЗТХС-ын 2017.12.27-ны өдрийн 541 дүгээр тушаалаар шинэчлэн батлуулав.<br>2. Сэлэнгэ, Сайншанд, Замын-Үүдийн төмөр замын буудлын авто тээврийн тасалбар түгээгүүрийг байрлуулж, буудлуудын ашиглалт болон иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулав.<br>3. Зорчигчид үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, Улаанбаатар-Эрхүү чиглэлийн галт тэрэгний аяллын хугацааг 9 цагаар богиносгож, 7 хоногт тогтмол аялах галт тэрэгний тоог нэмэгдүүлэв.<br>4. Олон улсын галт тэргээр зорчигч тээвэрлэх үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор 2017.07.30-08.04-ний өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо Төмөр замын тээврийн судалгаа шинжилгээний хүрээлэнтэй хамтран МУ, ОХУ-ын төмөр замаар зорчигчийн галт тэргэнд тасалбар худалдаалах цахим програмыг харилцан уялдуулах чиглэлээр хамтарсан судалгааг эхлүүлсэн. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 5. Тээвэр зуучлалын үйл ажиллагааны чанарыг сайжруулах тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын төлөөлөлтэй 2017.08.11-ний өдөр уулзалт зохион байгуулж, харилцан санал солилцов. Гэрчилгээжүүлэлтийн журамд тээвэр зуучлалын үйл ажиллагаатай холбоотой аюулгүй байдлын гэрчилгээ олгоход тавигдах шаардлагыг өөрчлөн, сайжруулж, төслийг бэлэн болгоод байна.<br>2018 онд:<br>1. ЗТХС-ын 2018 оны 13 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг "Төмөр замаар ачаа тээвэрлэх дүрэм", "Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм"-ийн төслийг шинэчлэн боловсруулсан бөгөөд шинэчилсэн төсөлд зорчигч, ачаа тээврийн үйлчилгээнд орчин үеийн менежмент нэвтрүүлэх олон шинэ зохицуулалтууд тусгагдсан.<br>2. Галт тэрэгний тасалбар худалдаалалтыг бүрэн цахимжуулж, бүх банкны картыг ашиглан цахимаар тасалбар худалдан авах боломжтой болгосон.<br>3. Зорчигчдын тав тухыг хангах зорилгоор Улаанбаатар-Сайншанд чиглэлийн галт тэрэгний цагийн хуваарийг 2018.03.19-ний өдрөөс эхлэн цагийн хуваарьт өөрчлөлт оруулсан.<br>4. Үйлчлүүлэгчид зориулсан төмөр замаар ачаа тээвэрлэх цахим үйлчилгээ бий болгох, цаасгүй технологи нэвтрүүлэх зорилгоор "УБТЗ" ХНН-тэй хамтран "Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем" боловсруулан 2018.09.01-ний өдрөөс эхлэн туршилтаар үйлчилгээнд нэвтрүүлэн ажиллаж байна.<br>2019 онд:<br>Төмөр замын тээврийн тухай хуулийн 15.1-д заасан 16 журмыг багцаар боловсруулж, "Төмөр замаар ачаа тээвэрлэх дүрэм", "Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм"-ийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 264 дүгээр тушаалаар батлуулж, Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулан Улсын нэгдсэн бүртгэлийн 2019 оны 4274 дугаарт бүртгүүлсэн тухай албан бичиг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлэн, багц журмыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>"Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн зорчигч тээврийн үйлчилгээнд 2019 оны 02 дугаар сараас эхлэн билет захиалах боломжтой гар утасны "Ticket UBTZ" аппликейшн нэвтрүүлж, амжилттай хэрэгжиж байна. Мөн тасалбар түгээх нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэхээр "Улаанбаатар төмөр зам" ХНН болон "АТҮТ" ТӨХК нар хамтарсан ажлын хэсэг байгуулж, туршилтаар авто үйлчилгээний Драгон төв, Галт тэрэгний төв вокзал зэрэг газруудад орон нутгийн авто тээврийн болон төмөр замын тасалбарыг худалдаалж эхлүүлээд байна.<br>Мөн онлайнаар төмөр замын тасалбарыг eticket.ubtz.mn хаягаар, автобусны тасалбарыг eticket.transdep.mn хаягаар тус тус захиалах боломжтой бөгөөд эдгээр цахим хаягууд нь хоорондоо холбоотой бөгөөд нэгээс нөгөөд шууд дамжин тасалбараа захиалах боломжтой болсон: | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Олон улсын тасалбар түгээх төвөөс ОХУ-ын бүх чиглэлд буюу олон улс, орон нутагт зорчих зорчигчийн тасалбарыг 2019.08.01-ний өдрөөс эхлэн худалдан авах боломжтой болсон.<br>“УБТЗ” ХНН нь нийт харилцагч, үйлчлүүлэгч нарын ачилтын захиалгыг жил, улирал, сараар хүлээн авч тээвэрлэлтийг эрх тэгш, түргэн шуурхай, тасралтгүй зохион байгуулахын тулд вагон хангалт, төлбөр төлөлтийн үйл ажиллагаанд хувь хүний хүчин зүйлийн оролцоог хаах, шударга ил, тод нээлттэй байлгах зорилгоор 2018.12.01-ний өдрөөс “Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем” программыг нэвтрүүлэн ажиллаж байна. Замын-Үүд-Эрээний галт тэрэг солилцоог хоногт 12 байсныг 14 хос галт тэрэг болгосон нь БНХАУ-руу экспортоор гаргах ачааны тоо нэмэгдсэн. Мөн нийт харилцагч, үйлчлүүлэгч нарын ачилтын захиалгыг жил, улирал, сараар цахимаар хүлээн авч тээвэрлэлтийг эрх тэгш, түргэн шуурхай, тасралтгүй зохион байгуулснаар вагон хангалт, төлбөр төлөлтийн үйл ажиллагаанд хувь хүний хүчин зүйлийн оролцоог хааж, шударга ил, тод нээлттэй болгож, хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулсан. 126 байгууллага цахим систем ашиглах гэрээ байгуулан үйлчилгээ авч байна. | |
| 73 | | 2.Аюулгүй, найдвартай, их багтаамжийн нийтийн тээврийг хөгжүүлэн 400-аас доошгүй автобусаар парк шинэчлэх | 2016-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 80 000,0 | 100 автобус авах | 20 000,0 | **АТБХЗГ:**<br>**<u>2016 онд:</u>** МУ-ын ЗГ, БНСУ-ын ЗГ хоорондын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд авах зээлийн хөрөнгөөр “Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. МУ-ын ЗГ-ыг төлөөлж Сангийн яам, БНСУ-ын ЗГ-аас “ЭЗХХАС”-гийн үйл ажиллагаа болон удирдлагыг итгэмжилсэн Эксим банкны хооронд гэрээ байгуулсан. Эхний шатны төслийн хүрээнд улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглах **43 автобусыг** 5.5 сая ам. долларын санхүүжилтээр худалдан авч хэрэгжүүлсэн.<br>**<u>2017 онд</u>**: Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн хоёрдугаар шатны төслийг хэрэгжүүлэх МУ-ын Сангийн яам, БНСУ-ын Экспорт-импорт банкны хооронд байгуулсан 2016.07.17-ны өдрийн гэрээгээр автобус худалдан авах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр тусгасан. Энэхүү төслөөр улс, хот хооронд болон жуулчин тээврийн үйлчилгээнд 189 автобус авахад автобусны үнэ өнөөгийн валютын ханшны үнээр тооцоход өндөр гарч байгаагаас тээвэрлэлт гүйцэтгэж буй аж ахуйн нэгжүүд төсөлд хамрагдахаас татгалзсан.<br>**<u>2018 онд:</u>** Эксим банкны 2 дугаар шатны төслийн зориулалтыг “Нийслэл хотын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл” болгон өөрчлөх асуудлаар ЗТХС-ын Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дэмжигдсэн. Энэхүү шийдвэрийг БНСУ-ын Эксим банк төслийн зориулалтыг өөрчлөхийг зөвшөөрөөгүй. Иймд МУ-ын ЗГ, БНСУ-ын ЗГ хоорондын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд авах зээлийн хөрөнгөөр “Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн эхний шатны төслийн хэрэгжилтийн тухай болон хоёрдугаар шатны төслийн талаар цаашид авах арга хэмжээний тухай асуудлаар Засгийн | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | газрын хуралдаанд танилцуулж, шийдвэр гаргуулахаар хуралдааны тэмдэглэл болон тогтоолын төсөл, танилцуулгын хамт Сангийн сайдад 2018.03.20-ний өдрийн 01/1186 тоот албан бичгээр хүргүүлэв. Уг асуудал нь “Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийг дуусгавар болгож, агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд нийслэл хотын нийтийн тээврийн хэрэгслийг цахилгаан болон хийн түлшний хэрэглээнд шилжүүлэх зорилгоор *2 дугаар шатанд хэрэгжүүлэх байсан 25.0 сая.ам.долларын санхүүжилтыг* “Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл”-д зориулах тусгайлсан зээлийн гэрээг БНСУ-ын Эксим банктай шинэчлэн байгуулах саналыг Засгийн газрын хуралдаанд оруулахаар ажилласан.<br>Аюулгүй, найдвартай, их багтаамжийн автобусаар паркийн шинэчлэлт хийх үүднээс нийтийн тээврийн аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийн нөөц хөрөнгийг бүрдүүлэн идэвхтэй ажиллаж байгаа ба 2018 оны эхний хагас жилд 2014-2016 онд үйлдвэрлэсэн **102 автобусыг** импортоор авч, үйлчилгээнд ажиллуулж байна.<br>**<u>2019 онд:</u>** Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д “Байгаль орчинд ээлтэй, нэгдсэн ухаалаг систем бүхий нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл”-ийг концессын “шинэчлэн сайжруулах–ашиглах- шилжүүлэх” төрлөөр нэмэлтээр оруулахаар Засгийн газраас шийдвэрлэн, Засгийн газрын тогтоолын төслийг тус яаманд ирүүлсэн.<br>Бодлогын хэрэгжилтийг хангах, агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгоор “Байгаль орчинд ээлтэй, нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд дизель хөдөлгүүр бүхий хотын доторх том оврын автобусыг цахилгаан автобусаар солих, нэвтрүүлэх асуудлыг тус яамны зүгээс дэмжин ажиллаж байна. Энэхүү төслийн хүрээнд 1200 цахилгаан автобус нийлүүлэгдэхээр төлөвлөсөн. Нийтийн тээврийн үйлчилгээний автобус, троллейбус болон таксийн тээврийн хэрэгслийн паркийг жил бүр шинэчлэн, шаардлагатай тооцоо, судалгааг тогтмол хийх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг түлхүү дэмжиж, нөхөн хангалт хийх замаар үе шаттайгаар сайжруулан ажиллаж байна. Тус тогтоолыг үндэслэн “Үндэсний хөгжлийн газрын даргын 2019.06.07-ны өдрийн А-103 дугаар тушаалаар концесс олгох уралдаант шалгаруулалтын баримт бичиг боловсруулах, зарлах, оролцох болон төслийн санал үнэлэх, шалгарсан оролцогчтой концессын гэрээний хэлэлцээр хийх, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий комисс байгуулагдан ажиллаж байна.<br><br>Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч даргын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/70 дугаар захирамжаар “Нийтийн тээврийн үйлчилгээний парк шинэчлэлтийн өнөөгийн байдлыг судалж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан танилцуулах” чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Энэхүү ажлын хэсэгт тус яамнаас орж ажиллаж байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Үүний дагуу ажлын хэсэг хоёр удаа хуралдан парк шинэчлэлтийн өнөөгийн байдал, цаашид парк шинэчлэлт хийх боломжуудын судалгааг хийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний төслийн санал боловсруулан Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Ажлын хэсгээс судалгаа тооцооллыг хийж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулав.<br>Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аюулгүй, найдвартай, их багтаамжийн автобусаар паркийн шинэчлэлт хийх үүднээс нийтийн тээврийн аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийн нөөц хөрөнгөөр 2019 оны байдлаар **их багтаамжийн 50 автобус, дунд багтаамжийн 41 автобус, 1 цахилгаан автобус, 159 такси** импортоор авч, үйлчилгээнд явуулж байна.<br>Засгийн газрын 2018 оны 122 дугаар тогтоолоор дотооддоо 2 ширхэг МОН-30 загварын цахилгаан автобус угсрах шийдвэрийн дагуу дотооддоо үйлдвэрлэн тус газрын даргын 2019.10.21-ний өдрийн А/68 тушаалаар МОН-30 загварын их багтаамжийн 2 ширхэг цахилгаан автобусыг акт үйлдэн хүлээн авч, 2019.10.30-ны өдрийн А/74 тушаалаар Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГазарт хүлээлгэн өгсөн.<br>Мөн НИТХ-н Тэргүүлэгчдийн 2019.08.29-ний өдрийн хуралдаанд нийтийн тээврийн паркийн талаар танилцуулагдсан.<br>2019 онд их багтаамжийн **147 автобусаар паркийн нөхөн хангалт, 1 цахилгаан автобусаар парк шинэчлэлт** хийсэн. Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд нийтийн тээврийн үйлчилгээнд байгальд ээлтэй их багтаамжийн 300 автобусаар үе шаттайгаар парк шинэчлэхэд шаардлагатай төсвөөс цахилгаан автобус 50 ширхгийг 3.0 тэрбум, троллейбус 100 ширхгийг 26.50 тэрбум төгрөгөөр парк шинэчлэх төсөв НИТХ-ын ээлжит 29 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн батлагдсан. | |
| 74 | | 3.Зам, тээврийн салбарын статистик мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтийн бүртгэлийн нэгдсэн систем бүрдүүлэх | 2017-2018 | - | - | Мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлэх | - | **БТГ:**<br>ЗТХС-ын 2017 оны 91 дүгээр тушаалаар "Зам, тээврийн салбарын статистик мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтийн бүртгэлийн нэгдсэн систем бүрдүүлэх" ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.<br>Ажлын хэсгийн зүгээс зам, тээврийн салбарын статистик мэдээллүүдийн маягтыг боловсруулан ҮСХ-нд хүргүүлэн зөвшөөрөл авсны дагуу ЗТХС-ын 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 267, 268, 269 дугаар тушаалаар батлуулсан.<br>Зам, тээврийн салбарын статистик мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтийн бүртгэлийн нэгдсэн системийг 2018-2019 онд бий болгон хөгжүүлж салбарын статистик мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтийн мэдээллүүдийг оруулсан.<br>Зам, тээврийн салбарын статистик мэдээлийн бүртгэлийн системийг Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээллийн нэгдсэн сантай 2019 онд холбосноор веб сервисийг хөгжүүлж дууссан. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 75 | | 4.Замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх тогтолцоог бүрдүүлэх | 2017-2018 | Гадаад зээл | 2 100,0 | Төсөл хэрэгжих | 1 000,0<br><br>2017 онд зарцуул-сан<br>-<br><br>1,100.0<br>2018 онд зарцуул-сан | **АТБХЗГ:** Замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх тогтолцоог бий болгох, холбогдох эрх зүйн орчинг бүрдүүлэх судалгааны ажлыг хийж дуусган, ЗТХЯ-ны ШУТЗ-ийн 2016.12.19-ний өдрийн 02 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн авто замын салбарт хяналт, шалгалт хийх чиглэлээр мөрдөж буй 5 журамтай уялдуулан боловсруулсны дараа хүлээн авахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу:<br>1. МУ-ын замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн байдалд хийсэн дүн, шинжилгээ;<br>2. Замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлүүдэд хийсэн дүн шинжилгээ;<br>3. Хөдөлгөөн зохион байгуулалтын өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ;<br>4.МУ-ын авто замын төлөвлөлтийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ;<br>5. Авто замын тээврийн салбарт мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичиг болон хөгжлийн бодлогод хийсэн дүн шинжилгээ;<br>6. Авто замын төлөвлөлт ба хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх гадаад улс орны тэргүүн туршлага судалгаа;<br>7. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит (ЗХАБА-ын тухай ерөнхий ойлголт, түүний хэрэгцээ, шаардлага, ач холбогдол, гадаад улс орнуудын туршлага зэргийг хамарсан судалгаа), авто замын төлөвлөлт болох хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаарх бусад орны туршлага, харьцуулалт зэргийг хамарсан)талаарх судалгаа;<br>8. МУ-д замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх тогтолцоог нэвтрүүлэх аргачлал, зөвлөмж (эрх зүйн орчинг бүрдүүлэх хүрээнд хуулийн төсөл, журмын төсөл, аргачлалын төслийг, практик хэрэглээнд нэвтрүүлэх хүрээнд загвар тайланг)-ийг тус тус боловсруулсан. Уг ажлын хүрээнд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах компанит ажил” сэдэвт семинарыг 2017.09.13-ны өдөр Улаанбаатар зочид буудалд зохион байгуулав.<br>Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны санхүүжилтээр “Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах” TA 9137-MON төслийг 2017.04 дүгээр сараас эхлүүлсэн бөгөөд Энэхүү төслийн хүрээнд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх аргачлал” боловсруулан ЗТХЯ-ны ХШҮДАГ-т хүлээлгэн өгөв. БНСУ, Дани улсын замын хөдөлгөөний аудит хийж байгаа тогтолцоотой танилцаж боловсруулсан аргачлалыг шинэчлэн ЗТХЯ-ны ШУТЗ-ийн 2018.06.15-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж дэмжүүлэв.<br>Уг аргачлалыг ашиглан Улаанбаатар-Дархан чиглэлийн замын 2 хэсэгт үнэлгээ хийж ЗТХ-ийн сайдад 2018.06.08-ны өдөр танилцуулав.<br>2018.09.19-25-ны өдрүүдэд Прокурорын Ерөнхий газрын Сургалт, судалгааны төвтэй хамтран 5 өдрийн сургалт, судалгааны ажлыг зохион байгуулан “Замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх” заалтыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд тусгуулах санал хүргүүлэх зөвлөмж боловсруулав. Азийн хөгжлийн банкны техникийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | туслалцааны санхүүжилтээр “Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах” ТА 9137-MON төслийг 2017.04 дүгээр сараас эхлүүлсэн бөгөөд энэхүү төслийн хүрээнд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх аргачлал” боловсруулан ЗТХЯ-ны ШУТЗ-ын хурлаар хэлэлцүүлэн дэмжиж ЗТХС-ын 2018 оны 283 дугаар тушаалаар батлуулав. | |
| 76 | | 5.Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, татвар, даатгал, авто үйлчилгээний салбарт RFID системийг нэвтрүүлэх | 2016-2020 | Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | 2 700,0 | Хөдөлгөөний эрчмийн тооллого хийгдэх нийт 68 цэгт RFID системийг суурилуулах | 1,000.0 | **АТБХЗГ:** Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан RFID технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд 2017 онд судалгаа хийж, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто замд нэвтрүүлэхээр төлөвлөсөн.<br>2018 онд “Кредо терра” ХХК-тай байгуулсан тээврийн нэгдсэн систем боловсруулах ажлын хүрээнд RFID уншигч төхөөрөмж 4 ширхэгийг худалдан авсан.<br>2019 онд “АТҮТ” ТӨҮГ-ын худалдан авах ажиллагааны дагуу 8000 шошго худалдан авах тендер зарласан. Энэхүү тендерт 9 компани оролцсоноос 2019.04.29-ний өдөр шалгаруулахад “Бодь электроникс” ХХК шалгарсан.<br>Мөн тус яамны авто зогсоолын орох, гарах хаалга дээр 2019.04.08-наас RFID шошго уншигч төхөөрөмж байрлуулан туршилтын ажлыг эхлүүлсэн. Хилийн боомт дээр RFID системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд ЗТХЯ, ГЕГ болон “АТҮТ” ТӨҮГ хамтарсан Ажлын хэсгийг Гаалийн ерөнхий газар, “АТҮТ” ТӨҮГ-ын 2019.05.31-ний өдрийн А/103, а/171 хамтарсан тушаалаар байгуулсан. Ажлын хэсэгт тус яамнаас 3, Гаалийн ерөнхий газраас 5, “АТҮТ” ТӨҮГ-аас 7 төлөөлөл багтсан. Ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу үйл ажиллагаа төлөвлөн ажиллаж байна.<br>Замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээвэрлэлт, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, тэдгээрийн даатгалд хамрагдсан байдалд хяналт тавих, авто зам, замын байгууламжийг ашигласны төлбөр төлөх үйл ажиллагаанд RFID (радио долгионы давтамж ашиглан бүртгэх) системд суурилсан цахим үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг Монгол Улсын хэмжээнд нэгдмэл байдлаар үе шаттайгаар хамтран зохион байгуулах талаар “Цахим үйлчилгээ нэвтрүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан 2019.08.08-ны өдрийн 01/4271 тоот албан бичгээр яамдаас санал авсан. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас санхүүжилтийн асуудлыг Сангийн яамтай сайтар зөвшилцөх тухай санал ирүүлсэн бөгөөд Сангийн яамнаас “Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт авто замын техник технологийг шинэчлэхэд шаардагдах зардлыг авто замын сангаас санхүүжүүлэхээр заасан байгаа тул дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нэмэлтээр Засгийн газрын тогтоол гаргах шаардлагагүй” гэсэн саналыг ирүүлсэн тул Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагагүй болсон. Нийслэлийн хэмжээнд RFID систем нэвтрүүлэхтэй холбоотойгоор 2020 оны төсөвт 600.0 сая төгрөг төсөвлөгдсөн. НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.11.12-ны өдрийн 181 дүгээр тогтоолын хавсралтаар радио долгионы давтамж ашиглан бүртгэх /RFID/ системд мөрдөх | 40% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 77 | | | | | | | | стандартын жагсаалтыг баталсан бөгөөд энэхүү стандарт нь ISO 18000-V6 байхаар тогтсон.<br>"Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын гэрчилгээний загвар батлах тухай" ЗТХС-ын 2019.12.03-ны өдрийн 365 дугаар тушаалаар техникийн хяналтын үзлэгийн гэрчилгээг RPID систем нэвтрүүлэх үйл ажиллагаанд нийцүүлэн батлуулсан. Сайдын тушаалаар батлагдсан техникийн хяналтын үзлэгийн гэрчилгээний загварыг Нийслэлийн мэдээллийн технологийн газар, Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний газар, “Монгол терминал” ХХК,“Доктор авто сүлжээ” ХХК, “Нива трейд” ХХК, “Мөнх ерөөлт интернэйшнл” ХХК, “Замт моторс” ХХК зэрэг газруудад хүргүүлсэн бөгөөд түүнийг хэвлүүлэх зардлыг 2020 оны зорилтот төвшинд тусган санхүүжүүлэх арга хэмжээ авах тухай чиглэлийг 2019.12.03-ны өдрийн 03/6441 тоот албан бичгээр "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-т хүргүүлсэн. | |
| 77 | | 6.Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах | 2016-2017 | Гадаад эх үүсвэр | 1 065,0 | Төсөл хэрэгжих 2017 | 1 065,0<br><br>2017 онд зарцуул-сан<br>-<br><br>2018 онд зарцуул-сан | **АТБХЗГ:**<br>Тус яамны захиалгаар Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Монгол Улсын Тээврийн ухаалаг системийн бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ТА-9131 МОН” техникийн туслалцааны төслийг 2017.03.17-ны өдрөөс 2018.12.31-ний өдөр хүртэл хугацаагаар хэрэгжүүлнэ. Уг төслийн зөвлөх компаниар БНСУ-ын Тээврийн институт, Траком /Tracom Ltd/ болон SH корпораци гэсэн 3 байгууллагын консорциум шалгарч Азийн хөгжлийн банктай 129480-S52983 тоот гэрээг байгуулан ажиллаж байна.<br>Төслийн эхлэлийн болон дундын шатны, эцсийн шатны тайланг холбогдох судалгааны хамт хүлээн авсан. ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу холбогдох байгууллагуудтай хамтран 2 удаагийн сургалт, семинар хийсэн.<br>Төслийн Удирдах хороо байгуулагдсан. АХБ-аас төсөл хэрэгжүүлэх хугацааг 2018 он дуустал сунгасан.Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд ЗГ-ын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д заасны дагуу эцсийн шатны судалгаа, тайланг боловсруулж, эцсийн шатны тайланг 2018 оны 12 дугаар сард хүлээн авсан.<br>Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2019.03.06-ны өдрийн 100 дугаар тушаалаар байгуулав.<br>Ажлын хэсгийн хурлыг 2019.03.22-ны өдөр хуралдуулж ажлын хэсгийн төлөвлөгөөг хэлэлцэн батлав. Хөтөлбөрийн талаар 3 хувилбарт төслийг боловсруулан гишүүдэд танилцуулсан. Эцсийн хувилбарын төслийг сонгон холбогдох журамд заасан судалгаа тооцоог хийж гүйцэтгэсэн. Хөтөлбөрийн төслийн хэлэлцүүлэгийг 2019.11.14-ны өдөр зохион байгуулав. Хэлэлцүүлэгт АТҮТ, ЗТХТ, нийслэлийн харъяа агентлагууд, Автотээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-ууд, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцов. | 40% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтоолын төсөл боловсруулан яамдаас санал авахаар 2019.11.19-ны өдрийн 01/6206 тоот албан бичгээр хүргүүлсэн боловч Сангийн яамнаас ирсэн 5-217971 тоот хариу албан бичгэнд Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд шинээр боловсруулах болон үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн жагсаалт”-нд “Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” байхгүй тул санал, зөвшөөрөл өгөх боломжгүй байна гэжээ. Иймд тус хөтөлбөрийг 121 дүгээр тогтоолын хавсралтанд нэмж тусгуулах талаар Засгийн газрын гишүүдээс санал авах 01/6634 тоот албан бичгийг хүргүүлэн ажиллаж байна. | |
| 78 | | 7.Зам, тээврийн салбарын стандарт, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2016-2020 | Зам, тээврийн салбарын нормчлолын сан | 4 000,0 | Зам тээврийн салбарт шинэ техник, технологийн чиглэлээр стандарт, техникийн баримт бичиг бий болох | 1,000.0 | **БТГ:**<br>2018 онд: “Зам, тээврийн салбарын стандарт, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж, зам тээврийн салбарын 4 техникийн хорооны 2018-2019 оны төлөвлөгөөг Стандартчиллын Үндэсний зөвлөлийн 2018.02.22-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.<br>Зам, тээврийн салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сан”-гийн Удирдах зөвлөлийн хуралдааныг 2018.02.08-ны өдрийн зохион байгуулж, “Зам, тээврийн салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сангийн 2018-2019 онд үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хэлэлцүүлэн гишүүдээс гаргасан санал, зөвлөмжийг тусган 2018.03.06-ны өдөр ТНБД-аар батлуулсан. ЗТХС-ын 2018 оны 90 дүгээр тушаалын 3 дахь заалтыг үндэслэн норм, нормативын сангийн төлөвлөгөө, үйл ажиллагаатай холбоотой баримт бичиг, материалыг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т шилжүүлэн өгсөн. Дээрх бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараахь, стандарт, норм, техникийн баримт бичгийг батлуулсан. Үүнд:<br>1.“Иргэний нисэх. Нисэхийн хөдөлгөөнт холбооны хэт өндөр давтамжийн хэмжээ. MNS **** : 2018 стандартыг Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018.04.26-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.<br>2. “Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ тооцох аргачлал” техникийн баримт бичгийг ЗТХС-ын 2018.05.02-ны өдрийн 87 дугаар тушаалаар батлуулсан.<br>3. “Зам төмрийн толгойн түвшинд авто угсрааны өндөр шалгах загвар. Баталгаажуулалтын арга хэрэгсэл ” MNS **** : 2018,<br>4. Замын тэмдэглэгээний материал. Физик шинж чанар. MNS EN 1871 :,<br>5. Авто замын 3, төмөр зам, далайн тээврийн 1, авто тээврийн 4 стандартын төсөл,<br>6 Зам барилгын материал. Нефтийн өтгөн битум. MNS GOST 33133 :<br>7. Асфальтбетон болон органик эрдэс (органо-минераль) хольцод хэрэглэх эрдэс нунтаг. Техникийн шаардлага. MNS GOST 52129 : 2018<br>8. Уулархаг нутгийн авто зам дагуу зэрлэг амьтдад зориулсан гарц. Ерөнхий шаардлага | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 9. Аккумуляторын батарейгаар ажилладаг цахилгаан автомашин. Хийц, аюулгүй байдалд тавих техникийн шаардлага MNS **** : 2018<br>10. Автотээврийн хэрэгсэл. байгалийн хийгээр цэнэглэх компрессорын станцын аюулгүй ажиллагаанд тавих шаардлага MNS **** : 2018<br>11. Автотээврийн хэрэгсэл. Байгалийн хийгээр ажилладаг автотээврийн хэрэгсэл. Ерөнхий шаардлага MNS **** : 2018<br>12. Автотээврийн хэрэгслийг байгалийн хийгээр цэнэглэх компрессорын станцын техник ашиглалтанд тавих шаардлага MNS **** : 2018 стандартын төслийг Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018.06.21-ний өдрийн хуралдаанаар тус тус батлуулаад байна:<br>Түүнчлэн Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018.06. 21-ний өдрийн хуралдаанаар дараах стандартад нэмэлт өөрчлөлт оруулсан:<br>13. Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. 2-р хэсэг: Ерөнхий шаардлага MNS 4410-2 : 2017 стандарт<br>2019 онд:<br>Авто замын салбарын 4 техникийн норм, авто тээврийн 4 стандарт, төмөр замын 4 стандартыг тус тус боловсруулж ЗТХ-ийн сайд, СХЗГ-ын даргын тушаалаар тус тус батлуулсан.Үүнд:<br>Авто замын техникийн нормыг 2019 оны 3 дугаар сард батлуулсан. Үүнд:<br>1. Цементээр бэхжүүлсэн хөрс суурь барих техникийн нормыг 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн ЗТХ-ийн сайдыг 67-р тушаал,<br>2. Цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь барих техникийн нормыг 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн ЗТХ-ийн сайдыг 68-р тушаал,<br>3. Асфальтбетон хучлагыг дахин боловсруулах ба цементээр бэхжүүлсэн суурь барих техникийн нормыг 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн ЗТХ-ийн сайдыг 69-р тушаал,<br>4. СБС төрлийн хам полимер битум барьцалдуулагчийг ашиглан полимер асфальтобетон хучлага барих техникийн баримт бичгийг ЗТХ-ийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 70 дугаар тушаалаар тус тус батлуулсан.<br>Авто тээврийн салбарын (ТХ15) стандартчиллын техникийн хорооны хуралдааны 2019 оны 3 дугаар сарын 01-ний өдөр хуралдааны дүгнэлтийг үндэслэн Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн С/12 дугаар тушаалаар дараахь 3 үндэсний стандартыг шинээр баталсан.Үүнд:<br>5. Ачаа тээврийн автомашин болон чиргүүлийн бүтээлэг. Ерөнхий шаардлага MNS 6756:2019<br>6. Автомашины дизель хөдөлгүүрийг утааны тортгийн шүүлтүүр(DPF)-ээр тоноглох, ашиглах. Техникийн ерөнхий шаардлага. MNS 6757: 2019<br>7. Цахилгаан тээврийн хэрэгслийг цэнэглэх станцын төрөл, тоноглолыг суурилуулах болон байруулахад тавих. Ерөнхий шаардлага MNS6758:2019<br>8. Авто тээврийн салбарын (ТХ15) стандартчиллын техникийн хорооны хуралдааны 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хуралдаанаар | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Автотээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг 1 дүгээр хэсэг:Ерөнхий шаардлага MNS4410-1:2002 стандартад нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлээд байна.<br>9. Зүтгүүр болон вагоны хос дугуйд хэмжил хийхэд ашиглах хэмжих хэрэгсэл ба хүлцэл шалгах хэрэгслийн шалгалт тохируулгын арга" MNS 5842:2019 стандартыг шинэчлэн боловсруулж, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн С/01 дүгээр тушаалаар батлууллаа.<br>Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн С/11 дугаар дараах 3 стандартыг батлуулаад байна.<br>10. Төмөр замын тээврийн техникийн найдвартай байдлын үндсэн ойлголт. Нэр томьёо, тодорхойлолт MNS6387-5:2019<br>11. Төмөр замын ачааны вагоны барилга байгууламжийн зураг төслийн шаардлага MNS TB 10031:2019<br>12. Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний тоормосны нэр, томьёо тодорхойлолт MNS 14478:2019<br>2018 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн Авто замын стандартчиллын техникийн хорооны хуралдаанаар дараах стандартыг хэлэлцүүлж батлуулаад байна:<br>13. Авто зам, нисэх онгоц хөөрөх, буух зурваст хэрэглэх органик барьцуулагч материал. Асфальтбетон болон полимерасфальтбетон хольц. Техникийн шаардлага MNS GOST 9128:2019<br>14. Авто зам, нисэх онгоц хөөрөх, буух зурвасын барилгын ажилд хэрэглэх органик барьцуулагч материал. Турших арга. MNS GOST 12801:2019<br>15. Чулуун мастик асфальтбетон болон хольц. Техникийн шаардлага MNS GOST 31015:2019<br>16. Авто замын байгууламжийн материал: ГГР-ээр битумын гулзайлтын хөшүүн чанарыг тодорхойлох туршилтын арга: MNS ASSHTO T313:2019<br>17. Авто замын байгууламжийн материал. Эргэлдэгч вискозиметрээр битумын зунгааралтыг тодорхойлох туршилтын арга: MNS ASSHTO T316:2019<br>18. Авто замын байгууламжийн материал. Битумд олон удаагийн ачаалал өгсөний дараах хэв гажилтыг дахин сэргээлтийг ДШР-ээр тодорхойлох туршилтын арга: MNS ASSHTO TP70:2019<br>Нэмэлттэй хүйтэн асфальтбетон хольцын туршилтын аргын заавар"-тай холбогдох 2 техникийн баримт бичгийг боловсруулж, ам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 193, 194 дугаар тушаалаар тус тус батлуулсан.<br>19. Авто тээврийн салбарын (TX15) стандартчиллын техникийн хорооны хуралдааныг 2019 оны 6 дугаар сарын 10-ний өдөр зохион байгуулсан. Уг хорооны хуралдааны дүгнэлтийг үндэслэн Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн С/19 дугаар тушаалаар Авто тээврийн хэрэгслийн улсын дугаар тэмдэг MNS 4410-1:2002 стандартад нэмэлт өөрчлөлт оруулсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 20. Хар тугалганы хүхрийн хүчлийн аккумуляторыг цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлагын стандарт”-ын төслийг Автотээврийн стандартчиллын техникийн хорооны 2019 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.<br>21. Иргэний нисэхийн салбарын (ТХ34) стандартчиллын техникийн хорооны хуралдааныг 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулж, Аэрдром. Хэлипортод тавигдах шаардлага. MNSxxxx:2019 стандартын төслийг хэлэлцэж батлахаар шийдвэрлэв**.** | |
| 79 | 2.119. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан автозамын сүлжээг сайжруулах зорилгоор Баянзүрх, Яармаг, Сонсголонгийн гүүр болон Улаанбаатар-Налайх чиглэлийн автозамыг шинээр барина. | 1. Улаанбаатар хотын зүүнээс баруун чиглэлд 36 км Туул хурдны авто замын барилгын ажлыг эхлүүлэх | 2019-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | 89,220.0 | Барилгын ажлыг эхлүүлэх | 29,740.0 | **АЗБХЗГ:**<br>Улаанбаатар хотын зүүнээс баруун чиглэлд 36 км Туул хурдны авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг “Гудамж” төслийн хүрээнд хийгдэж бэлэн болсон. **Хөрөнгө оруулалт шийдвэрлэгдээгүй тул хэрэгжих боломжгүй.** | - |
| 80 | | 2. Улаанбаатар хотын урдаас хойш чиглэлд 25.3 км Сэлбэ хурдны авто замын барилгын ажлыг эхлүүлэх | 2019-2022 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | 112,425.0 | Барилгын ажлыг эхлүүлэх | 37,475.0 | **АЗБХЗГ:**<br>Улаанбаатар хотын урдаас хойш чиглэлд 25.3 км Сэлбэ хурдны ТЭЗҮ-гийн судалгааг “Гудамж” төслийн хүрээнд хийгдэж бэлэн болсон. **Хөрөнгө оруулалт шийдвэрлэгдээгүй тул хэрэгжих боломжгүй.** | - |
| 81 | | 3.Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замд өргөтгөл, шинэчлэл хийх | 2017-2019 | Гадаад зээл | 73 620,0 | Барилгын ажлыг дуусгах | 40,900.0 | **АЗБХЗГ:** Засгийн газрын 2015 оны 309 дугаар тогтоолоор төслийн ажлыг БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу төслийн гүйцэтгэгч “Синохайдро корпораци лимитед” компанитай 2016.09.09-ний өдөр барилгын ажлын гэрээ, 2017.04.17-ны өдөр “Гуанжоу Ванан Констракшн Супервишн” ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. /Төслийн нийт өртөг 38.2 сая ам.доллар. Хэрэгжүүлэх хугацаа 24 сар/<br>Захиалагчийн зүгээс Баянзүрхийн товчоо орчмын газар чөлөөлөлтийн нөлөөлөл ихтэй авто замын трассыг өөрчлөхөөр шийдвэрлэсний дагуу зургийн зохиогч замын трассын эхний 5км-т өөрчлөлт оруулан зураг төслийг боловсруулж дууссан.<br>Нийслэлийн Газрын албанаас 2017.09.25-ны өдөр төслийн газар чөлөөлөлтийн ажлыг бүрэн хэрэгжүүлж дууссан. Нийслэлийн ЗД-ын 2017.08.22-ны өдрийн А/617 захирамжаар 3 байршилд авто замын барилгын ажилд ашиглах карьерын зөвшөөрөл олгосон. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ЗГ-ын 2017.08.08-ны өдрийн 222 дугаар тогтоолоор төслийн Монголын талын хариуцах зардал 15%-ийг 5% болгон өөрчлөн баталсан.<br>Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулж, БОАЖЯ-нд хүргүүлсэн.<br>Уг төслийн ерөнхий гүйцэтгэгчээр Синохайдро Корпорейшн Лимитед компани 2016 онд шалгарч гэрээ байгуулсан бөгөөд тус компанитай хэлэлцээ хийж, арилжааны гэрээг 2019.03.12-ны өдөр шинэчлэн байгуулж Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 300 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2019.02.20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн.<br>Ерөнхий гүйцэтгэгч Синохайдро Корпорейшн Лимитед компани Монголын үндэсний аж ахуйн нэгжүүд болох “Дардан говь” ХХК, “Тэгш плант” ХХК, “Гашууны гол” ХХК зэрэг нийт 3 туслан гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын барилгын ажлыг 2019.04.20-ны өдрөөс эхлүүлж, 2019.11.04-ний өдөр 4 эгнээ авто замын зорчих хэсгийг дуусгаж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээгээд байна. Энэхүү авто замын хуучин цементбетон хучилтыг хуулж зөөх ажил 100%, ухмал 100%, далангийн дүүргэлт 100%, 38 цэгт баригдах ус зайлуулах хоолойн ажил 100%, 3 ш нүхэн гарц буюу түннелийн ажил 100%, Хөлийн голын төмөрбетон гүүрийн ажил 100%, үндсэн 20.9 км авто замын суурь асфальтбетон хучилтын ажил 100%-тай байна.<br>Үлдэгдэл ажлууд болох төмөр туузан хашлага, суурьшлийн бүсийн хэсгүүдийн 5.1 км явган хүний болон дугуйн зам, 5 цэгт явган хүний гүүрэн гарц, өнгө асфальтбетон хучилт буюу 4 см-ээр нэмж хучих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн 2020 оны 7 дугаар сард багтаан бүрэн ашиглалтад оруулна. | |
| 82 | | 4.Туул гол дээгүүрх Баянзүрхийн 288 урт метр болон Сонсголонгийн 289.4 урт метр төмөр бетон гүүрийг барих | 2017-2019 | Гадаад зээл | 40 635,0 | Барилгын ажлыг дуусгах | 22,575.0 | **АЗБХЗГ:**<br><u>2017 онд</u>: Тус төслийг ЗГ-ын 2015 оны 309 тогтоолоор хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу төслийн гүйцэтгэгч “Бээжин Юни-Констракшн Групп” компанитай 2016.07.18-ны өдөр барилгын ажлын гэрээг, 2017.04.17-ны өдөр “Гуанжоу Ванан Констракшн Супервишн” ХХК-тай хяналтын зөвлөх үйлчилгээний гэрээг тус тус байгуулсан. /Төслийн нийт өртөг 21,4 сая ам.доллар, хэрэгжүүлэх хугацаа 22 сар/<br>Төслийн хүрээнд одоо байгаа Сонсголонгийн гүүртэй паралеллиар 2 эгнээ гүүр шинээр барих ба Налайх чиглэлийн авто замын трассын дагуу Баянзүрхийн гүүрийн ойролцоо шинээр 4 эгнээ гүүрийн барилга угсралтын ажил хийгдэнэ.<br>Газар чөлөөлөлтийн ажлыг багасгах үүднээс Налайх чиглэлийн авто зам болон Баянзүрхийн гүүрийн зураг төсөлд өөрчлөлт оруулж дууссан. Хятадын Эксим банк, МУ-ын Сангийн яам хооронд 2017.05.12-ны өдөр байгуулагдсан төслийн тусгайлсан зээлийн гэрээ 2017.10.16-ны өдөр хүчин төгөлдөр болсон. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 2018 онд: Хятадын Эксим банкнаас төслийн урьдчилгаа төлбөрийг шийдвэрлэснээр, барилгын ажлыг 2018 онд эхлүүлсэн ба энэ онд нийт ажлын 40 хувийг хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.•БНХАУ-ын Эксим банк Сангийн яам хооронд байгуулсан тусгайлсан зээлийн гэрээний дагуу гүйцэтгэгч компанид урьдчилгаа төлбөр орсноор 2018.04.11-ний өдрөөс ажил эхлүүлэх мэдэгдэл өгч, барилгын ажлын эхлүүлсэн.<br>1. Баянзүрхийн гүүр: Ажилчдын амрах байр болон үйлдвэрлэлийн талбай, кэмп байгуулах ажил хийгдсэн. Нийт 60ш гадсан суурийн ажил хийгдэхээс 37 суурийн өрөмдлөгийн ажил болон бетон цутгалтын ажил хийгдсэн. 29 суурийн арматурын хэлхээс бэлтгэх ажил хийгдсэн. Завсарын 1, 2 дугаар тулгуур багана болон захын 1 тулгуурын ажил хийгдсэн. Хуваарилах хавтангийн арматурын хэлхээс бэлтгэх болон тулгуурын арматурын хийц бэлтгэх ажил хийгдсэн.<br>2. Сонсголонгийн гүүр: Туслан гүйцэтгэгчээр “Гангүүр” ХХК ажиллаж байгаа бөгөөд ажилчдын амрах байр болон үйлдвэрлэлийн талбай, кэмп байгуулах ажил хийгдсэн. Завсрын 12ш худган суурь хийхээс 12ш худган суурийн бетон цутгалтын ажил хийгдсэн. Захын тулгуурын суурь болон ар хана, далавчны цутгалтын ажил хийгдсэн байна. Ригель дам нурууны арматур зангидах ажил хийгдэж байна.<br>2019 онд: Гүүрийн барилгын ажлыг 2019.04.01-ний өдөр эхлүүлсэн. Төслийн хүрээнд Сонсголонгийн гүүрийг засварлаж, шинээр 289.4 у/м, 21.9 м өргөнтэй, 2 эгнээ төмөрбетон гүүрийг параллелаар шинээр барьж өргөтгөх ба Налайхын чиглэлийн шинэ замын дагуу Баянзүрхийн гүүрийн ойролцоо шинээр 281.2 у/м, 22.6 м өргөнтэй, 4 эгнээ, үргэлжилсэн хайрцган дам нуруу бүхий төмөрбетон гүүрийн барилга угсралтын ажил хийгдсэн. **Сонсголонгийн гүүрийн барилгын ажлын гүйцэтгэл 100%-тай.** Комисст хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажил хангагдаж байна.<br>Баянзүрхийн гүүрийн барилгын ажил дуусч авто замын зорчих хэсгийн хөдөлгөөнийг нээсэн бөгөөд үерийн хамгаалалтын далангийн ажил, нөхөн сэргээлт, явган хүний замын хавтан суурилуулах ажлуудыг 2020 оны 06 сард багтаан дуусгахаар төлөвлөн ажиллаж байна. **Баянзүрхийн гүүрийн барилгын ажлын гүйцэтгэл 93.55%-тай.** | |
| 83 | 2.120. Улаанбаатар хотын автозамын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор гүүрэн гарцуудыг шинээр | 1.Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй тээврийн шинэ төрөл нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх | 2016-2020 | Гадаад эх үүсвэр | 310 500,0 | Төслийг эхлүүлэх | 147,500.0 | **АТБХЗГ:** Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр BRT /тусгай замын автобус/ төслийн удирдах хорооны төлөвлөгөөний дагуу тусгай замын автобусны авто замын трассыг тогтоох, зураг төслийг боловсруулах зөвлөх багийг сонгон шалгаруулах тендер зарласан. Уг тендерт 20 компани оролцох хүсэлт илэрхийлсэн бөгөөд үнэлгээний хороо хураангуй жагсаалтаар нийт 6 компанийг шалгаруулж, богино жагсаалтаар шалгарах аж ахуйн нэгжийг шалгаруулж, гэрээ байгуулахаар ажиллаж байна. Зөвлөх баг нь 3 үе шаттайгаар зураг төслийн ажлыг хийх бөгөөд 2018 оны 11-12 дугаар сард эхний зураг төслөөр хийх барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулна. | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулан, тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлнэ. | | | | | | | Төлөвлөгөөгөөр 2019 оны 05 дугаар сард эхний үе шатны барилгын ажил эхэлнэ.<br>GEF MON-0315 буюу төслийн бүрэлдэхүүн хэсэг Дэлхийн байгаль орчны сангийн 1,5 сая ам долларын буцалтгүй тусламжийн хүрээнд хийгдэх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын төслийг эцэслэж НЗДТГ-аас санал авахаар ажиллаж байна. Улаанбаатар хоттой ойролцоо бусад орны хотуудад ТЗА-ны төсөл хэрэгжсэн Study tour буюу туршлага судлах аяллыг Казакстан улсын Алма-Ата, БНХАУ-ын Ичанг хотуудад 2018.03.03-11 хооронд зохион байгуулсан. Нийлэлийн ЗД-ын 2018.07.10-ны өдрийн А/633 дугаар захирамжаар байгуулагдсан Техникийн ажлын хороо 2018.08.28-ны өдрийн хурлаар “Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Төсөл 1”-ийн санхүүжилтийн 1 дүгээр үе шатанд хэрэгжүүлэх Тусгай замын автобусны коридорын чиглэл, тусгай замын автобусны Ухаалаг тээврийн системийн “Хяналт, удирдлагын төв”-ийг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.<br>Төслийн удирдах хороо 2018 оны 11 дүгээр сарын 02, 06, 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр тус тус хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гаргасан. Үүнд:<br>1. “Тусгай замын автобусны сүлжээний чиглэл, коридоруудын хэрэгжүүлэх дараалал”-ыг тогтоохдоо:<br>1 дүгээр үе шатанд буюу Коридор 1А-г Чингис Хаан олон улсын нисэх онгоцны буудал, Наадамчдын зам, Яармагийн гүүр, Чингисийн өргөн чөлөө, Сүхбаатарын талбай чиглэлд нийт 14.9 км зам;<br>2 дугаар үе шатанд: Коридор 1Б-г Сүхбаатарын талбай, Их сургуулийн гудамж, Сүхбаатарын гудамж, Ногоон нуурын гудамж, Алтайн гудамж, Чингэлтэйн өргөн чөлөө, 7-н буудлын автобусны эцсийн зогсоол буюу нийт 7.8 км зам; Коридор 2-г Саппорогийн уулзвар, Ард-Аюушийн өргөн чөлөө, Энэбишийн өргөн чөлөө, Их тойруу, Намьянжугийн гудамж, Их хүрээ гудамж, Дүнжингарав олон улсын худалдааны төвийн уулзвар буюу нийт 10 км замын чиглэл; зэрэг болно.<br>2. “Төсөл хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”<br>3. “Захиалагчийн 2019 онд бараа ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө”<br>4. “2019 оны санхүүжилтийн төлөвлөгөө”-г тус тус баталсан.<br>ТЗА-ны дэд бүтцийн инженерийн нарийвчилсан зураг төсөл, УТС-ийн зураг төслүүдийг боловсруулах ажлын даалгаварын цар хүрээнд өөчлөлт оруулж дахин боловсруулж байна. Төслийн төлөвлөгөө, тайлан, биелэлтийг улирал бүр авч, мэдээлэл солилцон ажиллаж байна.<br>Энхтайваны гүүрийн баруун талд Моннисын уулзварын хойд талын туслах замаас Нарны зам болон төмөр зам доогуур нүхэн гарц гаргаж, улмаар Дунд гол дээгүүр төмөрбетон гүүр барин ХУД-ийн 19-р хорооллын арын буюу Үйлдвэрийн гудамж руу холбосон шинэ гудамж замын төсөл хийгдсэн сонгон шалгаруулалт хийгдэхээр ажиллаж байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 1-р шатны коридорын хүрээнд инженерийн нарийвчилсан зураг төслийг гаргах зургийн тендерийг зарласан бөгөөд зөвлөх компанийг сонгох ажил хийгдэж байна. Барилгын ажлын тендерийн материалыг боловсруулж байгаа бөгөөд 3-р улиралд багтаан Азийн хөгжлийн банканд хүргүүлэхээр ажиллаж байна.<br>Төслийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хавсралт 2-т заасан нийт 5 бүрэлдэхүүн ажлын төлөвлөгөө ёсоор ТЗА-ны /Тусгай замын автобус/ сүлжээ байгуулахад шаардагдах дэд бүтцийн бэлтгэл ажил 2014 -2019 онуудад улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн. /Эрэлийн уулзвар, Цагаан хаалганы уулзвар, Гадаад харилцааны яамны уулзвар, Өлзий төв уулзвар гэх мэт/<br>2018, 2019 онуудад төслийг хэрэгжүүлэх зорилгоор нийт 16 тендерийн материалын төслийг Азийн хөгжлийн банканд хүргүүлсэн боловч тендер зарлахтай холбоотой хариу ирүүлээгүй.<br>Мөн дээр дурдсанчлан Азийн хөгжлийн банкны зохих зөвшөөрөл хугацаа удсан зэрэг бодит шалтгаан байсан хэдий ч Сангийн сайдын 2019.11.13-ны өдрийн 01/5339 тоот албан бичгээр тус төслийн үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргаад байгаа бөгөөд НЗДТГ энэхүү байр суурийг хүлээн зөвшөөрөх боломжгүй, төслийг үргэлжлүүлэх байр сууриа илэрхийлээд байна.<br>Сангийн сайд, Нийслэлийн Засаг дарга нарын 2019.12.13-ны өдрийн албан уулзалтын үеэр Нийслэлийн Засаг дарга тусгай замын автобусны нэвтрүүлэх төслийг цааш дахин үргэлжлүүлэх хүсэлтийг Сангийн сайдад тавьсан бөгөөд уг төслийг эрчимжүүлэх талаар судлахаа Сангийн сайд илэрхийлсэн. | |
| 84 | 2.121. Автозамын засвар арчлалтын хугацааг уртасгах, чанарыг сайжруулах, хөрөнгийн эх үүсвэрийг үе шаттай нэмэгдүүлнэ. | 1.Олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээний бэлэн байдлыг жилийн туршид хангах, арчлалт, засварын ажлыг норм, нормативын дагуу хийж гүйцэтгэх | 2016-2020 | Улсын төсөв | 189 810,0 | Арчлалт, засварын ажлыг норм, норматив ын дагуу хийж гүйцэтгэх | 50,000.0<br><br>2019 онд 9.870,7 | **АЗБХЗГ:**<br><u>2018 онд:</u> Улсын төсөвт олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажилд 20.0 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд замын чиглэл, хариуцагч компани бүрээр хучилтын төрөл, насжилт, хөдөлгөөний эрчимтэй уялдуулан 2018 оны төлөвлөгөөг гаргаж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 38 дугаар тушаалаар батлуулан төрийн өмчит 20, хувийн хэвшлийн 8, нийт 28 зам хариуцагч компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Сайдын тушаалаар батлагдсан нийт 48 цэгт 2018 оны 1,2,3, 11,12 дугаар саруудад өвлийн арчлалтын “Шуурхай ажлын хэсэг” гарч Олон улсын болон улсын чанартай 12967 км авто зам, замын байгууламжийн өдөр тутмын байнгын бэлэн байдлыг ханган ажиллаж байна.<br>Замын ашиглалт, засварын хэлтсийн мэргэжилтнүүд 2018 онд хийгдэх засварын ажлын төрөл, тоо хэмжээг газар дээр нь явж тогтоон засварын ажлын график төлөвлөгөөг гарган батлуулж хэрэгжүүлэн ажилласан. **Ажлын биелэлт 99.8 хувьтай** хэрэгжсэн.<br>Олон удаагийн давтамжтай орсон аадар борооны улмаас үер бууж 19 аймгийн нутаг дэвсгэрт хамаарах 56 байршилд нийт 178 км урт улсын | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | чанартай авто зам, замын байгууламжид гэнэтийн эвдрэл, гэмтэл үүсгэсэн. Үерийн улмаас эвдэрсэн авто зам, замын байгууламжийн талаарх мэдээллийг тухай бүр нь авч холбогдох байгууллагуудтай хамтран шаардлагатай арга хэмжээг шуурхай авч, зам хариуцагч байгууллагуудаар тухай бүрд нь засварлуулж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулан ажиллаж байна. Үүссэн эвдрэл гэмтлийн тоо хэмжээг газар дээр нь тогтоож, сэргээн засварлах ажлын төсвийг гаргаж Улсын онцгой комисстой хамтран Засгийн газрын 2 удаагийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын 2018 оны 230, 238 дугаар тогтоолуудаар 1.88 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлж хэрэгжүүлэн ажилласан.<br>2019 онд: Улсын төсөвт улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажилд 30.0 тэрбум төгрөг төлөвлөгдсөн бөгөөд 2019 оны төлөвлөгөөг замын чиглэл, хариуцагч компани бүрээр хучилтын төрөл, насжилт, хөдөлгөөний эрчимтэй уялдуулан гаргаж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 288 дугаар тушаалаар батлуулж, зам хариуцагч төрийн өмчит 20, хувийн хэвшлийн 12 нийт 32 компанитай гэрээ байгуулан, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 30%-ийн урьдчилгаа санхүүжилтийг олгосон. Өвлийн арчлалтын 47 цэгт "Шуурхай ажлын хэсэг" гарч ажилласан.<br>Олон улсын болон улсын чанартай 14918.7 км авто зам, замын байгууламжийн өдөр тутмын байнгын бэлэн байдлыг ханган ажиллаж байна.<br>Энэ онд хийгдэх замын засвар арчлалтын ажил **2019.12.02-ны өдрийн байдлаар 92%-тай** хэрэгжиж байна. | |
| 85 | | 2.Улаанбаатар -Дархан-Алтанбулаг, Улаанбаатар-Арвайхээр, Дархан-Эрдэнэт, Улаанбаатар-Чингис, Налайх-Чингис чиглэлийн нийт 504 км авто замд их засвар шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэх | 2016-2020 | Улсын төсөв | 226 800,0 | 378 км авто замд их засвар, шинэчлэлийн ажил хийж гүйцэтгэх | 56,700.0 | **АЗБХЗГ:**<br>Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2016 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Налайх-Тэрэлж чиглэлийн **30.2 км**, Элсэнтасархай-Хархорины Орхоны гүүр чиглэлийн **77 км** нийт 107.2 км авто замын их засвар, шинэчлэлтийн ажлыг Улсын ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалтхаан-Чингис хот чиглэлийн 100 км авто замын 1-р ээлжийн **17 км** авто замын их засварын ажлыг "Наранбулаг хан" ХХК, "Анандын зам" ХХК-ийн түншлэлээр гүйцэтгүүлж, 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр улсын ашиглалтад оруулсан.<br>Баян-Өлгий аймгийн Өлгий сумын **4.5 км** авто замын шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэхээр "Жол" ХХК гэрээ байгуулан ажиллаж, гэрээт ажлыг бүрэн дууссан. Улсын ашиглалтад хүлээн авсан.<br>Ховд аймгийн Жаргалант сумын **3.784** км авто замын шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэхээр "Түмдэлгэрэх" ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж гэрээт ажлыг бүрэн дууссан. Улсын ашиглалтад хүлээн авсан.<br>2018 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр олон улсын чанартай АН-3 чиглэлийн Улаанбаатар-Дархан-Алтанбулаг чиглэлийн авто замд 60.0 сая доллараар их засвар, шинэчлэлт хийхээр Засгийн газраар хэлэлцүүлж, шийдвэрлээд байна. Зээлийн хэлэлцээр батлагдсан. | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 2018 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-өлгий аймгийн Өлгий сумын төвийн **10.4 км** авто замын их засвар, шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэхээр “Жол” ХХК-тай гэрээ байгуулж, энэ онд нийт ажлын 89%-ийг гүйцэтгээд байна.<br>2019 онд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр олон улсын чанартай АН-3 чиглэлийн Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.64 км авто замд шинэчлэлийн ажлыг 5 багц болгон гэрээ байгуулж, 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдөр барилгын ажлыг эхлүүлсэн. Ажлын явц 33%-тай. Мөн нийслэл Улаанбаатар хотын авто замын сүлжээг өргөтгөж, замын хөдөлгөөний нэвтрүүлэх чадварыг дээшлүүлж, түгжрэлийг бууруулах зорилгоор Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх **20.9 км** авто замыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2 урсгалтай, 4 эгнээ бүхий авто зам болгон өргөтгөж, шинэчлэх ажлын зорчих хэсгийн ажлыг дуусгаж 2019 оны 11 дүгээр сард автотээврийн хөдөлгөөнийг нээсэн. | |
| 86 | | 3.Дархан-Эрдэнэт, Улаанбаатар-Арвайхээр, Улаанбаатар-Чингис, Налайх-Чойр, Хархорин-Цэцэрлэг, Улаангом-Хандгайт, Өлгий-Улаан байшинт чиглэлийн 725 км авто замд ээлжит засварын ажлыг гүйцэтгэх | 2016-2020 | Улсын төсөв | 145 000,0 | 543 км авто замд ээлжит засварын ажлыг хийж гүйцэтгэх | 36,250.0 | **АЗБХЗГ: 2016 онд** улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар-Дархан А0401 чиглэлийн авто замын 6 км авто замын ээлжит засварын ажлыг “Дархан АЗЗА” ТӨХК гүйцэтгэж, 2017.08.09-ний өдөр ашиглалтад хүлээлгэн өгсөн<br>**Э**элжит засвар хийх ажлын хүрээнд тус яамнаас **2017 оны төсвийн төсөлд** УБ-Арвайхээр чиглэлийн 62 км, УБ-Чойр чиглэлийн 59 км авто зам, **2018 оны төсвийн төсөлд** УБ-Арвайхээр чиглэлийн 60 км авто замд ээлжит засвар хийхээр **санал хүргүүлсэн боловч хөрөнгө шийдэгдээгүй**. .<br>2016-2018 онуудад олон улс, улсын чанартай авто замын урсгал засвар арчлалтын ажилд төлөвлөгдсөн хөрөнгөөр 40 орчим км авто замын ээлжит засварын ажил гүйцэтгэсэн.<br>2019 оны төсвийн төсөлд Налайх-Чойр чиглэлийн 50 км замд 17.5 тэрбум, УБ-Хандгайт чиглэлийн 58.35 км замд 20.4 тэрбум, Ховд-Улаангом чиглэлийн 23 км замд 8.05 тэрбум төгрөгийг тусган 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. **Ээлжит засварын ажил хөрөнгө тусгагдаагүй.**<br>2019 онд урсгал засвар арчлалтын хөрөнгөөс А0302 дугаартай Арвайхээр-Баянхонгор, А0602 дугаартай Хархорин-Цэцэрлэг чиглэлийн авто замд хэсэгчилсэн ээлжит засварын ажлыг 2.5 тэрбум төгрөгөөр "Хархорин АЗЗА" ТӨХК, "Өвөрхангай АЗЗА", 1.4 тэрбум төгрөгийн Мандалговь-Даланзадгад чиглэлийн улсын чанартай авто замд 87-104 дэх км-т хэсэгчилсэн ээлжит засварын ажлыг "АЗММ" ХХК гүйцэтгэж дуусан. | - |
| 87 | | 4.Чигэстэй, Онги, Түргэн, Цалгар, Усан хоолой, Цагаан сүм, Тэс, Хэрлэн, Буянт, | 2016-2020 | Улсын төсөв | 16 400,0 | 846.3 урт метр төмөр бетон гүүрэнд их засвар | 4,100.0 | **АЗБХЗГ:**<br>2016 онд: Улсын чанартай авто замын урсгал засвар, арчлалтын ажлын хөрөнгөөр Чигэстэй голын 54 у/м, Цагаан сүмийн 51 у/м гүүрэнд засварын ажлыг хийж дуусгасан. Нийт **105 у/м** гүүрэнд засварын ажил хийсэн.<br>2017 онд: Архангай аймгийн Тариат сумын Тэрхийн голын 217.1 у/м төмөр бетон гүүрийн их засварын ажлыг 3.152 тэрбум төгрөгийн хөрөнгөөр | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хуурай хөндий, Хараагийн нийт 1128.5 урт метр төмөр бетон гүүрэнд их засвар шинэчлэлийн ажил хийх | | | | шинэчлэл тийн ажил хийж гүйцэтгэх | | “Хурдны зам” ХХК гэрээ байгуулан гүйцэтгэж дуусссан. Комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан. 2017.12.22-ны өдрийн 07/22/17 дугаар актаар баталгаажуулсан.<br>Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замд байрлах Тарнын голын 48.2 у/м төмөр бетон гүүр үерийн улмаас гэнэтийн эвдрэл гарч нурсан тул 2017 оны урсгал засвар арчлалтын ажлын хөрөнгөөр засварлаж, ашиглалтад оруулсан. Нийт **370.3 у/м** гүүрэнд засварын ажил хийсэн.<br>2017 оны урсгал засвар, арчлалтын хөрөнгөнөөс 55.0 сая төгрөгөөр Алтай-Ховд чиглэлийн авто замд байрлах Ээвийн голын 24 у/м төмөр бетон гүүрийн их засварын ажлын зураг төслийг боловсруулсан.<br>2018 оны засвар, арчлалтын төлөвлөгөөнд Увс аймгийн Цалгарын голын 126.8 у/м, Баян-Өлгийн аймгийн Сагсайн голын 96.8 у/м гүүрийн ээлжит засварын ажилд шаардагдах хөрөнгийг батлуулан хийж гүйцэтгүүлсэн.<br>Дорнод аймгийн Цагаан-овоо сумын галын голын 36,7 у/м төмөр бетон гүүрийг 2018.10.15 нд барьж ашиглалтад оруулсан. “ЗМЗ” ХХК 691.5 сая төгрөгөөр гүйцэтгэсэн.<br>Ховд аймгийн Мөст сумын Бооржийн голын 30.68 у/м төмөр бетон гүүрийг 2018.10.30-нд хүлээн авсан. 2018 онд 400.0 сая зарцуулсан<br>Дархан-Уул аймгийн Дархан сумын Хараагийн 135 у/м төмөр бетон гүүрийн их засварын ажил бүрэн дуусаж хүлээн авсан. 2018 онд 644.7 сая зарцуулсан<br>Завхан Дөрвөлжин сум Чоно харайхын 47 у/м гүүр ашиглалтад орсон. 2018 онд 70.0 сая зарцуулсан<br>Хэнтий аймгийн Дадал сумын Онон голын 238.9 у/м, Увс аймгийн Гашууны голын 72 у/м төмөр бетон гүүрийн их засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо ажиллаж байна.<br>Олон улс, улсын чанартай авто замын 2018 оны урсгал засвар, арчлалтын ажлын батлагдсан төсвөөс 600.0 сая төгрөг төсөвлөж, **нийтдээ 594 у/м төмөр бетон** гүүрэнд ээлжит болон их засварын ажлыг гүйцэтгээд байна.<br>2019 онд Хэнтий аймгийн Дадал сумын Онон голын 238.9 у/м, Увс аймгийн Улаангом сумын Гашууны голын 72 у/м төмөр бетон гүүр, Дорнод аймгийн Чойбалсан сумын Хэрлэнгийн доод 264 у/м төмөр бетон гүүрүүдэд их засварын ажил гүйцэтгэж байгаагаас Хэрлэн голын **264 у/м гүүрийг** 9 сард ашиглалтад оруулж, Онон голын 238.9 у/м гүүрийн их засвар 45%, Гашууны голын 72 у/м гүүрийн их засвар 45% гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Тус 2 гүүрийн их засварын ажлыг гэрээ ёсоор 2020 онд ашиглатад оруулна. | |
| **Тэргүүлэх зорилт №3.2.2.** Шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн системийг нэвтрүүлж, мэдлэгт суурилсан инноваци, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | |
| 88 | 3.2.33. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт | 6. Зам, тээврийн салбарын эрдэм шинжилгээ, туршилт | 2017-2019 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр, төр, хувийн | 10 000,0 | Эрдэм шинжилгээ, туршилт судалгааны байгуулла | - | **БТГ :**<br>- УИХ-аар 2017.05.11-ний өдөр батлагдсан Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалт буюу Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “авто замын засвар, арчлалт, хамгаалалт, ашиглалтын нэгдсэн зохион байгуулалтаар хантан эрдэм, шинжилгээ судалгааны | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторын орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ. | судалгааны байгууллагатай болох ажлыг эхлүүлэх | | хэвшлийн түншлэл | | гатай болох | | ажил хийж, замын стандарт, норматив, техник технологийг сайжруулах үүрэг бүхий авто замын судалгаа, шинжилгээний байгууллага ажиллуулах" гэж оруулан эрх зүйн орчинг бий болгосон. Мөн хуулийн 11 дүгээр зүйлд "Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага"-эрх үүргийг тусгаж, батлуулсан.<br>МУ-ын Засгийн газрын 2019.10.02-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр Авто замын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүргийг "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-т хариуцуулан ажиллуулах шийдвэрийг гаргасаны дагуу уг төв нь авто замын салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын эрх үүрэгтэйгээр ажиллаж байна.<br>- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017.01.24-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн "Судалгаа, хөгжил, чанар удирдлагын алба"-тай байхаар оруулан батлуулснаар автотээврийн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагыг бий болгон ажиллуулж байна.<br>- Төмөр замын салбарын хувьд "Улаанбаатар төмөр зам" ХХН-ийн Замын даргын тушаалаар "Улаанбаатар төмөр зам" ХХН-ийн харьяанд "Судалгаа, шинжилгээ, технологийн төв"-ийг 2019.07-р сараас байгуулан ажиллуулж байна.<br>- Иргэний нисэхийн салбарын хувьд "ИНЕГ-ын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" ЗТХС-ын 2018 оны 151 дүгээр тушаалаар ИНЕГ-ын харьяанд "Мэдээлэл технологи, инноваци, судалгаа хөгжлийн алба"-ыг байгуулан ажиллуулж байна. | |
| 89 | | 7. Авто замын салбарт дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, цемент ашиглан цемент бетон хучилттай авто зам барьж, өртөг зардал хямд авто замын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, үндэсний стандартыг бий болгох | 2016-2020 | Гадаад эх үүсвэр | 50 000,0 | Дотоодын бүтээгдэхүүн, цементээр бетон хучилттай авто зам барих чиглэлээр Үндэсний стандарт бий болох | 10,000.0 | **БТГ:** ЗТХ-ийн сайдын 2019.03.11-ний өдрийн 67, 68, 69 дүгээр тушаалаар Цементээр бэхжүүлсэн хөрс суурь барих, Цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь барих, Асфальтбетон хучлагыг дахин боловсруулах ба цементээр бэхжүүлсэн суурь барих техникийн нормыг тус тус батлуулсан.<br>Авто замын стандартчиллын техникийн хорооны 2018.06.12-ны өдрийн хуралдаанаар МСРС gr ХХК-аас 3 стандартыг хэлэлцүүлж батлуулсан. Үүнд:<br>1. Авто зам, нисэх онгоц хөөрөх, буух зурвааст хэрэглэх органик барьцуулагч материал. Асфальтбетон болон полимерасфальтбетон хольц. Техникийн шаардлага MNS GOST 9128:2019<br>2. Авто зам, нисэх онгоц хөөрөх, буух зурвасын барилгын ажилд хэрэглэх органик барьцуулагч материал. Турших арга. MNS GOST 12801:2019<br>3. Чулуун мастик асфальтбетон болон хольц. Техникийн шаардлага MNS GOST 31015:2019<br>"Авто замын асфальтбетон хучлагын засварт хэрэглэх нэмэлттэй хүйтэн асфальтан хольц" гарын авлагыг ЗТХСайдын 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 194 дугаар, "Нэмэлттэй хүйтэн асфальтбетон хольцын туршилтын аргын заавар"-ыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 193 дугаар тушаалаар тус тус батлуулав. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Мөн цемент ашиглан цемент бетон хучилттай авто зам барихтай холбоотой дараах стандартын төслийг боловсруулж, Авто замын стандартчиллын техникийн хорооны хуралд хэлэцүүлж, батлуулав. Үүнд:<br>1. Авто замын болон нисэх онгоцны хөөрч буух зурвасын барилгын ажилд хэрэглэгдэх органик барьцалдуулагч материал. Шинжилгээний арга MNS GOST 12801: 2019;<br>2. Авто зам, нисэх онгоц хөөрч буух зурваст хэрэглэгдэх асфальтобетон, полимер асфальтобетон хольцын техникийн шаардлага MNS GOST 9128 : 2019;<br>3. Чулуун мастик асфальтбетон болон хольц. Техникийн шаардлага MNS GOST 31015 : 2019;<br>4. Нефть болон нефтийн бүтээгдэхүүн. Техникийн шаардлага MNS GOST 1510 : 2019 зэрэг болно. | |
| **Тэргүүлэх зорилт №4.1.** Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгалийн нөөц баялгийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, зохистой ашиглах, нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэн, байгаль орчинд нийцтэй, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс болгоно. Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | |
| 90 | 4.1.3. Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ авч, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна. | 1.Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, хариуцлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хүн ам болон хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах судалгаа хийх | 2017-2020 | - | - | Зам, тээврийн салбарын хог хаягдлыг ашиглах технологи боловсруулах | - | **БТГ:**<br>Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, хариуцлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хүн ам болон хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах судалгаа хийх чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>1.Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийн талаар судалгаа хийх, норм норматив боловсруулах ажлыг “Эс Ай Си Эй” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж тайлан хүлээж авсан.<br>Уг судалгааны үр дүнд үндэслэн Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019.10.11-ний өдрийн 43 дугаар тушаалаар “Ашиглалтаас гарсан хар тугалгат-хүхрийн хүчлийн батарейг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах. Ерөнхий шаардлага MNS 6783:2019” Үндэсний стандарт батлуулсан.<br>2.Зам, тээврийн салбарын хог хаягдлын зохистой менежментийн судалгаа хийх, стандарт боловсруулах, ашиглалтаас хасагдсан автомашины хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах, ашиглалтаас хасагдсан автомашин, мотоциклийн бүртгэлийн болон мэдээллийн сан бий болгох саналыг боловсруулж, ЗГ-ын 2017 оны 98 тогтоолоор батлагдсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах Үндэсний хөтөлбөр”-т тусгуулсан.<br>3.Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зам тээвэр, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хэрэгжүүлэх бүрэн эрхэд “тээврийн хэрэгслийн болон барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг батлах” заалт оруулах санал өгч, УИХ-ын 2017.05.12-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж батлуулсан. | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 4.Автотээврийн салбарын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор БОАЖЯ, Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ, НЗДТГ, ШУТИС-ийн Механик тээврийн сургууль, "Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо" ТББ зэрэг байгууллагуудтай хамтарсан хэлэлцүүлэг, уулзалтыг 2017 онд 3 удаа, 2018 онд 2 удаа тус тус зохион байгуулсан. Дээрх хэлэлцүүлэг, уулзалтаас гарсан зөвлөмж, саналыг тус яамны санхүүжилт болон олон улсын байгууллагуудтай хамтран хийж байгаа судалгааны ажил, төслүүдэд тусгаж, цаашид хамтран ажиллах нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын механизмыг бий болгохоор шийдвэрлэсэн. Уг ажлын хүрээнд ЗТХЯ, "Монголын Хог Хаягдлыг Дахин Боловсруулах Үндэсний Холбоо" ТББ-тай зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр "Хамтран ажиллах санамж бичиг"-ийг 2018.06.21-ний өдөр байгуулсан.<br>5.Нэгдсэн үндэстний үйлдвэрийн хөгжлийн байгууллага(UNIDO)-тай ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийн талаар судалгаа 2018 онд хийж, цаашид хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, чадавхыг сайжруулах техникийн туслалцааны төслийг боловсруулаад байна.<br>6. Автотээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлын менежментийг сайжруулах, хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг дахин боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор тус яам Солонгос улсын хөрөнгө оруулалттай "Монгол авто ресаикл парк" ХХК-тай хамтран ажиллах "Санамж бичиг"-ийг 2019.07.05-ны өдөр байгуулан ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг дахин боловсруулах цогц үйлчилгээний төвийн барилгын ажлыг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын 2019.01.23-ны өдрийн А/45 дугаар захирамжаар тус яаманд Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт 30 га газар олгосон бөгөөд тээврийн хэрэгслийн ашиглалтын явцад үүссэн хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, боловсруулах үйлдвэрлэлийг байгуулах чиглэлээр "Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо" ТББ-тай хамтран "Зам тээврийн салбарын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэл технологийн "Авто рисайклинг парк"-ийг байгуулан хамтран ажиллах гэрээг 2019.07.22-ны өдөр байгуулан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулан ажиллаж байна. Тус яамны Хан-Уул дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах нэгж талбарын 1781502151 дугаар бүхий 299760 м.кв /29.976 га/ газар нь Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газраас 2008 онд "Санцэнд" ХХК-д 30 жилийн хугацаатай олгосон ашигт малтмал, ашиглалтын 14302А тусгай зөвшөөрөл бүхий 189.6 га газартай давхцаж байгаа тул газрын байршлыг өөрчлүүлэх хүсэлтээ Зам, тээврийн хөгжлийн яамны 2019.11.18-ны өдрийн 03/6167 тоот албан | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | бичгээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлээд байна.<br>7. “Тээврийн хэрэгслийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын төслийг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргад 2019.09.12-ны өдөр танилцуулсан. Журмын төсөлд санал авахаар яамны вейб сайтад 2019.10.17-ны өдөр байршуулсан. Мөн холбогдох яамдууд болон төрийн бус байгууллага, холбоодуудаас санал авахаар Зам, тээврийн хөгжлийн яамны 2019.11.19-ний өдрийн 07/6207, 2019.11.21-ний өдрийн 03/6244 тоот албан бичгийг тус тус хүргүүлэн санал авч 2019.12.25-ны өдрийн дотор батлуулахаар ажиллаж байна. | |
| 91 | 4.4.5. Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу байгальд ээлтэй зогсоол, үйлчилгээний төвүүдийг олон улсын стандартад нийцүүлэн байгуулахыг дэмжинэ. | 2.Нийслэл болон аймгийн төвд улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний авто буудал барих | 2016-2020 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 57 000,0 | Нийтийн тээврийн үйлчилгээ-ний 2-3 автобуудал баригдах | 20,000.0 | **АТБХЗГ, АЗБХЗГ:**<br>ЗТХ-ийн сайд, аймгийн Засаг даргатай зам, тээврийн салбарт 2018 онд хамтран ажиллах гэрээнд автотээврийн салбарт шаардлагатай байгаа автобуудал, авто замын дагуух үйлчилгээний цогцолборын барилга байгууламжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барих-өмчлөх-ашиглах сонирхолтой аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж ажиллах заалтыг тусгасан. Улсын төсвийн хөрөнгө, “АТҮТ” ТӨҮГ-ын хөрөнгөөр дараах аймаг, сумдад автобуудал, авто замын дагуух үйлчилгээний цогцолбор барь ашиглалтад оруулсан. Үүнд:<br>1. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд автобуудлын барилгын өргөтгөл;<br>2. Хэнтий аймагт автобуудал;<br>3. Архангай аймгийн Цэцэрлэг суманд автобуудал;<br>4. Дорноговь аймгийн Сайншанд суманд автобуудал;<br>5. Төв аймгийн Лүн сумын нутаг дэвсгэрт улсын чанартай авто замын дагуу “Урьхан-2” үйлчилгээний цогцолбор;<br>6. Баян-Чандмань сумын нутаг дэвсгэрт Аглагийн хийд рүү эргэдэг уулзварын үйлчилгээний цогцолбор;<br>7. Төв аймагт улсын төсвийн хөрөнгөөр автобуудал;<br>8. Завхан аймгийн Улиастай суманд автобуудал;<br>9. Баянхонгор аймгийн Баянхонгор суманд автобуудал барьж үйл ажиллагаа эхлүүлсэн.<br>10. Увс аймгийн Улаангом сумын Цагаан дэглий нисэх буудлын барилгыг автобуудал болгон өөрчлөн тохижуулсан.<br>11. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын төвд Худалдааны төвийн барилгыг автобудал, техникийн хяналтын үзлэгийн төвийн зориулалтаар ашиглах асуудлыг ЗГ, УИХ-аар шийдвэр гаргуулж, “АТҮТ” ТӨҮГ хүлээж авсан.<br>12. Сэлэнгэ аймагт дахь “УБТЗ” ХНН-ийн автобуудлаас улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг гүйцэтгэх шийдвэр гаргуулж, үйл ажиллагаа эхлүүлсэн.<br>13. Булган аймгийн Рашаант сумын нутаг дэвсгэр “Элсэн тасархай”-т “Сод хан трэвел” ХХК, Багануур дүүрэг "Минимакс", Ховд аймгийн Дарви сумын нутаг дэвсгэрт "Бумбат цоцолбор" зэрэг улсын чанартай авто зам дагуу хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд авто замын дагуух | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үйлчилгээний барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулж үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.<br>14. Улаанбаатар хот, Ховд, Дорнод зэрэг аймгуудад шаардлагатай автобуудал, авто замын дагуух үйлчилгээний цогцолборын барилга байгууламжийг орон нутгийн концессын зүйлийн жагсаалтад оруулж, сонирхогч аж ахуйн нэгжээр барих-өмчлөх-ашиглах төрлөөр хэрэгжүүлэхээр аймаг, нийслэлийн ИТХТ-ийн шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг хангах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллаж байна. | |
| **Тэргүүлэх зорилт №5.1.** Тогтвортой, хариуцлагатай улс төрийн соёлыг төлөвшүүлж, хүчтэй, чадамжтай, хууль дээдэлсэн төрт ёсыг бэхжүүлэх зарчмыг баримтална. | | | | | | | | | |
| 92 | 5.1.3. Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах хүрээнд салбар бүрд батлагдан хэрэгжиж байгаа бодлогын уялдаа холбоог хангаж, боловсронгуй болгон үргэлжлүүлнэ. | 1.Зам, тээврийн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан шинэчлэх, шинээр боловсруулах, дэд салбарын талаар төрөөс баримтлах бодлогыг шинэчлэх | 2016-2020 | - | - | Салбарын хөгжлийн бодлого, төлөвлө-гөө, хөтөл-бөрүүдэд шинэчлэл хийж, баримт бичиг батлагдах | - | **БТГ, АТБХЗХ, ТЗДТБХЗГ, АЗБХЗГ, АТБХЗГ:**<br>- **Төрөөс автотээврийн талаар** баримтлах бодлого Засгийн газрын 2018.10.24-ны өдрийн 321 дүгээр тогтоолоор батлагдсан. Уг бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ЗТХС-ын 2018.12.12-ны өдрийн 286 дугаар тушаалаар батлуулав.<br>**- Төрөөс иргэний нисэхийн** салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогод өөрчлөлт оруулах тогтоолын төслийг Засгийн газрын 2018.05.30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн дэмжүүлсэн. УИХ-ын 2018.06.29-ний хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-ын 72 дугаар тогтоолоор батлуулсан.<br>**- Төмөр замын тээврийн** талаар төрөөс баримтлах бодлогод нэмэлтээр оруулах УИХ-ын тогтоолын төслийг 2018.05.30-ны өдрийн Засгийн газрын 23 дугаар хуралдааны тэмдэглэлээр дэмжигдэж**,** “Зүүнбаян-Ханги” чиглэлийн 280 км төмөр зам, “Эрдэнэт-Овоот” чиглэлийн 780 км төмөр замыг УИХ-ын 2018.06.29-ны өдрийн 71 дугаар тогтоолоор тус тус нэмүүлж, батлуулсан.<br>- **Төрөөс авто замын** талаар баримтлах бодлогын баримт бичгийн суурь судалгааны ажил болон гадаад зөвлөхөөс санал болгосон бодлогын хувилбарт үндэслэн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулсан. Засгийн газраас Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого /2020-2045 он/ боловсруулах шийдвэрийг гарсан. Тус урт хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахдаа салбар хоорондын бодлогын уядааг хангах зарчмыг баримтлахаар тодорхойлсон тул төрөөс авто замын талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах ажлыг түр хойшлуулахаар болсон. | 100% |
| **Тэргүүлэх зорилт №5.6.** Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого хэрэгжүүлж, гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалж, дэлхийн улсуудтай найрсаг харилцаа, улс төр, худалдаа, эдийн засаг, соёлын болон бусад салбарын хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлж, бүс нутгийн хамтын ажиллагаанд оновчтой оролцож, хилийн чанадад Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн эрх ашгийг тууштай хамгаалж, иргэд гадаадад зорчих нөхцөлийг улам сайжруулж, эх орноо гадаадад сурталчилан таниулах ажлыг эрчимжүүлнэ. | | | | | | | | | |
| 93 | 5.6.1. Монгол Улс, ОХУ-ын стратегийн түншлэл | 5.ОХУ-ын нутаг дэвсгэрээр төмөр замаар дамжин өнгөрөх | 2016-2020 | Улсын төсөв | 450,0 | Хэлэлцээрийг байгуулах | 50.0 | **ТЗДТБХЗГ:** Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Оросын Холбооны Улсын Москва хотноо хоёр улсын тээврийн салбар хариуцсан яамд 2017.08.29-ний өдөр эцэслэн тохиролцсон. Оросын талтай тохиролцсон хэлэлцээрийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | болон Монгол Улс, БНХАУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлж, худалдаа, эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, хоёр хөршийн далайн боомтыг ашиглах, тэдгээрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөлийг бүрдүүлнэ. | тээврийн нөхцөлийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах | | | | | | төслийг баталгаажуулж, гарын үсэг зурах эрхийг олгох асуудлыг Засгийн газрын 2017.11.29-ний өдрийн хуралдаанаар уг хэлэлцэн дэмжсэн.<br>2018 оны 01 дүгээр сард ОХУ-ын Тээврийн яамнаас Монгол-Оросын Засгийн газар хоорондын “Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцлийн тухай хэлэлцээр”-ийн эцэслэн тохиролцсон төсөл дээр Оросын талын нэмэлт саналыг ирүүлсний дагуу өөрчлөлт оруулсан хэлэлцээрийн төслийг ЗГ-ын 2018.02.14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн.<br>МУ-ын Зам тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ болон ОХУ-ын Тээврийн сайд Е.И.Дитрих нар Улаанбаатар хотноо 2018.06.08-ны өдөр Монгол, ОХУ-ын Засгийн газар хоорондын Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан. | |
| 94 | | 6.БНХАУ-ын нутаг дэвсгэрээр далайд гарах, дамжин өнгөрөх, олон улсын зэрэглэл бүхий авто болон төмөр замын боомт нэмж байгуулах асуудлыг хамтран шийдвэрлэх | 2016-2020 | Улсын төсөв | 650,0 | Яриа, хэлэлцээ хийх | 200,0 | **БТГ, ТЗДТБХЗГ, АЗБХЗГ, АТБХЗГ:** БНХАУ-ын дарга Си Зиньпин 2014 онд Монгол Улсад хийсэн Төрийн айлчлалын үеэр 1991 оны “Монгол Улс Хятад Улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай МУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг шинэчлэн, Хятадын Зүүн хойд бүс нутгийн Дандон, Далиан, Жиньжөү, Инкоу, Чинхуандао, Тяньжин, Хуанхуа зэрэг гадаад худалдааны нээлттэй боомтыг далайд гарцгүй МУ-ын ачааг далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэрт ашиглах нөхцөл нээгдсэн.<br>Төрийн айлчлалын үеэр “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр”-ийг шинэчлэн байгуулах тухай МУ-ын Зам, тээврийн хөгжлийн яам, БНХАУ-ын Төмөр замын газар хоорондын Харилцан ойлголцлын Санамж бичигт гарын үсэг зурсан. Шинэчлэн байгуулах хэлэлцээрт шинээр хилийн төмөр замын 4, авто замын 1 гарцын харилцааг зохицуулахаар нэмж тусгасан. Үүнд:<br>- Гашуун Сухайт – Ганц Мод,<br>- Шивээхүрэн – Сэхэ,<br>- Бичигт – Зүүн Хатавч,<br>- Сүмбэр – Рашаан зэрэг хилийн төмөр замын боомт<br>- Цагаандэл уул – Өлзий авто замын боомт шинээр байгуулах зэрэг болно.<br>ГХЯ-тай хамтран Шивээхүрэн-Сэхэ, Бичигт-Зүүнхатавч, Ханги-Мандал хилийн боомтын холболтын цэгийг тодорхойлсон. Тавантолгой-Гашуунсухайт, Нарийнсухайт-Шивээхүрэн, Хөөт-Бичигт, Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замуудын ТЭЗҮ-ийг боловсруулсан.<br>МУ-ын Ерөнхий сайдын 2018 оны 04 дүгээр сард БНХАУ-д хийх айлчлалын бэлтгэл ажлыг хангах, тээврийн салбарт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор ЗТХСайд Ж.Бат-Эрдэнэ 2018 оны 01 дүгээр сард БНХАУ-д айлчилсан. Айлчлалын үеэр Хятадын Тээврийн яамтай уулзаж Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замын холболтын цэгийг тохиролцох чиглэлд үргэлжлүүлэн хамтран ажиллахаар тохиролцсон.<br>ГХЯ-аас БНХАУ-ын Гадаад харилцааны яамруу 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн ноот бичгээр Гашуунсухайт-Ганцмод, Бичигт- | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зүүнхатавч, Шивээхүрэн-Сэхэ боомтуудыг 2 талын шинжтэй байнгын ажиллагаатай байхаар “Монгол-Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хүргүүлж, 2019.04.12-ны өдөр хятадын талаас зөвшөөрсөн хариуг ирүүлсэн. “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газар хоорондын ноот бичгийн төслийг 2019.07.18-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар дэмжиж, гарын үсэг зурах эрхийг сайд Д.Цогтбаатарт олгосон. Монгол-Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажиллагааны комиссын 3 дугаар хуралдаан 2019.09 сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан бөгөөд тус хуралдаанаар “Монгол-Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т нэмэлт, өөрчлөлтийг ноот бичгээр баталгаажуулахаар тохиролцсон.<br>Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой-Баруунналан чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс “Цагаандэл уул” хилийн боомт хүртэлх 270 км авто зам болон Зорчигчийн хоол бэлтгэх зориулалт бүхий Кэтерингийн барилгыг барьж, үйлчилгээ үзүүлэх төслүүдийг зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх төрлөөр уралдаант шалгаруулалт явуулах нөхцөлөөр Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад ЗГ-ын 2017.09.22-ны өдрийн 277 дугаар тогтоолоор оруулсан.<br>Тавантолгой-Цагаандэл-Уул чиглэлийн авто замын концесс олгох уралддаант шалгаруулалтыг 2018.03.02-ны өдөр зарласан.<br>“Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай ОХУ, МУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2016.12.08-ны өдөр байгуулсан бөгөөд хэлэлцээрийг УИХ-ын чуулганы 2018.04.12-ны өдрийн хуралдаанаар соёрхон баталсан. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд автотээврээр БНХАУ-ын нутгаар дамжин Тяньжин боомт хүртэл тээвэрлэлт гүйцэтгэх эрх зүйн орчин бүрдэж байгаа юм. Хэлэлцээрийг хэрэгжүүлэх хамтарсан хорооны хурлыг 2019 оны 04 дүгээр сард багтаан хятадын тал зохион байгуулахаар болсон.<br>Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замын хилийн холболтын цэгийг тохирох, 2004 оны “Монгол-Хятадын хилийн боомт болон тэдгээрийн дэглэмийн тухай” хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах талаар 2019.01.24-ний өдрийн 01/334 дугаар албан бичгээр санал хүргүүлсэн. Мөн Ханги-Мандал болон бусад боомтуудыг дээрх хэлэлцээрт нэмэлтээр оруулах саналыг 2019.02.22-ны өдрийн 01/762 дугаар албан бичгүүдээр тус тус хүргүүлээд байна. Тус хэлэлцээрт нэмэлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан 2019.03.11-ний өдрийн 09/1270 дугаар албан бичгээр санал авахаар ирүүлсэн. Хариу санал боловсруулахад санал өгсөн. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Тавантолгой-Цагаандэл-Уул чиглэлийн авто замын концесс олгох уралдаант шалгаруулалтыг 2018.03.02-ны өдөр зарласан "Ундрах говь" ХХК-тай гэрээ байгуулахыг зөвшөөрсөн Засгийн газрын 2018 оны 330 дугаар тогтоолын дагуу 2018 оны 12 дугаар сард концессын гэрээ байгуулсан. Одоогоор концесс эзэмшигчийн зүгээс гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлүүдийг хангахаар ажиллаж байна.<br>“Бүс ба зам” дээд түвшний уулзалт 2019.04.28-ны өдөр зохион байгуулагдсан бөгөөд тус арга хэмжээний үеэр ЗТХ-ийн сайд Б.Энх-Амгалан БНХАУ-ын Тээврийн сайдтай уулзаж, төмөр замын салбарт төмөр замын боомт нэмж байгуулах асуудлыг хамтран судлан шийдвэрлэх талаар тохиролцсон. Үүний дагуу ЗТХ-ийн сайдын 2019.05.21-ний өдрийн 156 дугаар тушаалаар Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. | |
| 95 | 5.6.5. Худалдааны гол түнш болон бусад улстай худалдааг улам хөнгөвчлөхөд чиглэсэн хэлэлцээр байгуулах чиглэлээр холбогдох судалгааг эхлүүлж, худалдааны тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулна. | 1.Гуравдагч улсаас БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин Монгол Улсад импортлогдож буй бараа, бүтээгдэхүүний тарифын болон тарифыг бус хориг саадыг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааг шат дараалалтайгаар зохион байгуулах | 2016-2020 | Улсын төсөв | 730,0 | Хориг саадыг арилгах чиглэлээр ажиллаж тодорхой ахиц гаргах | 160,0 | **БТГ:** Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар 2018.01.31-ний өдөр Монголын Тээвэр зуучдын нэгдсэн холбооны төлөөллийг хүлээн авч уулзсан. Уулзалтаар Монгол Улсад хуурай боомтын үйл ажиллагааг эхлүүлэх шаардлага, түүний ач холбогдлын талаар санал солилцон, хуурай боомтын үйл ажиллагааг эхлүүлэхэд хөрш орнуудтай гэрээ хэлцэл хийх, хуурай боомтын үйл ажиллагаа явуулж байгаа орнуудын эрх зүйн орчныг судлах асуудал чухал байгааг уулзалтад оролцогчид илэрхийлсэн. Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар энэхүү ажилд дэмжлэг үзүүлэхээ илэрхийлээд, хуурай боомтын үйл ажиллагааг эхлүүлэхэд судалгаа хийх, эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг ГХЯ, ЗТХЯ, Тээвэр зуучийн нэгдсэн холбооны төлөөлөл оролцуулан байгуулах, уг асуудлыг ЗГ-ын хуралдаанд оруулан хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Ерөнхий сайдын 2018.05.23-ны өдрийн № 104 дугаар захирамжаар Монгол Улсад олон улсын хуурай боомт байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг судалж санал боловсруулах, гадаад улс, олон улсын байгууллагын дэмжлэг авч, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хангах үүрэг бүхий Гадаад хэргийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүний дэд дарга-Зам, тээврийн хөгжлийн сайд, гишүүн-Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, нарийн бичгийн дарга-Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн нар тус тус орсон болно. Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд зам, тээврийн саналыг боловсруулж ГХЯ-д хүргүүлсэн. Худалдаа, тээврийг хөнгөвчлөх зорилго бүхий “НҮБ-ын худалдаа, тээврийн байршлын код” **(UN/LOCODE National Focal Point)-**ын Зам, тээврийн хөгжлийн яам Монгол Улсыг төлөөлж ажиллаж байна.<br>Хилийн боомтын үндэсний зөвлөлийн ээлжит 2 дугаар хуралдаанаар хэлэлцэх асуудалд Замын-Үүдийн бүс нутгийн логистикийн төвийн үйл ажиллагааг хуурай боомтын статустай болгох асуудлыг хэлэлцүүлэх саналыг 2018.11.20-ны өдрийн 02/5582 тоот албан бичгээр Хилийн боомтын үндэсний зөвлөлд хүргүүлээд байна. | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Ерөнхий сайдын 2018.05.23-ны өдрийн 104 тоот захирамжаар байгуулагдсан Монгол Улсад олон улсын хуурай боомт байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг судалж санал боловсруулах, гадаад улс, олон улсын байгууллагын дэмжлэг авч, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд санал өгсөн.<br>Мөн Олон улсын хуурай боомтын асуудал хариуцсан ажлын хэсгийн үйл ажиллагааны “Дэлхийн логистикийн өдөр”-ийг тохиолдуулан “Монголын Мэргэшсэн Зөвлөх Инженерүүдийн Холбоо” ТББ (ММЗИХолбоо), “GS1 Монгол” нийгэмлэг болон “Авто Тээврийн Үндэсний Төв” хамтран “Логистикийн 7 хоног” арга хэмжээг “Хуурай боомтын хөгжил ба шийдэл” гэсэн сэдвийн дор 2019.05.20-26-ны өдрүүдэд зохион байгууллаа.<br>Ажлын хэсгийн хурал 2019.11.08-ны-ний өдөр хуралдан ажлын хэсгийн төлөвлөгөөний биелэлтийг авч хэлэлцлээ. Ажлын хэсгийн дараагийн хурал 2019 оны 12 дугаар сард хийхээр товлогдсон бөгөөд ажлын хэсгийн хуралд Хуурай боомтын танилцуулгыг бэлдэн ГХЯ-ны ажлын хэсгийн нарийн бичигт хүргүүлээд байна. | |
| ЗУРГАА. АЙМАГ, ОРОН НУТГИЙН ТАЛААР ТУСГАЙЛАН ОРУУЛАХ ЗААЛТУУД | | | | | | | | | |
| 6.1. Архангай аймаг | | | | | | | | | |
| 96 | 1. Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, замыг гүйцээж Мянганы замд холбоно. /139 км/ | 1.Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр замыг гүйцээж Мянганы замд холбох /139 км хатуу хучилттай авто зам, гүүрийг шинээр барих/ | 2017-2020 | Улсын төсөв | 118 200,0 | Трассын дагуу 46 км хатуу хучилттай зам барих | 38,000.0 | **АЗБХЗГ:** Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна. 2017.05.08-ны өдрийн 01/1968 тоот албан бичгээр тус замын “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгуулах санал Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн боловч тусгагдаагүй. Сангийн яаманд 2018.06.13-ны өдрийн 01/2777 тоот албан бичгээр "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны төсвийн хязгаарыг батлах тухай" тогтоолын төсөлд тусгуулахаар хүргүүлсэн.<br>Мөн 2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 117,5 тэрбум төгрөгийг тусган 2019-2021 онд хэрэгжүүлэхээр 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Өгийнуур-Батцэнгэл-Их Тамир чиглэлийн 130.6 км хатуу хучилттай авто зам:<br>Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд тухайн төслийн эхний 63 км замыг 2019-2020 онд хэрэгжүүлэхээр XIII.1.1.48 дугаартайгаар тусгагдсан.<br>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019.01.10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар Архангай аймгийн Засаг дарга зохион байгуулахаар эрх шилжсэн.<br>Тендерийг зарлаж, 2019.06.14-ний өдөр нээсэн боловч шаардлагад нийцсэн нэг ч оролцогч ирээгүй. Тендерийг дахин зарлаж 2019.08.02-нд нээсэн бөгөөд нэг ч компани оролцоогүй.<br>**2.107.3-тай давхцсан.** | - |
| 6.2. Баян-Өлгий аймаг | | | | | | | | | |
| 97 | 1. Өлгий хотын Нисэх | 1.Холбогдох байгууллагууда | 2017 | Улсын төсөв | 5 000,0 | Зураг төсвийг | 500,0 | **АТБХЗХ:** Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх **хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй** байна. | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | буудлын хатуу хучилттай зурвасыг өргөтгөж, хүнд даацын том онгоц хүлээж авах боломжийг бүрдүүлнэ. | д асуудлыг тавьж, зураг төсөл хийлгэж, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх | | | | бэлэн болгох, хөрөнгийн асуудлыг шийдвэрл үүлэх | 2017 онд зарцуул-сан<br>-<br>4,500.0<br>2018 онд зарцуул-сан | Баян-Өлгий аймгийн Өлгий хотын нисэх буудлыг тавдугаар түвшний техникийн хангамжид нийцүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлэх тухай Бүгд Найрамдах Казахстан Улсаас 2017.06.16-ны өдрийн 30/463 тоот ноот бичиг ирүүлсэн.<br>Үүний дагуу тус нисэх буудалд газрын системд тулгуурласан нарийвчлалыг өсгөх систем /GBAS/-ийг суурилуулах, түүнд тулгуурласан нислэгийн журмыг боловсруулах, ойртолтын налуу заагч систем /PAPI/-ийг зурвасын гэрлийн системийн хамт суурилуулахад хамтан ажиллах саналаа ЗТХ-ийн сайдын 2017.11.07-ны өдрийн 01/4864 тоот албан бичгээр БНКУлсаас Монгол Улсад суугаа элчин сайдад хүргүүлсэн. | |
| 6.3. Баянхонгор аймаг | | | | | | | | | |
| 98 | 1. Баянхонгор-Говь-Алтайн чиглэлийн замын Баянхонгор-Бууцагаан чиглэлийн замыг үргэлжлүүлэн барьж, ашиглалтад оруулна. | 1.Баянхонгор-Бууцагаан чиглэлийн авто замыг барьж ашиглалтад оруулах | 2017-2018 | Гадаад зээл | 136 600,0 | Авто замын ажлыг бүрэн дуусгах | 110 000,0<br>2017 онд зарцуул-сан<br>-<br>26,600.0<br>2018 онд зарцуул-сан | **АЗБХЗГ:**<br>БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Шанхай Констракшн Групп” ХХК шалгарч 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр нийт 56,785,696.10 ам.долларын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан.<br>Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 350 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2018.03.14-ний өдрийн 72 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2018.04.01-ний өдөр эхлүүлсэн.<br>**Нийт ажлын явц 100%-тай.** Улсын комисс 2019.08.06-ны өдөр ажиллаж, улсын ашиглалтад хүлээн авч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэн. Улсын комиссын 10/11/19 дүгээр дүгнэлтээр баталгаажуулсан.<br>Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замд “Макс рөуд” ХХК-тай концессын гэрээ байгуулан 2019.05.09-ний өдөр барилгын ажлыг эхлүүлсэн.<br>Зам барилгын талбайд далан, ухмал, суурь, хоолой, төмөрбетон гүүр, хучилтын ажлууд хийгдсэн бөгөөд эхний 30 км замыг 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс ашиглалтад оруулсан. Улсын комиссын 10/17/19 дүгээр дүгнэлтээр баталгаажуулсан.<br>2019 онд нийт ажлын 45%-ийг хийж гүйцэтгээд байна.<br>**2.107.4, 2.107.5-тай давхцсан.** | 100% |
| 6.4. Булган аймаг | | | | | | | | | |
| 99 | 1. Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай автозамын ажлыг хийж гүйцэтгэнэ. | 1.Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай авто замын ажлыг хийж гүйцэтгэх | 2017-2020 | Улсын төсөв | 72 000,0 | 70 км зам шинээр бариг-даж, ашиглал тад орох 2017 | 36 000,0<br>2017 онд зарцуул-сан<br>-<br>36,000.0<br>2018 онд зарцуул-сан | **АЗБХЗГ:** Инженерийн нарийвчилсан зураг төслийг 2017 онд "Ар Си Эс Си" ХХК боловсруулсан. 2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй.<br>2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 32,5 тэрбум төгрөгийг тусган 2019-2020 онд хэрэгжүүлэхээр 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br><br>**2.107.24-тэй давхцсан.** | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6.7. Дархан-Уул аймаг | | | | | | | | | |
| 100 | 1. Дархан-Шарын гол чиглэлийн 48 км авто зам, авто замын байгууламжийн ажлыг эхлүүлнэ. | 1.Дархан-Шарын гол чиглэлийн 48 км авто зам, авто замын байгууламжийг эхлүүлэх | 2017-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 29 090,5 | Замын суурийн ажил хийгдэж дуусах, асфальт бетон хучилт 50 хувь хийгдэх | 7,272.6 | **АЗБХЗГ:** Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна. Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг гадаадын зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэх төслүүдийн жагсаалтад тусган Сангийн яам, Азийн хөгжлийн банк зэрэг холбогдох байгууллагуудад саналаа хүргүүлсэн. Мөн Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар 2017.08.15-ны өдрийн 01/3569 тоот албан бичгээр Сангийн яаманд санал хүргүүлсэн. 2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй учраас төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон.<br>2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй учраас 2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад Шарын голын гүүрийг 2019 онд багтаан барихаар 1 тэрбум, 48 км авто замыг 2019-2020 онд барихаар 31 тэрбум төгрөгийг тусган 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br><br>**2.107.29-тэй давхцсан. /Хэрэгжүүлэх хугацаа 2020 он/** | - |
| 6.8. Дорнговь аймаг | | | | | | | | | |
| 101 | 1. Сайншанд-Хамарын хийдийн засмалаас салаалж, Зүүнбаян хүртэл хатуу хучилттай зам тавина. | 1.Сайншанд-Хамарын хийд чиглэлийн авто замын уулзвараас Зүүнбаян баг хүртэлх 16 км хатуу хучилттай авто замыг барих | 2017-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 9 603,0 | Ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэх | 4,800.0 | **АЗБХЗГ:**<br>Зураг төсөл хийгдсэн. Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар 2017.08.15-ны өдрийн 01/3569 тоот албан бичгээр Сангийн яаманд санал хүргүүлсэн.<br>**2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй** учраас төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон.<br>2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй учраас 2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 9,6 тэрбум төгрөгийг тусган 2019-2020 онд хэрэгжүүлэхээр 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>2019 оны төсвийн төсөлд уг төслийг хэрэгжүүлэх хөрөнгө тусгагдаагүй.<br>**2.107.30-тай давхцсан. /Хэрэгжүүлэх хугацаа 2019 он/** | - |
| 102 | 2. Сайншанд-Замын-Үүдийн засмал замаас салаалж, Бүрдэнэ Булгийн бөөрний сувилал хүртэл хатуу | Чойр-Сайншанд-Замын-Үүд чиглэлийн босоо тэнхлэгийн авто замаас Бүрдэнэ булаг бөөрний сувилал хүртэлх 18 км сайжруулсан авто зам барих | 2018 | Улсын төсөв | 90.0 | Ажлыг бүрэн дуусгах | 90.0<br><br>2018 онд зарцуул-сан | **АЗБХЗГ: 2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй** учраас төслийг хэрэгжүүлэх боломжгүй байна.<br><br>**2019 оны төсвийн төсөлд уг төслийг хэрэгжүүлэх хөрөнгө тусгагдаагүй**.<br><br>. | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хучилттай зам тавина. | зураг төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулах | | | | | | |
| 6.9. Дорнод аймаг | | | | | | | | |
| 103 | 1. Чойбалсан хотоос Хавирга, Баянхошуу, Эрээнцав хилийн боомт чиглэлд хатуу хучилттай автозам барина. | 1.Чойбалсан хотоос Хавирга хилийн боомт чиглэлд 124.5 км хатуу хучилттай авто зам барих | 2017-2018 | Улсын төсөв | 114 045,0 | 2017 онд 62 км, 2018 онд 62.5 км хатуу хучилт-тай авто зам баригдах | 55 786,0 58,259.0 2018 онд зарцуул-сан | **АЗБХЗГ:** Зураг төсөл хийгдсэн. Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан. Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна.<br>Төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга батыг сайжруулах зорилгоор “Барих-шилжүүлэх” нөхцөлтэйгөөр хэрэгжих концессын зүйлийн жагсаалтыг Улсын Их Хурал тухайн жилийн төсвийн тухай хуулийн хавсралтаар батлахаар 2017.04.14-ний өдөр Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолоор Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль батлагдах хүртэл дээрх нөхцөлтэй концессын гэрээ байгуулахгүй байхыг Засгийн газарт даалгасан. **2018 оны төсвийн тухай хуульд "Барих-шилжүүлэх" төслүүдийн жагсаалтад ороогүй.**<br>Уг төслийн санхүүжилтийг "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны төсвийн хязгаарыг батлах тухай" тогтоолын төсөлд тусгуулахаар 2018.06.13-ны өдрийн 01/2777 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Мөн 2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад тусган 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2019 оны улсын төсвийн тухай хуульд тусгагдаагүй.<br>**2.107.9-тэй давхцсан. /Хэрэгжүүлэх хугацаа 2019-2020 он/** | - |
| 104 | | 2.Чойбалсан сумаас Эрээнцав боомт чиглэлд 200 км хатуу хучилттай авто зам барих | 2017-2018 | Улсын төсөв | 95 200,0 | 2017 онд 100 км, 2018 онд 100 км хатуу хучилт-тай авто зам баригдах | 47 600,0 2017 онд зарцуул-сан<br>-<br>47,600.0 2018 онд зарцуул-сан | **АЗБХЗГ:** Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна. Тус чиглэлийн авто замын зураг төсөл хийх хөрөнгийг Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар 2017.08.15-ны өдрийн 01/3569 тоот албан бичгээр Сангийн яаманд санал хүргүүлсэн.<br><br>**2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй** учраас төслийг хэрэгжүүлэх боломжгүй байна.<br><br>**2.107.11-тэй давхцсан. /Хэрэгжүүлэх хугацаа 2020 он/** | - |
| 105 | | 3.Чойбалсан хотоос Баянхошуу хилийн боомт /Халхгол сум/ чиглэлд 323 км хатуу хучилттай авто зам барих | 2017-2018 | Улсын төсөв | 183 500,0 | 2018 онд 2, 4 дүгээр хэсгийн 149.8 км хатуу хучилт-тай авто зам баригдах | 79 300,0 2017 онд зарцуул-сан<br>-<br>104,200.0 2018 онд зарцуул-сан | **АЗБХЗГ:** Зураг төсөл хийгдсэн. Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна. 2017.04.28-ны өдрийн 03/1754 тоот албан бичгээр Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгуулах санал Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн.<br><br>Инженерийн нарийвчилсан зураг төслийг 2016 онд "Эм Си Пи Си Жи Ар" ХХК боловсруулсан. **2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй.**<br><br>**2.107.10-тай давхцсан. /Хэрэгжүүлэх хугацаа 2020 он/** | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 106 | | 4.Чойбалсан хотоос Ульхан хилийн боомт чиглэлд 233.48 км хатуу хучилттай авто зам барих | 2017-2018 | Улсын төсөв | 245 057,0 | 2018 онд 3, 4 дүгээр хэсгийн 98.48 км /60.88+37.6/ хатуу хучилттай авто зам баригдах | 152 550,0 2017 онд зарцуулсан<br>-<br>92,507.0 2018 онд зарцуулсан | **АЗБХЗГ:** Зураг төсөл хийгдсэн. Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар 2017.08.15-ны өдрийн 01/3569 тоот албан бичгээр Сангийн яаманд санал хүргүүлсэн.<br>Инженерийн нарийвчилсан зураг төслийг 2016 онд "Эм Си Пи Си Жи Ар" ХХК боловсруулсан. **2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй**.<br>2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 186,4 тэрбум төгрөгийг тусган 2019-2021 онд хэрэгжүүлэхээр тусган 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Зураг төсөл хийгдсэн. 2019 оны төсвийн төсөлд уг төслийг хэрэгжүүлэх хөрөнгө тусгагдаагүй.<br>Уг төслийн барилгын ажлын санхүүжилтийг төсвийн төсөлд тусгуулахаар 2019.08.14-ний өдрийн 01/4326 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2020 оны улсын төсвийн тухай хуульд тусгагдаагүй тул хэрэгжих боломжгүй. | - |
| 6.11. Завхан аймаг | | | | | | | | | |
| 107 | 1. Завхан аймгийн Улиастай хот, Говь-Алтай аймгийн чиглэлд орших Ширээгийн голд 120 м-ийн урттай төмөр бетонон гүүр барина. | 1.Баруун бүс нутгийн улсын чанартай босоо тэнхлэгийн замд 120 м урт төмөр бетон гүүр барих | 2017-2019 | Улсын төсөв | 3 600,0 | Баруун бүс нутгийн улсын чанартай босоо тэнхлэгийн зам саадгүй зорчих нөхцөл бүрдэх | 600.0 | **АЗБХЗГ:** Улиастай-Алтай чиглэлийн замд орших Ширээгийн голд 90 у/м-ийн төмөрбетон гүүрийн зураг төслийг орон нутгийн зүгээс хийлгэсэн. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгагдсан тус гүүрийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "ЗЗБ" ХХК шалгарч, 2018.05.14-нд гэрээ байгуулсан. 2019 онд хийгдэх барилгын ажлын нарийвчилсан төлөвлөгөө батлуулсан. Барилгын ажил 2019.05.25-нд эхэлсэн. Нийт ажлын гүйцэтгэл 100%-тай. Улсын комисс ажиллаж 2019.11.08-нд ашиглалтад хүлээн авсан. Комиссын 10/12/19 дүгээртэй дүгнэлтээр баталгаажуулсан.<br>**2.107.7-той давхцсан.** | 100% |
| 6.13. Өвөрхангай аймаг | | | | | | | | | |
| 108 | 1. Хархорин-Хужирт-Арвайхээр чиглэлийн 40 км авто замыг шинээр барих зураг төсөл боловсруулж, барьж эхэлнэ. | 1.Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалан, Хархорин-Хужирт-Арвайхээр чиглэлийн авто замыг шинээр барих | 2017-2019 | Улсын төсөв | 34 000,0 | Ажлыг бүрэн дуусгах | 17,000.0 | **АЗБХЗГ:** Зураг төсөл хийгдсэн. Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна.<br>**2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй.**<br><br>2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 90,4 тэрбум төгрөгийг тусган 2019-2021 онд хэрэгжүүлэхээр тусган 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Зураг төсөл хийгдсэн. 2019 оны төсвийн төсөлд уг төслийг хэрэгжүүлэх хөрөнгө тусгагдаагүй.<br>Уг төслийн барилгын ажлын санхүүжилтийг төсвийн төсөлд тусгуулахаар 2019.08.14-ний өдрийн 01/4326 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2020 оны улсын төсвийн тухай хуульд тусгагдаагүй тул хэрэгжих боломжгүй. | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6.14. Өмнөговь аймаг | | | | | | | | | |
| 109 | 1.Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн хатуу хучилттай автозам барих ажлыг үргэлжлүүлж дуусгана. | 1.Өмнөговь аймгийн Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн хатуу хучилттай авто замыг үргэлжүүлж дуусгах | 2016-2020 | Улсын төсөв | 200 000,0 | Ажлын гүйцэтгэлийг 75 хувьд хүргэх | 50,000.0 | **АЗБХЗГ:** Өмнөговь аймгийн зүгээс өөрсдийн хөрөнгөөр гүйцэтгүүлэхээр Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн 302.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг гүйцэтгэх гэрээг “Дардανговь” ХХК-тай байгуулсан бөгөөд 2016 онд нийт **56 км** авто замыг барьж ашиглалтад оруулсан. 2017 онд орон нутгийн зүгээс уг замыг үргэлжлүүлэн **25 км** авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж, 09 дүгээр сарын 06-ны өдөр ашиглалтад хүлээлгэн өгсөн.<br>Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатараас цаашид орон нутгийн хөрөнгөөр зам барилгын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй тул улсын төсвийн хөрөнгөөр үргэлжлүүлэх хүсэлт ирүүлсний дагуу тус чиглэлд үргэлжлүүлэн 40 км авто зам барих хөрөнгийг МУ-ын 2019 оны төсвийн тухай хуулинд тусгуулахаар 2018.08.10-ны өдрийн 01/3822 тоотоор Сангийн яаманд санал хүргүүлсэн.<br>2019 оны төсвийн төсөлд уг төслийг хэрэгжүүлэх **хөрөнгө тусгагдаагүй. 2.107.22-той давхцсан** | - |
| 110 | 2.Даланзадгад-Цогтцэций чиглэлийн хатуу хучилттай автозам барих ажлыг үргэлжлүүлж дуусгана. | 2.Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Шар тээг-Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлж дуусгах | 2016-2019 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 40 700,0 | Ажлыг бүрэн дуусгах | 13,700.0 | **АЗБХЗГ:** Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Шар тээг-Цогтцэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто замын төслийг концессын “Барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэх гэрээг “Үндэсний хөгжлийн газраас Эн Си Эф” ХХК-тай 2017.03.30-ны өдөр байгуулсан .<br>Концесс эзэмшигч гэрээ хүчин төгөлдөр болох нөхцлүүдийг хангаж, 2017 оны 11 сард гэрээ хүчин төгөлдөр болсон тул Үндэсний хөгжлийн газраас зам барилгын ажилд өдөр тутмын хяналт гүйцэтгэх зөвлөх компани сонгон шалгаруулалтыг 2018.04.11-ний өдөр зарлан, үнэлгээ хийж, шалгаруулсан боловч оролцогчдоос Сангийн яаманд гомдол гаргасан шалтгаанаар Зөвлөх томилогдоогүй тул Авто замын тухай хуулийн 20.4-т “техник, технологийн хяналтгүйгээр зам барилгын ажлыг гүйцэтгэхийг хориглоно” гэж заасны дагуу зам барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй байна. Мөн концесс эзэмшигчээс 2018.05.09-ны өдөр зам барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл хүссэн албан бичиг ирүүлсэн боловч холбогдох хууль болон журмын дагуу Зөвлөхийг сонгож, гэрээ байгуулагдаагүй тохиолдолд зам барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл олгох боломжгүй гэсэн хариу өгсөн.<br>Үндэсний хөгжлийн газраас Зөвлөхийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан тохиолдолд зам барилгын ажлыг эхлүүлэх нөхцөл бүрдэнэ.<br>Үндэсний хөгжлийн газраас шалтгаалан уг ажил хүлээгдэж байна.<br>Концессын гэрээ хүчин төгөлдөр болж, барилгын ажил эхлэх нөхцөл бүрдсэн боловч **шүүхийн маргааны улмаас Зөвлөхийн гэрээ байгуулах, зам барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй, хүлээгдэж байсан.**<br>Зөвлөхийн сонгон шалгаруулалттай холбоотой шүүхийн маргаан дуусгавар болсон тул концессын гэрээг 2019.10.30 хүртэл сунгасан бөгөөд Зөвлөхийн гэрээг 2019.04.13-ны өдөр байгуулснаар зам барилгын ажлыг эхлүүлэх нөхцөл бүрдсэн. Тус яамнаас 2019.05.27-ны өдөр 06/22/2019 дугаартай замын барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | олгосон. Зам барилгын ажлын талбайд ухмал, далан, суурийн доод үе, хиймэл байгууламжийн ажил хийгдсэн бөгөөд 2019 онд нийт ажлын 50%-ийг хийж гүйцэтгэсэн. | |
| 6.16. Сэлэнгэ аймаг | | | | | | | | | |
| 111 | 1. Орон нутгийн чанартай нийт 200 км автозамыг барьж байгуулна. | 1.Улаанбаатар-Алтанбулаг чиглэлийн олон улсын авто замаас Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг чиглэлийн 112 км авто зам барих | 2016-2018 | Улсын төсөв | 44 800,0 | Замын барилга угсрал-тыг дуусгаж, ашиглалтад оруулах | 24 000,0 2017 онд зарцуул-сан<br>-<br>20,800.0 2018 онд зарцуул-сан | **АЗБХЗГ:** МУ-ын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 63 дугаар тэмдэглэлээр эдийн засгийн хүндрэлтэй байгаа нөхцөл байдалтай уялдуулан төсөвт ирэх ачааллыг бууруулах зорилгоор улсын хөгжлийн төлөвлөлттэй нийцээгүй, нийгэм эдийн засгийн ач холбогдол багатай концессын гэрээ байгуулсан боловч барилга угсралтын ажил эхлээгүй Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 112 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг хийж гүйцэтгэх хугацааг түр хойшлуулахаар шийдвэрлэсэн. Тус яамнаас Сангийн яаманд 2018.06.13-ны өдрийн 01/2777 тоот албан бичгээр "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны төсвийн хязгаарыг батлах тухай" тогтоолын төсөлд тусгуулахаар хүргүүлсэн.<br>Мөн 2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 127,4 тэрбум төгрөгийг тусган 2019-2021 онд хэрэгжүүлэхээр 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн өмчийн Концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан.<br>**Засгийн газрын 2016.12.28-ны өдрийн 63 дугаар тэмдэглэлээр эдийн засгийн хүндрэлтэй байгаа нөхцөл байдалтай уялдуулан төсөвт ирэх ачааллыг бууруулах зорилгоор улсын хөгжлийн төлөвлөлттэй нийцээгүй, нийгэм эдийн засгийн ач холбогдол багатай концессын гэрээ байгуулсан боловч барилга угсралтын ажил эхлээгүй Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 112 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг хийж гүйцэтгэх хугацааг түр хойшлуулахаар шийдвэрлэсэн**.<br>Тус яамнаас Сангийн яаманд 2018.06.13-ны өдрийн 01/2777 тоот албан бичгээр "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны төсвийн хязгаарыг батлах тухай" тогтоолын төсөлд тусгуулахаар хүргүүлсэн. Мөн тус яамнаас 2018.08.10-ны өдрийн 01/3822 тоотоор Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулинд тусгуулахаар Сангийн яаманд санал хүргүүлсэн. 2019 оны улсын **төсөвт хөрөнгө тусгагдаагүй**.<br>ЗГХЭГ-аас тус чиглэлийн авто замыг концессын "Барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхээр тогтоолын төсөл ирүүлсэн бөгөөд тус яамнаас 2019.05.31-ний өдрийн 01/2901 тоот албан бичгээр дэмжсэн санал хүргүүлсэн. Засгийн газрын 2019 оны 239 дүгээр тогтоолоор концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг Үндэсний хөгжлийн газарт зөвшөөрсний дагуу Үндэсний хөгжлийн газраас концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд концесс эзэмшигчийн зүгээс концессын гэрээний урьдчилсан нөхцөлүүдийг хангасны үндсэн дээр концессын гэрээ хүчин төгөлдөр болоод байна. Үндэсний хөгжлийн | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | газраас зам барилгын ажилд техник технологийн хяналт гүйцэтгэх Зөвлөхийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна. Зөвлөх шалгарснаар зам барилгын ажлыг эхлүүлэх боломж бүрдэнэ. | |
| 112 | | 2.Дархан-Эрдэнэтийн чиглэлийн замаас Орхонтуул сумын төв хүртэл 65 км хатуу хучилттай авто зам барих | 2017-2018 | Улсын төсөв | 26 000,0 | Замын барилга угсрал-тыг дуусгаж, ашиглал тад оруулах | 150,0 2017 онд зарцуул-сан - 25,850.0 2018 онд зарцуул-сан | **АЗБХЗГ:** Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна. Тус чиглэлийн авто замын зураг төсөл хийх хөрөнгийг Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар 2017.08.15-ны өдрийн 01/3569 тоот албан бичгээр Сангийн яаманд санал хүргүүлсэн боловч батлагдаагүй.<br>Харин Дархан-Эрдэнэтийн чиглэлийн замаас Орхонтуул сумын төв хүртэл авто замын Орхон гол дээрх гүүрийн барилгын ажилд 500 сая төгрөгийг 2018 оны төсөвт батлуулсан.<br>Уг зураг төсөл боловсруулах ажлын даалгаварыг Зам, тээврийн хөгжлийн яамны 2018.03.01-ний өдрийн 03/884 тоот албан бичгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн. Тендерийг 2018.04.06-ны өдөр зарласан бөгөөд 2018.05.09-ны өдөр нээсэн. Тендер шалгаруулалтад оролцогчдын ирүүлсэн санхүүгийн батлагдсан төсвөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн тул хуулийн дагуу бүх тендерээс татгалзсан.Тендер шалгаруулалтыг 2018.09.10-ны өдөр дахин зарласан боловч нэг ч компани оролцоогүй учир тендер хүчингүй болсон. Ажлын тоо хэмжээнд зохих өөрчлөлт оруулсны дараа дараагийн шатны ажил хийгдэхээр хүлээгдэж байна.<br>2019 оны төсвийн төсөлд уг төслийг хэрэгжүүлэх **хөрөнгө тусгагдаагүй.** | - |
| 113 | | 3.Дархан-Улаанбаатарын чиглэлийн авто замаас Мандал сумын төв хүртэл 32 км хатуу хучилттай авто зам барих | 2017-2018 | Улсын төсөв | 18 800,0 | Замын барилга угсрал-тыг дуусгаж, ашиглал тад оруулах | 75,0 2017 онд зарцуул-сан - 18,725.0 | **АЗБХЗГ:** Зураг төсөл хийгдсэн. Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар 2017.08.15-ны өдрийн 01/3569 тоот албан бичгээр Сангийн яаманд санал хүргүүлсэн. **2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй** учраас төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон.<br>Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн.<br>Тендерийг 2019.03.22-ний өдөр зарласан бөгөөд 2019.04.22-ны өдөр нээсэн.<br>Тендер шалгаруулалтад 3 оролцогч оролцсон бөгөөд гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн боловч Сангийн яаманд гомдол гарсан тул түр түдгэлзүүлсэн.<br>Сангийн яамнаас 2019.05.22-ны өдөр захиалагчийн шийдвэр үндэслэлтэй албан бичиг ирсэн. Иймд гүйцэтгэгч “Замын битум” ХХК-тай 2019.06.03-ны өдөр гэрээ байгуулсан. Барилгын ажил эхэлсэн.<br>Талбайд дээр 110 ажилтан, 60 машин механизм ажил гүйцэтгэж байна.Асфальтны үйлдвэр шинээр барьсан. Далангийн ажил-75%-тай.32 км-т 50 ширхэг хоолой тавих ажил 80%-тай явж байна.Битум татаж дууссан. Суурийн ажил хийгдэж байна.Нийт барилга угсралтын ажлын явц 35%-тай байна. | 40% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 114 | | 4. Дархан-Сэлэнгийн хатуу хучилттай авто замаас Хушаат сумын төв хүртэл 26 км хатуу хучилттай авто зам барих | 2018-2019 | Улсын төсөв | 10,400.0 | Замын барилга угсралтыг дуусгаж, ашиглалтад оруулах | 10,330.0 | **АЗБХЗГ: 2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй** учраас төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон. Энэ чиглэлийн авто замын барилгын ажлыг 2020 оны төслийн төсөлд тусгахаар төлөвлөж байна.<br><br>2019 оны төсвийн төсөлд уг төслийг хэрэгжүүлэх хөрөнгө тусгагдаагүй. | - |
| 115 | | 5. Мандал сумын Түнхэл тосгоноос Төв аймгийн Батсүмбэр сумын төв хүртэлх 45 км хатуу хучилттай авто зам барих | 2019-2020 | Улсын төсөв | 18,000.0 | Зураг төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулах | 85.0 | **АЗБХЗГ:**<br>2019 оны төсвийн төсөлд уг төслийг хэрэгжүүлэх хөрөнгө тусгагдаагүй. | - |
| 116 | | 6.Аймгийн төв Сүхбаатар сумын ерөнхий төлөвлөгөөний дагуу төв дотор 34 км хатуу хучилттай авто зам барих | 2017-2020 | Улсын төсөв | 13 600,0 | Хатуу хучилт-тай замын ажлыг үргэлж-лүүлэх | 4 000,0 | **АЗБХЗГ:** Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна. Тус чиглэлийн авто замын зураг төсөл хийх хөрөнгийг Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар 2017.08.15-ны өдрийн 01/3569 тоот албан бичгээр Сангийн яаманд санал хүргүүлсэн.<br>**2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй** учраас төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон.<br>Аймгийн Засаг даргын ирүүлсэн саналын дагуу 2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 3 км авто замын зураг төсөл боловсруулах ажилд 153 сая төгрөг тусган 2019 онд хэрэгжүүлэхээр 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Хэрвээ 2019 онд зураг төсөл хийгдсэн тохиолдолд 2020 онд барилгын ажлыг эхлэх боломжтой болно.<br>2019 оны төсвийн төсөлд уг төслийг хэрэгжүүлэх хөрөнгө тусгагдаагүй. | - |
| 117 | | 7.Сумдын төвийн хатуу хучилттай авто замын сүлжээг нэмэгдүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 12 500,0 | Орхон, Сант, Шаамар, Зүүнбүрэн сумдын төвийн хатуу хучилттай авто замын сүлжээг нэмэгдүүлэх | 2,000.0 | **АЗБХЗГ:** Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар 2017.08.15-ны өдрийн 01/3569 тоот албан бичгээр Сангийн яаманд санал хүргүүлсэн. **2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй.**<br><br>Орхон, Сант, Шаамар, Зүүнбүрэн сумдын төвийн хатуу хучилттай авто замын сүлжээг нэмэгдүүлэх хөрөнгө **2019 оны улсын төсөвт тусгагдаагүй.**<br>Сумын төвийн доторх авто зам, тохижилт биелэлт /Сэлэнгэ, Сүхбаатар сум/<br>ЗТХС-ын 2019.01.10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн. Тендерийг зарласан бөгөөд 2019.04.29-ний өдөр нээсэн. Тендэр шалгаруулалтад 3 оролцогч оролцсон бөгөөд шаардлагад | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нийцсэн нэг ч оролцогч оролцоогүй тул тендерийг дахин зарласан. ТШ-ыг 2019.06.17-ны өдөр нээхэд 3-н оролцогч оролцсон бөгөөд “Грэйт Роуд” ХХК-д гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн боловч Сангийн яаманд гомдол гарсан тул түр түдгэлзүүлсэн. Сангийн яамнаас Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй гэсэн тул 2019.07.09-ний өдөр гэрээ байгуулж барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Ажлын явц 69 %-тай.<br>- Сумын төвөөс Сайханы хөтөл хүртэл хатуу хучилттай авто зам, 7 км /Сэлэнгэ, Сүхбаатар сум/<br>Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2019 оны "Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 52 дугаар тушаалаар эрх шилжсэн. Тендерийг 2019.03.21-ний өдөр зарласан бөгөөд 2019.04.22-ны өдөр нээсэн. Тендер шалгаруулалтад 1 оролцогч оролцсон бөгөөд “Сэлэнгэ АЗЗА” ТӨХК-тэй 2019.05.20-ны өдөр гэрээг байгуулж БУА-г эхлүүлсэн. Хучилтын ажил дууссан. Барилга угсралтын ажлын явц 100%-тай, Улсын комисс ажилласан.<br>-Сумын төвийн доторх авто зам, тохижилт /Сэлэнгэ, Мандал сум/<br>Барилгын ажлыг эхлүүлсэн.<br>-Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замаас Мандал сум хүртэлх авто замтай холбох хатуу хучилттай авто зам /Сэлэнгэ, Мандал сум/<br>ЗТХС-ын 2019.01.10-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 08 дугаар тушаалаар эрх шилжсэн. Тендерийг 2019.03.22-ны өдөр зарлаж, 2019.04.22-ны өдөр нээсэн. Тендер шалгаруулалтад 3 оролцогч оролцсон бөгөөд гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн боловч Сангийн яаманд гомдол гарсан тул түр түдгэлзүүлсэн. Сангийн яамнаас 2019.05.22-ны өдөр захиалагчийн шийдвэр үндэслэлтэй албан бичиг ирсэн. Иймд гүйцэтгэгч “Замын битум” ХХК-тай 2019.06.03-ны өдөр гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Барилга угсралтын ажлын явц 44%-тай байна. 2020 онд хучилтын ажил хийгдэнэ. | |
| 6.19. Ховд аймаг | | | | | | | | | |
| 118 | 1. Чоно харайхын гүүрийг ашиглалтад оруулна. /Дөргөн сум/ | 1.Чоно харайхын гүүрийг ашиглалтад оруулах /Дөргөн сум/ | 2017-2018 | Улсын төсөв | 1 500,0 | Ажлыг бүрэн дуусгаж, хүлээн авах | 700,0 | **АЗБХЗГ: 2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй** учраас төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон.<br>Сангийн яаманд 2018.06.13-ны өдрийн 01/2777 тоот албан бичгээр "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны төсвийн хязгаарыг батлах тухай" тогтоолын төсөлд тусгуулахаар хүргүүлсэн.<br>Мөн 2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 1,56 тэрбум төгрөгийг тусган 2019-2020 онд хэрэгжүүлэхээр 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Чоно харайхын голын 37.68 урт метр гүүрийг барих **хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй** учраас уг төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон.<br>Чоно харайхын голын 37.68 урт метр гүүрийн барилгын ажлын хөрөнгө оруулалтыг 2020 оны төсөвт тусгуулсан, хэрэгжилтийн хуваарийн дагуу зохион байгуулна. | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 119 | 2. Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр баруун бүсийн босоо тэнхлэгийн автозам барина. /Өлгий-Ховд 100 км/ | 2.Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам барих /Өлгий-Ховд 100 км/ | 2016-2018 | Гадаад зээл | 86 300,0 | Газар шорооны ажлыг дуусгах, хучилтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулах 2017 | 86 300,0 | **АЗБХЗГ:** Багц 1-1 хэсэг буюу Хашаатын даваа-Шурагийн гүүр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын барилгын дуусч 07/13/18 дугаар дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан.<br>Багц 1-2 хэсэг буюу Шурагийн гүүр-Ховд чиглэлийн 53.9 км хатуу хучилттай авто замын барилгын ажил дуусч 07/13/18 дугаар дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан.<br>**2.107.1-тэй давхцсан** | 100% |
| 120 | 3. Олон улсын нисэх буудлын барилгыг өргөтгөнө. | 3.Олон улсын нисэх буудлын барилгыг өргөтгөх | 2017-2018 | Улсын төсөв | 10 000,0 | Ажлыг бүрэн дуусгаж, улсын комисс хүлээн авах | 3 000,0 | **АТБХЗХ:** ЗТХС-ын 2017.07.04-ний өдрийн 137 дугаар тушаалаар батлагдсан “ИНЕГ-ын 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт”-д Ховд аймаг дахь нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга байгууламжийн зураг төсөв хийхэд 60 сая төгрөг, мөн нисэх буудлын аэродромын өргөтгөлийн зураг төслийг шинэчлэхэд 26 сая төгрөгийг тусгуулсан.<br>Нисэх буудлын аэродромын өргөтгөлийн зураг төсвийг шинэчлэхээр “ЭЗТ” ХХК-тай 2017.10.19-ний өдөр ИНЕГ/ЦА/ТББ/ЗҮ-12/17 дугаар гэрээ байгуулсан. “ЭЗТ” ХХК-нь гэрээний дагуу аэродромын өргөтгөлийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж дуусган захиалагч талд хүлээлгэн өгсөн.<br>Ховд нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга, байгууламжийг өргөтгөх зургийн эскизийг ИНЕГ-ын даргаар 2019.03.15-ны өдөр батлуулсан. Зорчигч үйлчилгээний барилгын зураг төсвийг 2019.05.15-ны өдөр хүлээн авахаар “Алтайн газрын хүч” ХХК-тай гэрээг шинэчлэн байгуулсан. Зураг төсөв боловсруулах ажил 70%-тай.<br>Нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, аэродромыг 4С болгох ажлыг гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд санхүүжилтийг эрэлхийлэх ажлыг хийж байгаа болович амжилтгүй байна.<br>/2020-2024 онд концессын гэрээ, гадаадын зээл тусламж, улсын төсвийн хөрөнгө оруулалт зэргээр санхүүжилтийн боломжтой хувилбарыг сонгон хэрэгжүүлэхээр тусгаж, он дамжуулж санхүүжүүлэх замаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.<br>2.114.10-тай давхцсан | - |
| 6.21. Хэнтий аймаг | | | | | | | | | |
| 121 | 1.Даланжаргалан сумаас Бор-Өндөр чиглэлийн 45 км хатуу хучилттай | 1.Даланжаргалан сумаас Бор-Өндөр чиглэлийн 45 км хатуу хучилттай зам барих | 2017-2020 | Улсын төсөв | 25 000,0 | Барилга угсралтын ажлыг дуусгаж, ашиглал | 5,000.0 | **АЗБХЗГ:** Концессын гэрээгээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгүүлэх концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан Даланжаргалан сумаас Бор-Өндөр чиглэлийн 45 км хатуу хучилттай замыг Эдийн засгийн хүндрэлтэй байгаа нөхцөл байдалтай уялдуулан төсөвт ирэх ачааллыг бууруулах зорилгоор улсын хөгжлийн төлөвлөлттэй нийцээгүй, нийгэм эдийн засгийн ач холбогдол багатай тул одоогоор хэрэгжүүлж эхлээгүй байна. | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зам барина. | | | | | тад оруулах | | Мөн цаашид концессын “барих-шилжүүлэх” төрлөөр авто замын төслийг хэрэгжүүлэхгүй гэсэн чиглэлийг УИХ-аас гаргасан. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар 2017.08.15-ны өдрийн 01/3569 тоот албан бичгээр Сангийн яаманд санал хүргүүлсэн боловч 2018 оны улсын төсвийн тухай хуульд тусгагдаагүй.<br>Төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга батыг сайжруулах зорилгоор “Барих-шилжүүлэх” нөхцөлтэйгөөр хэрэгжих концессын зүйлийн жагсаалтыг тухайн жилийн төсөвт тусгаж байхаар Төсвийн тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тус төслийг төсөвт тусгуулахаар Үндэсний хөгжлийн газраас Сангийн яаманд санал хүргүүлсэн боловч, хасагдаж концессын "Барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэх боломжгүй болсон.<br>"Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 оны төсвийн хязгаарыг батлах тухай" тогтоолын төсөлд тусгуулахаар 2018.06.13-ны өдрийн 01/2777 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Мөн 2019 оны төсвийн төслийн Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцад 49,4 тэрбум төгрөгийг тусган 2019-2020 хэрэгжүүлэхээр 2018 оны 01/3822 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>ТНБД-ын 2019 оны 41 дүгээр тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг 2019.02.22-ны өдөр зарласан бөгөөд 2019.03.25-ний өдөр нээсэн. Тендерийг үнэлж хамгийн сайн үнэлэгдсэн оролцогчид гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлж, “Билэгт зам” ХХК-тай гэрээ байгуулж, барилгын ажлыг эхлүүлсэн. Барилга угсралтын **ажлын явц 70%-тай** байна.<br>**2.107.28-тай давхцсан.** | |
| **Нийт** | | | | | | | | | **86.97%** |

ЗТХЯ-ны Засгийн газрын гишүүдтэй хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ, 2019 оны жилийн эцсийн байдлаар/

| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | 2019 он | | Хэрэгжилт | Үнэл-гээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв, (сая төгрөг) | | |
| **Тэргүүлэх зорилт №2.1.** Макро тэнцвэрийг бататгасан олон тулгуурт дотоодын үйлдвэрлэлд түшиглэсэн, тогтвортой эдийн засгийг бий болгон Монгол Улсын үндэсний нийт орлогыг нэмэгдүүлж, дундаж-дээгүүр орлоготой орнуудын эгнээнд буцаан оруулна. | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2.11. Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана | 1. Алтанбулаг чөлөөт бүсийг ОХУ-ын талтай шууд гарцаар холбох асуудлыг судлан шийдвэрлүүлэх | 2016-2020 | - | - | Хоёр орны ЗГ хоорон-дын хурал-даанаар шийд-вэрлэх | - | Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах чиглэлээр судалгаа хийж зураглал гарган, ажлын даалгавар боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ЗТХ-ийн сайдын 2017 оны 58 дугаар тушаалаар байгуулсан. Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгааны ажлыг 2017 онд 25.0 сая төгрөгөөр хийхээр зам, тээврийн салбарын норм нормативыг боловсронгуй болгох сангийн 2017-2018 оны төлөвлөгөөнд тусгасан.<br>Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах чиглэлээр судалгаа хийж зураглал гаргах ажлын хүрээнд ачаа тээврийн хэмжээ, хэтийн төлөвийг судлан, ачаа үүсэх, шингээх гол цэгүүдийг тодорхойлон, замын сүлжээтэй уялдуулан тээвэр логистикийн төвүүдийн байршлыг тодорхойлох ажлыг хийхээр төлөвлөсөн.<br>Зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан “Монголын логистикийн холбоо” ТББ-тай 2017 онд 267 дугаар гэрээг байгуулсан.<br>“Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгаа”-ны ажлын даалгаварт 3 улсын хил дамнасан олон улсын авто замын транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг тусгасан.<br>“Монголын логистикийн холбоо” ТББ-ын ирүүлсэн эхлэл, дундын тайлантай танилцаад санал, дүгнэлт өгсөн. Зөвлөх үйлчилгээ үзүүлж буй байгууллага зарим төрлийн судалгаа хийж дүгнэлт гаргахад хугацаа шаардлагатай байгааг харгалзан гэрээг 2018.10.20-ны өдөр хүртэл сунгасан. Зөвлөх үйлчилгээний багаас эцсийн тайланг боловсруулан ирүүлээд байна. Уг тайлантай танилцан дүгнэлт, санал боловсруулах, хэлэлцүүлэг хийх ажлууд хийгдэж байна.<br>Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын ЗГ хоорондын комиссын тээврийн ажлын XIII хуралдааны протоколын төсөлд “Азийн авто замын сүлжээгээр олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх тухай” ЗГ хоорондын хэлэлцээрийн хүрээнд энэхүү зорилтыг хэрэгжүүлэх саналыг 2018оны 02 дугаар сарыг 08-ны өдрийн 02/610 тоот албан бичгээр ГХЯ-нд хүргүүлсэн. ОХУ-ын Москва хотноо 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдсан Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын ЗГ хоорондын комиссын Тээврийн ажлын хэсгийн XIII хуралдааны үеэр монголын тал “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийн хүрээнд 3 улсын хил дамнасан олон улсын авто замаар транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг худалдааны чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг дэвшүүлсэн боловч оросын тал энэхүү асуудал нь тээврийн ажлын хэсгийн хэлэлцэх зүйл бус харин өргөн хүрээ хамарсан хил хамгаалал, гааль болон бусад хяналтын байгууллагуудын оролцоо шаардлагатай тул Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын ЗГ хоорондын комиссын XXII хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгаж, хэлэлцүүлэх санал дэвшүүлснийг талууд тохиролцсон. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн XXII | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хуралдааны протоколын Тээврийн салбарын хамтын ажиллагаа хэсгийн 3.14-т “Монгол Улсын чөлөөт бүс Алтанбулаг болон ОХУ-ын Кяхта хотын хооронд авто замыг нээх саналыг монголын тал дэвшүүлэв” гэж тусгуулсан.<br>Эдийн засгийн коридор хөтөлбөрийн хүрээнд 3 улсын дамжин өнгөрөх тээврийн Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрөх асуудлыг судлан үзэхэд Оросын талаас Алтанбулаг булаг чөлөөт бүстэй холбогдох гарц байхгүй байна.<br>Эдийн засгийн коридор хөтөлбөрийн хүрээнд 3 улсын дамжин өнгөрөх тээврийн Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрөх асуудлаар ГХЯ-аас Оросын талд хандсан боловч Оросын талаас уг асуудлыг шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу мэдэгдсэн байна. Уг асуудлыг дахин Монгол-Оросын ЗГХК-ын 2018 оны хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар саналаа ГХЯ-д хүргүүлсэн. Гэвч энэхүү асуудал нь Оросын талаас хамаарч байгаа бөгөөд монголын тал бие даан шийдвэрлэх боломжгүй байна.<br>Монгол Улсын Засгийн газар, ЗТХЯ, ГХЯ-ны зүгээс Орос-Монгол-Хятад 3 улсын хил дамнасан олон улсын авто замын транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг дэмжүүлэхээр ОХУ-тай ихээхэн хүчин чармайлт гаргаж ажилласан боловч уг асуудал **“олон улсын тээвэрлэлт Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрөхгүйгээр**” шийдвэрлэгдсэн.<br>Иймд дээрх арга хэмжээнд туссан “.... судлан шийдвэрлүүлэх” ажлыг бүрэн гүйцэтгэсэн болно. | |
| 2 | | 3. Замын-Үүд чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, улмаар Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн хоёрдугаар ээлжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх | 2017-2020 | Гадаад эх үүсвэр | 182 444,0 | 2 дугаар ээлжийн бүтээн байгуулалтын ажил үргэлжлэх | 82,444.0 | Замын-Үүд чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын яам боловсруулж, батлуулах бөгөөд одоогоор төлөвлөгөөг боловсруулах ажил эхлээгүй байна. Мөн “Замын Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн **хоёрдугаар ээлжийн төслийг хэрэгжүүлж эхлээгүй.** Чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах болон төслийн 2 дугаар ээлжийг эхлүүлэх үе шатанд зам, тээврийн салбарын шаардлагатай мэдээ, мэдээлэл, санал, зөвлөмжөөр ханган хамтран ажиллана.<br>МУ-ын Шадар сайдын 2018.02.13-ны өдрийн 11 тоот тушаалаар Замын-Үүд, Эрээний боомтыг түшиглэн хил дамнасан чөлөөт бүс байгуулах асуудлыг судалж санал, дүгнэлт боловсруулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ЗТХЯ-ны ТНБД ажилласан.<br>Мөн Замын-Үүдийн эдийн засгийн хамтын ажиллагааны чөлөөт бүс байгуулах ажлын хүрээнд Шадар сайдын 2018.05.05-ны өдрийн 47 тоот тушаалаар байгуулагдсан Замын-Үүд Эрээний боомтыг түшиглэн хоёр улсын эдийн засгийн хамтын ажиллагааны зэргэлдээ бүс байгуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг судлах, уг асуудлаар Хятадын талтай хэлэлцээ хийх багийн бүрэлдэхүүнд БТГ-ын холбогдох мэргэжилтэн орж ажилласан. Уг хэлэлцээрийн төсөлд /маш нууцын зэрэглэлтэй санал | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | авахаар ирүүлсний дагуу/ холбогдох саналыг тусгуулахаар 2018.06.08-ны өдөр МУ-ын Шадар Сайдад хүргүүлсэн. | |
| **Тэргүүлэх зорилт №2.2.** Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор "ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН" үндэсний хөтөлбөр, "ҮЙЛДВЭРЖИЛТИЙН 21:100" хөтөлбөр, "ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ" хөтөлбөр, "МАХ, СҮҮНИЙ АНХДУГААР АЯН"-ыг шинээр эхлүүлж, "АТРЫН-III АЯН"-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | | | | | | | | | |
| 3 | 2.48. Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ. | 6. Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг боловсруулан батлуулах | 2016-2020 | - | - | Хөтөл-бөрийг хэрэг-жүүлэх | - | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас боловсруулсан "Үйлдвэржилт 21:100 хөтөлбөр"-ийн төсөл, Засгийн газрын тогтоолын төсөлд зам, тээврийн салбарт шинээр барихаар төлөвлөж байгаа үйлдвэрүүдийн талаарх санал боловсруулж, ЗТХЯ-ны ТНБД-ын 2017.05.17-ны өдрийн 03/2178 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Салбарын үйлдвэрлэлийн өнөөгийн байдлын судалгаа хийж, "Зам тээврийн салбарт шинээр байгуулах болон үйл ажиллагааг нь дэмжвэл зохих үйлдвэрийн жагсаалт"-ыг гарган Зам, тээврийн хөгжлийн сайдаар 2017.08.23-ны өдөр батлуулсан.<br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас дахин боловсруулсан "Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулж, ЗТХС-ын 2017.11.28-ны өдрийн 01/5237 тоот албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2018.01.31-ний өдрийн 36 дугаар тогтоолоор "Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр" батлагдсан. Энэхүү хөтөлбөрийн жагсаалтад зам, тээврийн салбараас "Ачааны вагон угсрах үйлдвэр" Дорноговь аймагт, "Хаягдал дугуй дахин боловсруулах үйлдвэр" Өмнөговь аймагт, "Хос дугуйн засварын үйлдвэр" Сэлэнгэ аймагт байгуулахаар туссан байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж эхлээд байна. | 100% |
| 4 | | 7."Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймагт 100 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад санхүү, эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах | 2016-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | 301 000,0 | Үйлдвэрүүдийн үйл ажиллагааг эхлүүлж, туршилт тохируулга хийгдэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтын 45-60 хувь нь хийгдэх | 100,000.0 | Ашиглалтаас хасагдсан автомашиныг дахин боловсруулах үйлдвэр байгуулах төсөл хэрэгжүүлэхээр Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрт болон БНСУ-ын Эксим банкны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлэхээр санал хүргүүлсэн.<br>Ашиглалтаас хасагдсан автомашины үйлдвэр байгуулахад шаардлагатай эрх зүйн орчинг бүрдүүлэхээр "Тээврийн хэрэгслийн зай хураагуурын өнөөгийн байдал болон цаашид хэрхэн зохицуулалт хийх" хэлэлцүүлгийг 2017.02.21-ний өдөр зохион байгуулж, БОАЖЯ, МХЕГ, ГЕГ, ЭМЯ, НЭМХ, ШУТИС болон холбогдох судлаачдыг оролцуулсан. Уг хэлэлцүүлгийн зөвлөмжид үндэслэн Хог хаягдлын тухай хуулийн төсөлд тээврийн хэрэгслийн хог хаягдлыг журмаар зохицуулахаар тусгуулсан.<br>Мөн Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалтыг үндэслэн "Тээврийн хэрэгслийн болон барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих" журмын төслийг боловсруулж батлуулах шатандаа байна.<br>"Монголын төмөр зам" ХХК-ийн Ачааны вагоны үйлдвэр байгуулах урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулж, Зам, тээврийн салбарын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2016. оны 01 дүгээр хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн. ЗТХС-ын 2017 оны 21 дүгээр тушаалын дагуу | 40% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ачааны вагоны үйлдвэрийн туршилтын цехийг байгуулж, үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулаад байна. | |
| 5 | 2.58. Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах бараа, түүхий эдийн нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, үйл ажиллагааг боловсронгуй болгоно. | 2. Хөдөө аж ахуйн биржийн системийг онлайн горимд шилжүүлэн хөгжүүлж, олон улсын шаардлагад нийцсэн технологийн шинэчлэл хийх | 2017-2020 | - | - | Олон улсын шаардлагад нийцсэн технологийн шинэчлэл хийх | - | Хөдөө аж ахуйн биржийн системийг онлайн горимд шилжүүлэн хөгжүүлэх болон итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн тээврийн хэрэгслийн GPS системд холбох асуудлаар “Монгол тээвэр нэгтгэл” ХХК-тай хамтран ажиллаж байна. Биржийн системийг бүрэн онлайн горимд шилжүүлэх, тээврийн хэрэгслийг GPS системтэй холбох ажлыг 2019 оны гуравдугаар улиралд бүрэн хийж дуусгахаар ажиллаж байна. | 40% |
| **Тэргүүлэх зорилт №2.3.** Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. | | | | | | | | | |
| 6 | 2.65. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна. | 2. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог хангах | 2016-2020 | - | - | Дэд бүтцийн хөгжлийн төсөл хэрэгжүүлэх | - | Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалтаар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг барьж байгуулах талаар Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 135 дугаар тогтоол гарсан. Уг чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын доод бүтцийн ажил хийгдэж байна.<br>Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалтаар Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг “Зүүнбаян төмөр зам” ХХК нь “зураг төсөл боловсруулах- барих-ашиглах-шилжүүлэх” концессын төрлөөр барьж байгуулах тухай Засгийн газрын 2018.05.23-ны өдрийн 139 дугаар тогтоол, мөн төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах 2018.05.23-ны өдрийн 153 дугаар тогтоол тус тус баталсан. Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалтаар Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн хүнд даацын авто зам, Оюутолгой-Ханги чиглэлийн авто замын төслийг хөрөнгө оруулагч нарт танилцуулан холбогдох уулзалтыг хийж байна.<br>Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог хангах чиглэлээр холбогдох яам, байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал, Койка байгууллагын шугамаар хэрэгжсэн “Ашигт малтмалын нөөц, дэд бүтцийн хөгжил, санхүүгийн шаардлагын ерөнхий төлөвлөгөө боловсруулах” төсөлд зам, тээврийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, эцсийн шатны тайланд санал хүргүүлж, цаашид хамтран ажиллах механизмыг бүрдүүлэн ажиллаж байна.<br>Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах ажлын хэсэгт БТГ-ын холбогдох мэргэжилтэн оролцож ажиллаж байна. Ажлын хэсгийн удирдамжийн хүрээнд Монгол | 40% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Улсын төмөр зам, авто замын өнөөгийн байдал, цаашдын төлөвлөлтийн талаарх мэдээллийг хүргүүлэхээр нэгтгэн боловсруулж байна.<br>2019 оны зорилтот түвшинд суулгахаар ажиллаж байна.<br>ЗТХС-ын 2019.02.01-ний өдрийн 33 дугаар тушаалаар Таванталгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг 1 дүгээр улиралд багтаан шинэчлэн боловсруулах үүргийг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захиралд өгсөн. ТЭЗҮ шинэчлэн боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.<br>Таванталгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлэхээр ЗТХС-ын 2019 оны 90 дүгээр тушаалаар УУХҮЯ-тай хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан. ЗГ-ын 2019.02.20-ны өдөр, 04.03-ны өдөр тус тус танилцуулж 8, 15 дугаар тэмдэглэлүүд гарсан. ЗТХС-ын 2019 оны 185 дугаар тушаалаар ЗГ-ын хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаварыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэлбэрийг тодорхойлон ЗГ-ын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлэх санал гарган Сайдын зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгээд байна. Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар Таванталгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх санхүүжилтийг шийдвэрлэн, “Таванталгой төмөр зам” ХХК-ийн хувь эзэмшлийг тогтоосон 304 дүгээр тогтоол батлагдсан. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд барилгын ажил эхлүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. | |
| **Тэргүүлэх зорилт №2.4.** Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ. | | | | | | | | | |
| 7 | 2.85. Улаанбаатар хот болон томоохон хотуудыг дахин төлөвлөж, хөгжүүлэх бодлогын хүрээнд барилга байгууламжийг шинэчлэх, гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл, хөтөлбөрийг | 3. Хөшигийн хөндийд баригдах олон улсын нисэх буудлыг даган бий болох “ухаалаг” жишиг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах | 2017-2019 | Улсын төсөв | 633,0 | Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах | 2017 онд 451,6<br>2018 онд 181.4 | МУ-ын Ерөнхий сайдын 2017.07.03-ны өдрийн 122 дугаар захирамжаар байгуулагдсан “Төв аймгийн Хөшигийн хөндийд баригдах нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд тодотгол хийх ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, шинэ хотын инженерийн дэд бүтцийн эх үүсвэр, шугам шийдлийг тодорхойлох болон нисэх онгоцны буудал барих зориулалтаар тусгай хэрэгцээнд авсан маргааныг шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсгийн дэд ахлагчаар Зам, тээврийн хөгжлийн дэд сайд, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга ажиллаж байна.<br>УБ хотын ОУШНОБ-ыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын даалгаврын төсөлд Хөшигийн хөндийд олон улсын ачаа тээврийн логистик төв, зорчигч тээврийн терминалыг барих, тээврийн хэрэгслийн нэгдсэн авто зогсоолыг төлөвлөх саналыг тусгуулаад байна.<br>УБ хотын ОУШНОБуудлын АӨЗА-наас гаргасан “Ачаа, тээврийн судалгаа”-нд далайд гарцгүй манай орны хувьд дотоодын логистикийн салбарыг хөгжүүлэх нь улсын эдийн засагт онцгой ач холбогдолтой гэж | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлж, агаарын бохирдлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | дүгнэсэн. Мөн МУ-ыг тив дамнасан зорчигч болон ачаа тээврийн дамжин өнгөрөх зангилаа болгох боломжийг судалж байна.<br>УБ холимог тээврийн ачааны терминал, логистикийн төвийн мастер төлөвлөгөө боловсруулсан.<br>Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төсөл, Шинэ нисэх онгоцны буудлыг даган хөгжих шинэ хотын ерөнхий төлөлөгөөний тодотголд Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийг тусгуулахаар БХБЯ болон Газар зохион байгуулалт, геодизи, зураг зүйн газар, НЕТГ-т санал хүргүүлэн уг төслүүдэд Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийг тусгуулаад байна.<br>БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 2020 оноос хэрэгжих төсөлд, Европын хөрөнгө оруулалтын банканд, Азийн хөгжлийн банканд мөн БНСУ-ын "Мэдлэг хуваалцах хөтөлбөр"-ийн хүрээнд 2020 онд хэрэгжүүлэх бодлогын зөвөлгөө авах төсөлд Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах төслийн танилцуулсан.<br>Төслийг Үндэсний хөгжлийн газрын санхүүжилт шаардлагатай төслүүдийн танилцуулга бүхий сайтад тавиулахаар хүргүүлсэн.<br>ЗГ-ын 2017 оны 277 дугаар тогтоолоор "Богдхан төмөр зам төслийг "Ар богдын төмөр зам" ХХК-иас Концессын зүйлийн жагсаалтын $53^2$–т нэмэлтээр оруулсан байгааг хүчингүй болгох саналыг Үндэсний хөгжлийн газарт 2017.11.14-ний өдрийн 01/4971, 2018.09.07-ны өдрийн 02/4327 дугаартай албан бичгээр тус тус хүргүүлсэн.<br>"Богдхан" төмөр замын төслийн хүрээнд хэрэгжиж буй техникийн туслалцааг үргэлжлүүлэн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгүүлэх саналыг ТНБД-ын 2019.02.26-ны өдрийн 03/825 тоот албан бичгээр АХБ-нд хүргүүлсэн.<br>АХБ-аас зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт 5 жил тутам шинэчлэгддэг бөгөөд "TA-8935 MON: Богдхан төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр", "Хөшигийн хөндийн холимог тээврийн логистикийн төвийн төсөл"-ийг энэхүү жагсаалтад ахин тусган хэрэгжүүлэх саналыг тус банканд уламжлуулахаар ЗТХ-ийн дэд сайдын 2019.05.09-ний өдрийн 02/2386 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>"Ар богдын төмөр зам" ХХК-ны оруулсан төслийг Концессын зүйлийн жагсаалтаас хасуулах саналыг ЗТХ-ийн сайдын 2019.06.12-ны өдрийн 01/3149 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br>**Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 260 дугаар тогтоолоор Концессын зүйлийн жагсаалтын $53^2$ дахь заалт болох "Богдхан төмөр замын төсөл"-ийг хүчингүй болгосон. Азийн хөгжлийн банкнаас Техникийн туслалцааны хүрээнд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад 1 жилийн хугацаатай сунгаж ТЭЗҮ боловсруулах тендер зарласан. Шалгаруулалт хийгдэж тус төмөр замын ТЭЗҮ боловсруулагдсанаар чиг батлах боломжтой болох юм** | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | | 4. Аймгийн төв болон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах | 2017-2020 | Улсын төсөв | 5 068,5 | Хархорин хотыг байгаль орчинд ээлтэй хот болгон хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах | 727.2 | Бүсийн тулгуур төв болох Ховд, Төв, Дорнод хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрыг түшиглэн хөгжих Багануур хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг БХБ-ын сайдын зөвлөлийн 2017.03.09-ний өдрийн 02 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. | 40% |
| 9 | 2.95. Улаанбаатар хотын орон сууцны хороолол, нийтийн үйлчилгээний төвүүдийн дэргэд газар доорх болон давхар зогсоол барьж, авто зогсоолыг хоёр дахин нэмэгдүүлнэ. | 1. Авто зогсоолын тухай хуулийн төслийг боловсруулах | 2016-2017 | - | - | Хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх | - | Авто зогсоолын тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Зам, тээврийн хөгжлийн сайд Үзэл баримтлалыг баталж, 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 01/5533 тоот албан бичгээр БХБЯ-нд хүргүүлсэн. Холбогдох яамдын төлөөлөл оролцсон ажлын хэсэг Авто зогсоолын тухай хуулийн төслийг боловсруулж, төсөлд ЗГ-ын гишүүдээс санал авч нэгтгэсэн. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар БХБЯ-ны сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хуралдаанаас Авто зогсоолын тухай хуулийн төсөл, Ногоон байгууламжийн тухай хуулийн төслийг Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэгтгэх шийдвэр гарсны дагуу дээрх хуулийн төсөлд бүлэг болгон оруулж боловсруулсан.<br>Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын Үзэл баримтлал батлагдсан. Хуулийн төслийг боловсруулж ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, УИХ-д өргөн мэдүүлсэн. | 100% |
| **Тэргүүлэх зорилт №2.5.** Улс орны эдийн засгийн аюулгүй байдлын үндэс болсон эрчим хүчний тогтвортой, найдвартай ажиллагааг бүрэн хангаж, экспортын чадамжтай болох нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | | | |
| 10 | 2.100. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг зохистой харьцаагаар хөгжүүлж, Эгийн голын | 1. Эгийн голын УЦС-ын дэд бүтцийг байгуулах | 2016-2017 | Гадаад зээл | 201 500,0 | Ашиглалтад орох | 100,000.0 | Зам, тээврийн салбарын ШУТЗ-ийн 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар Эгийн голын Усан цахилгаан станцын авто замын трассын асуудлыг хэлэлцэж, авто замын трассын чиглэлийн Эрдэнэтийн Говил-Зосын даваа - Төслийн талбар гэсэн хувилбарыг дэмжсэн.<br>“Эгийн голын усан цахилгаан станц” төслийн авто зам болон агаарын шугамын чигтэй “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замын шугамын чиг давхацсан давхцалыг зассанаар концесс эзэмшигч “Нортерн Рейлвэйс” ХХК-ийн гүйцэтгэх Орхон аймгийн Эрдэнэт хотоос Хөвсгөл аймгийн | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | усан цахилгаан станц барих ажлыг эхлүүлнэ. | | | | | | | Цэцэрлэг сумын нутаг дэвсгэрт орших Овоотын уурхай хүртэл барьж байгуулах төмөр замын чигийг ЗГ-ын 2017 оны 10 дугаар тогтоолоор баталсан. 10 дугаар тогтоолд Эгийн голын усан цахилгаан станцын авто зам, цахилгаан дамжуулах агаарын шугамын трасстай давхцуулахгүйгээр Ханжаргалант уулаар батлагдсан хэдий ч тус уул нь Улсын тусгай хамгаалалттай бүс нутаг тул өөрчлөх шаардлага гарч Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 228 дугаар тушаалаар Эрчим хүчний яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтарсан ажлын хэсэг байгуулж Хужирын голын хөндийгөөр Эгийн голын усан цахилгаан станц төслийн авто зам, цахилгаан дамжуулах агаарын шугамын чигтэй зэрэгцүүлэн төмөр замын чигийг явуулахаар ажлын хэсгийн 2019.07.08-ны өдрийн №19/228/10 дүгнэлт гарсан.<br>Авто замын барилгын ажлыг хэрэгжүүлэх **хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүй**, барилгын ажил эхлээгүй. | |
| 11 | | 9. Цахилгаан хөдөлгүүртэй автомашиныг цэнэглэх авто зогсоол бий болгох асуудлыг шийдвэрлэх | 2018-2020 | - | - | Загвар төсөл хэрэгжих | - | Авто зогсоолын тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Зам, тээврийн хөгжлийн сайд Үзэл баримтлалыг баталж, 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 01/5533 тоот албан бичгээр БХБЯ-нд хүргүүлсэн. Холбогдох яамдын төлөөлөл оролцсон ажлын хэсэг Авто зогсоолын тухай хуулийн төслийг боловсруулж, төсөлд ЗГ-ын гишүүдээс санал авч нэгтгэсэн. Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар БХБЯ-ны сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хуралдаанаас Авто зогсоолын тухай хуулийн төсөл, Ногоон байгууламжийн тухай хуулийн төслийг Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нэгтгэх шийдвэр гарсны дагуу дээрх хуулийн төсөлд бүлэг болгон оруулж боловсруулсан.<br>Дээрх хуулийн төсөлд Цахилгаан хөдөлгүүртэй автомашиныг цэнэглэх зогсоолын тооны харьцааг стандартаар тогтоохоор хуулийн төсөлд тусгаад байна.<br>Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын Үзэл баримтлал батлагдсан. Хуулийн төслийг боловсруулж ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, УИХ-д өргөн мэдүүлсэн.<br>Автотээврийн салбарт шинээр боловсруулж байгаа “Цахилгаан тээврийн хэрэгслийг цэнэглэх станцын төрөл, тоноглолыг суурилуулах болон байршуулахад тавих ерөнхий шаардлага” MNS6758:2019 стандартын төслийг Автотээврийн стандартчлалын техникийн хороогоор 2019.03.01-ний өдөр хэлэлцүүлэн батлуулав. Улаанбаатар хотын агаар, орчныг бохирдлыг бууруулах, ногоон хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд цахилгаан тэжээлт автомашины олон улсын жишигт нийцсэн цэнэглэгч станцыг өөрийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн авто зогсоолуудад суурилуулах талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай 2018.11.15-ны өдөр байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу “Номин ойл” ХХК нь нийт 18 байршилд /СБД-т 5, ЧД-т 7, СХД-т 3, ХУД-т 1, БГД-т 1, БЗД-т 1/-д суурилуулахаар төлөвлөсөн. 2019 оны 12 дугаар сарын байдлаар “Номин ойл” ХХК нь өөрийн хөрөнгөөр ЧД-ийн 1-р хороо, СБД-ийн 1 | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | болон 8-р хорооны нутаг дэвсгэрт байрлалтай нийтийн эзэмшлийн авто зогсоолуудад 3 цэнэглэгч станцыг тус тус суурилуулаад байна. Тус компаний зүгээс үлдсэн 15 байршилд суурилуулах талаар төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | |
| 12 | 2.119.УБ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө-тэй уялдуулан Баянзүрх, Яармаг, Сонсголон-гийн гүүр болон УБ-Налайх чиглэлийн автозамыг шинээр барина | 5. Яармагийн гүүрийг засварлан, улмаар шинээр параллель гүүр, нүхэн гарц барих замаар олон түвшний огтлолыг бий болгох, 360 урт метр гүүр, 40 урт метр нүхэн гарц барих | 2018-2020 | Гадаад зээл, төр, хувийн хэвшлийн түншлэл | 46,177.0 | Барилгын ажлын гүйцэтгэл 40 хувь | 18,470.8 | Төслийн гүйцэтгэгч “Хятадын төмөр замын 20-р товчоо групп” корпораци төслийн зураг төсөв боловсруулах болон барилгын ажлыг гүйцэтгэнэ. Төслийн нийт өртөг 30.26 сая ам.доллар, хэрэгжүүлэх хугацаа 2016.10.01- 2019.01.30.<br>-Төслийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаа 2019.01.31-ний өдрөөр дуусгавар болсон тул үлдэгдэл ажлыг гүйцэтгэх график төлөвлөгөөг гаргуулж, төслийн ажлыг дуусгах асуудлаар зөвшилцөж 2019.04.01-ний өдрөөс барилгын ажил эхлүүлсэн.<br>Төслийн хүрээнд 4 эгнээ шинэ гүүр бүхий 250 у/м, 20.5 м өргөнтэй, 50 у/м нүхэн гарц, D-рамп шинэ гүүр нь 276 у/м, 8.5 м өргөнтэй, 2 эгнээ бүхий хуучин гүүр нь 250 у/м, 9 м өргөнтэй, 57 у/м тунелтэй, гэрэлтүүлэг, борооны ус зайлуулах шугам, инженерийн шугам сүлжээний ажлуудыг тус тус хийхээр төлөвлөж гүүрийн барилгын ажлыг бүрэн дуусган улсын комисст хүлээлгэн өгөхөөр бэлтгэл ажил хангагдаж байна.<br>Нийт ажлын явц 100%. | 100% |
| **Тэргүүлэх зорилт №3.1**. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг боловсруулж, хүн амыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх эдийн засгийн тооцооллыг бий болгож, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлнэ. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал, хандлагад төлөвшүүлж нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн тусламж үйлчилгээг эрс сайжруулах, Халдварт бус өвчнөөс сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого төлөвлөлтөд урт болон дунд хугацааны хөтөлбөр боловсруулж, чанар хүртээмжийг дээшлүүлнэ. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг хангаж, нийгмийн хамгааллыг сайжруулна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанартай уялдсан эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгоно. | | | | | | | | | |
| 13 | 3.1.10. Анхан болон лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний чанарыг эрс сайжруулж, нэгдсэн эмнэлгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төрөх, хүүхэд, гэмтэл, мэс заслын тусламж, | 10. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд агаарын яаралтай тусламжийг нэвтрүүлэх арга хэмжээ авах | 2017-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр | 3 000,0 | Эмнэлэг хүртэлх яаралтай тусламж боловсронгуй болгох | 100.0 | Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Гэмтэл согог судлалын үндэсний төвийн эзэмшил газарт нислэг тэрэгний зогсоол байгуулж, 2017 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр нээж, ашиглалтад оруулан ИНД-139 дүрмийн дагуу аэродромын түр гэрчилгээ олгосон.<br>“Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг ЗГ-ын 2018.05.02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, 2018 оны 120 дугаар тогтоолоор батлуулсан.<br>“Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн шатахуун хангамжийн сүлжээ бий болгох”-ын хүрээнд 2 чиглэлээр 3 арга хэмжээ тус тус 2018-2022 онд хэрэгжүүлэхээр тусган баталгаажуулсан. Төлөвлөгөөний дагуу бага оврын агаарын хөлөг хөөрч буух 56 зурвас барьж байгуулах, сэргээн засварлахаар 1.176 сая төгрөгийг төсөвт тусгасан, зураг төсвийн ажил хийгдэж байна. Орон нутагт шатахуун хангамжийн сүлжээ, зурвас байгуулах газрын байршлыг тогтоох ажлууд хийгдэж байна.<br>Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын Хавсралт 14-ын 2-р хэсгийг орчуулж, хелипортын стандартын төслийг боловсруулж, 2018.11.21-ний өдрийн 01/4044 тоот албан бичгээр Стандарт, хэмжил зүйн газарт хүргүүлсэн. | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээг өргөжүүлж чирэгдлийг бууруулна. | | | | | | | ЗТХ-ийн сайдын 2017 оны 69 дүгээр тушаалаар “МИАТ” ТӨХК-ийн агаарын хөлгийн засвар үйлчилгээний газрыг түшиглэн Оросын Холбооны Улсын Новосибирск хотын СИБНИА (Сибирийн нисэхийн эрдэм шинжилгээний институт) хүрээлэнтэй хамтран ТВС-2МС агаарын хөлгийг хамтран угсарч үйлдвэрлэх, мөн АНУ-ын “Gate Corporation Golax Aircraft Comp air” компаниас бага оврын агаарын хөлгийг угсрах, хамтарсан үйлдвэр байгуулахаар ирүүлсэн саналыг судлах, техник эдийн засгийн талаар тооцоо судалгаа хийж, санал боловсруулах, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. | |
| **Тэргүүлэх зорилт №3.2.2.** Шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн системийг нэвтрүүлж, мэдлэгт суурилсан инноваци, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | |
| 14 | 3.2.33. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторийн орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ. | 5.3ам, тээврийн салбарын эрдэм шинжилгээ судалгааг цөм технологи, тэргүүлэх чиглэлийн хүрээнд хөгжүүлэх | 2016-2020 | Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл | 25 000,0 | Судал-гааны ажил хийгдэх | 2017 онд 8000,0<br><br>2018 онд 8000,0 | Тэргүүлэх чиглэл, цөм технологийг нэвтрүүлэх хүрээнд ЗТХЯ-ны “Зам, тээврийн салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сангийн хөрөнгөөр 2016-2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан дараах судалгааны ажилд нийт 700 сая төгрөгийн санхүүжилт хийгээд байна. Үүнд:<br>- Зам барилгын битумын иж бүрэн судалгааг хийж, Монгол орны байгаль, цаг уурын нөхцөлд тохиромжтой битумыг дотооддоо үйлдвэрлэх технологийн судалгаа” ажлыг хэрэгжүүлэх 240 гэрээг ЗТХТ-тэй байгуулж, уг судалгааны ажлын дунд шатны тайлан хүлээн авсан.<br>- “Монгол улсын зам барилгын үйлдвэрлэлд сайжруулсан, бүлээн асфальт бетон хольцыг нэвтрүүлэх, нутагшуулах судалгаа”–ны ажлыг хэрэгжүүлэх 241-р гэрээг ЗТХТ-тэй байгуулан ажиллаж байна. Уг судалгааны ажлын тайлан хүлээн авсан.<br>- Авто замын хучилтыг цемент бетоноор барих технологийг нэвтрүүлэх, боловсронгуй болгох судалгааны ажлыг 2017 онд MCPC gr компани хийж гүйцэтгэсэн.<br>- Авто замын сүлжээний орон зайн цогц мэдээллийн санд суурилсан вэб апликейшн бий болгох, хөгжүүлэх судалгааны ажлыг MCPC gr компани хийж гүйцэтгэж, тайланг 2017 онд хүлээн авсан.<br>- Авто зам, замын байгууламжийн тооллого, бүртгэл хийж, паспорт, карт хөтлөн үндсэн хөрөнгийн бүртгэлд авах судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт” ажлыг “Ар Ди Ай Си” ХХК-тай гэрээ байгуулан салбарын мэргэжилтнүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан, эцсийн шатны тайлангаа ирүүлээд байна.<br>- Монгол Улсын авто замын салбарын бодлогын баримт бичгийг боловсруулах судалгааны ажлын зөвлөхийг шалгаруулан гэрээ байгуулан ажиллаж, уг ажлыг 2018 онд хүлээн авсан.<br>- Үндэсний тээвэр логистикийн сүлжээ байгуулах бодлогын ажлын зөвлөхийг шалгаруулан 2017 онд гэрээ байгуулан ажиллаж байна.<br>АХБ-ны “Ухаалаг тээврийн системийн үндэсний хөгжлийн төлөвлөгөө боловсруулах, боловсон хүчнийг чадавхижуулах” техникийн туслалцааны 500 мянган ам. долларын төслийг эхлүүлэв. Төслийн | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр БНСУ-ын Тээврийн хүрээлэн шалгарч 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж байна.<br>АХБ-ны санхүүжилтээр хийгдэх “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах” техникийн туслалцааны 1 сая ам. долларын төслийн Зөвлөх баг шалгарч 2017 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс ажлаа эхлүүлэн ажиллаж байна.<br>Жайка-гийн техникийн тусламжийн хүрээнд “Монгол орны байгаль цаг уурын нөхцөлд тохирсон авто замын хучилтын технологийн чадавхыг сайжруулах техникийн хамтын ажиллагааны төсөл” (2018- 2020)-ийг хэрэгжүүлэхээр уулзалтын тэмдэглэлд 2017 оны 8 дугаар сарын 23-ны өдөр гарын үсэг зурж баталгаажуулаад байна. Уг төслийн зөвлөхийг Жайка сонгож шалгаруулж, “Төслийн хэлэлцүүлгийн тэмдэглэл” (RD)-ийг бичгийг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Сангийн яаманд хүргүүлж эцэслэн батлуулсан бөгөөд ирэх оны 1 улирлаас эхлүүлэхээр болоод байна.<br>Дэлхийн банкны "Улаанбаатарын тээврийн салбарт цаг уурын нөхцөлийг даван туулах чадвартай өмчийн менежментийн төсөл“(2017-2018)-ийг хэрэгжүүлж байна.<br>БНСУ-ын Техник туслалцааны хүрээнд гүйцэтгэхээр хэрэгжүүлж буй Авто замын салбарыг 2030 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-г боловсруулж дууссан, эцсийн тайланг хүлээн авсан.<br>БСШУСЯ/ШУТС-ийн шугамаар “Авто замын дагуу зэрлэг амьтдын нүүдлийг хамгаалах арга замын судалгаа” сэдэвт төсөл (2016 -2018), “Авто замын барилгын ажлын явцад технологийн хяналтын оновчтой системийг нэвтрүүлэх судалгаа”(2017-2018 ажлуудыг эхлүүлээд байна.<br>Мөн “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн хүрээнд зам, тээврийн сүлжээг оновчтой хөгжүүлэх судалгааны төсөл хэрэгжүүлэх үндэслэл, шаардлагыг тодорхойлсон. БСШУСЯ-наас Зөвлөхийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн хүрээнд зам, тээврийн сүлжээг оновчтой хөгжүүлэх судалгааны ажлыг 2018 оноос эхлүүлсэн.<br>Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 11 дүгээр зүйлд “Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага”-тай болох асуудлыг судалж, уг судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагын чиг үүргийг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т шилжүүлэх шийдвэрийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 04 өдрийн 90 дүгээр тушаалыг гаргуулсан.<br><br>Зам, тээврийн хөгжлийн яамны захиалгаар ШУТС-аас 2018-2019 онд хэрэгжих “Нисэхийн авионикийн технологийн сургалтыг боловсронгуй болгох судалгаа”-ны ажлыг Шинжлэх ухаан технологийн тухай” хууль, “Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам”, БСШУС-ын сайдын 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/546 тоот тушаалыг | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үндэслэн ШУТИС-ийн Механик, тээврийн сургуулийн профессорын багийн ахлагч, доктор (Ph.D) Б.Эрдэнэбат удирдагчтай багтай 73,3 сая төгрөгийн гэрээ байгуулав.<br>БСШУСЯ, ШУТС-аас зохион байгуулсан инновацийн төсөл шалгаруулах уралдаанд шалгарсан “Монгол орны байгал цаг уурын нөхцөлд тохиромжтой полимер битум дотооддоо үйлдвэрлэх төсөл” нэртэй инновацийн төслийг Ч.Лхагважав удирдагчтай баг 90.0 сая төгрөгийн инновацийн гэрээ байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.<br>Шинжлэх ухаан, технологийн сангийн шугамаар 2020 оноос эхлэн хэрэгжүүлэх Шинжлэх ухаан, технологийн захиалгат зам, тээврийн салбарт хамаарах нийт 750 сая төгрөгийн 7 төслийг хэрэгжүүлэх шийдвэрийг 2019 оны 5 дугаар сард гаргуулсан. | |
| **Тэргүүлэх зорилт №3.3.** Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар, мэргэшилтэй ажилтны тоог нэмэгдүүлэх замаар хүн амын орлогыг дээшлүүлэн дундаж давхаргын хүрээг нэмэгдүүлж, иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулна. | | | | | | | | | |
| 15 | 3.3.28. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтална. | 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 1 300,0 | Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 70 хувьд хүрэх | 500.0 | Холбогдох яамдын төлөөлөл оролцсон ажлын хэсэг “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн төслийг боловсруулж, ЗГ-ын 2017 оны 321 дүгээр тогтоолоор баталсан.<br>Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам, холбогдох мэргэжлийн холбоодын төлөөлөгчидтэй хамтран Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй дэд бүтцийн талаарх үнэлгээг хийлгэж, 2017 оны 5 дугаар сарын 02-ны өдөр хүлээн авсан. Уг үнэлгээг үндэслэн УБ хотын ОУШНОБ-ын дэд бүтцийг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй болгох ажлыг шуурхай зохион байгуулах үүрэг даалгаврыг ИНЕГ, ШНБАӨЗА-д хүргүүлэв.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн үйлчилгээнд оролцох оролцоог нэмэгдүүлэх, нийгэм хамгааллын үйлчилгээг дэмжих хүрээнд “Авто замын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын 30.5 дугаар заалтад “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тээврийн хэрэгслийг авто зам, замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлөхөөр хуульчилсан.<br>- ЗТХ-ийн сайдын 2017 оны 120 дугаар тушаалаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үүрэг бүхий Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх орон тооны бус дэд зөвлөл”-ийг байгуулж, ТНБД-ын 2017 оны 334 дүгээр тушаалаар дэд зөвлөлийн 2017-2019 онд хийх ажлын төлөвлөгөөг батлан арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.<br>Тус хөтөлбөрт ЗТХЯ-ны хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан 5 арга хэмжээний биелэлт дундажаар 82 хувийн хэрэгжилттэй байна. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | 3.3.29. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үеийн найзуудтайгаа хамт суралцах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай дэд бүтцийг сайжруулна. | 1. Бүх шатны боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцахад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг сайжруулахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 20 000,0 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд энгийн сургуульд хамрагдах дэд бүтэц бий болох | 2017 онд 5 000,0<br><br>2018 онд 5 000,0<br><br>2019 онд 5 000,0 | Авто замын норм нормативын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хөтөлбөрт “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан зам, техникийн шаардлага” MNS 5682:2009, “Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009 улсын стандартуудыг шинэчлэн боловсруулах ажил тусгагдсан. Батлагдсан төлөвлөгөөний дагуу зөвлөх үйлчилгээний тендэрийг 2018.03 дугаар сард гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж “Геозураглал” ХХК-тай 2018.11.23-ны өдрийн 2018/283 тоот гэрээ байгуулан дээрх стандартуудыг 2019.05 дугаар сард багтаан батлуулахаар ажиллаж байна.<br>Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчид санаачлан Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр сургууль, харааны бэрхшээлтэй хүүхдийн 116 дугаар тусгай сургуулийн болон сонсгол хараны бэрхшээлтэй хүүхдийн тусгай цэцэрлэгийн дэд бүтцийг жишиг байдлаар тохижуулахад олон нийтийг уриалж, мөнгөн хуримтлал үүсгэхээс гадна тодорхой хугацаанд өөрсдийн чадах хэмжээнд тохижилтын ажилд оролцож, зам талбайг нь янзалж, материаллаг дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Санаачлагыг уриалан гаргасан Зам, тээврийн хөгжлийн яамны алба хаагчид 1 өдрийн цалингаа хандивлаж нийт 19 сая гаруй төгрөгийг энэхүү сайн үйлсийн ажилд зориулаад байна. Мөн Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах Тусгай элч, Дэмжигч байгууллагуудад хандаж, хэвлэлийн бага хурал хийж олон нийтийг уриалан ажилласан. | 70% |
| **Тэргүүлэх зорилт №3.4**. Монгол гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, бат бөх хариуцлагатай гэр бүлийг дэмжин, хүүхдийн эрхийг дээдэлж, залуучуудыг хөгжих, суралцах, хөдөлмөрлөх таатай орчин нөхцөлөөр хангана. | | | | | | | | | |
| 17 | 3.4.6. Бага насны хүүхдийг осол, гэмтлээс сэргийлэх, эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлж, хүүхдийн осол, эндэгдлийн түвшинг 2 дахин бууруулна. | 1. Бага насны хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх, эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлэх хөтөлбөр боловсруулах | 2017-2020 | - | - | Хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээ хийгдэх | - | ЭМЯ-ны ТНБД-ын 2016 оны А83 дугаар тушаалаар “Бага насны хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх, эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлэх хөтөлбөр боловсруулах” ажлын хэсэг байгуулан, “Осол гэмтлээс сэргийлэх" хөтөлбөрийг боловсруулж, ЗГ-ын 2018.05.30-ны өдрийн 163 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Уг хөтөлбөрт Бага насны хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх, Эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлэх зорилтуудыг тусгасан.<br>Хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээнд зам, тээврийн салбарт хэгэжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хүргүүлсэн. Хэрэгжилт 100 хувьтай. | 100% |
| 18 | | 2. "Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх" үндэсний хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх | 2017-2020 | Улсын төсөв | 1 950,0 | Хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээ хийгдэх | 650.0 | “Осол гэмтлээс сэргийлэх" хөтөлбөрийг боловсруулж, ЗГ-ын 2018.05.30-ны өдрийн 163 дугаар тогтоолоор батлуулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд 2 сургууль, 2 цэцэрлэгийн орчныг тохижуулах ажлыг ЗТХЯ-ны ажилтнуудын зүгээс саначлан “Дөрвөн бэрх хөгжлийн сан”-тай хамтран эхлүүлж, МУЗН-тэй хамтран 4 чиглэлд эмнэлгийн анхны тусламжийн цэг байгуулах ажлыг зохион байгуулаад байна.<br>Хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээнд зам, тээврийн салбарт хэгэжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хүргүүлсэн. Хэрэгжилт 100 хувьтай. | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Тэргүүлэх зорилт №4.1.** Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгалийн нөөц баялгийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, зохистой ашиглах, нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэн, байгаль орчинд нийцтэй, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс болгоно. Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | |
| 19 | 4.4.5. Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу байгальд ээлтэй зогсоол, үйлчилгээний төвүүдийг олон улсын стандартад нийцүүлэн байгуулахыг дэмжинэ. | 1. Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу зогсоол, үйлчилгээний төв, ариун цэврийн байгууламжийн ТЭЗҮ, зураг төслийг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж байгуулах | 2016-2020 | Улсын төсөв, гадаад эх үүсвэр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт | 16 800,0 | Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу түр буудаллах цогцолборыг байгуулж, жуулчдад урт хугацааны аяллын дунд түр амрах, буудаллах ая тухтай орчин, нөхцөл бүрдүүлэх | 2017 онд 800,0<br>2018 онд 4,000.0<br>2019 онд 4,000.0 | Авто замын дагуух үйлчилгээний цогцолбор. Ангилал, ерөнхий шаардлага MNS 5537:2016 стандартын төсөл боловсруулж, СҮЗ-ийн 2016.04.28-ны өдрийн 18 дугаар тогтоолоор батлуулсан.<br>БОАЖ-ын яаманд дээр хэрэгжиж буй Азийн хөгжлийн банкны буцалтгүй тусламж буюу Ядуурлыг бууруулах Японы сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл”-д бэлтгэх техник, туслалцааны төслийн хүрээнд Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор газарт аялал жуулчлалын дэд бүтэц барих судалгааны ажил хийгдэж байгаа бөгөөд тус төслийн техникийн ажлын хэсэг болон зөвлөх багийг авто зам, замын байгууламжийн дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн төлөвлөхтэй холбогдуулан шаардлагатай мэдээ, мэдээлэл, санал зөвлөмжөөр ханган ажиллаж байна.<br>ЗТХ-ийн сайд, аймгийн Засаг даргатай зам, тээврийн салбарт хамтран ажиллах гэрээнд автотээврийн салбарт шаардлагатай байгаа автобуудал, авто замын дагуух үйлчилгээний цогцолборын барилга байгууламжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барих-өмчлөх-ашиглах сонирхолтой аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж ажиллах заалтыг тусгасаж дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>1. Хөвсгөл аймгийн Мөрөн суманд автобуудлын барилгын өргөтгөл;<br>2. Хэнтий аймагт автобуудал;<br>3. Архангай аймгийн Цэцэрлэг суманд автобуудал;<br>4. Дорноговь аймгийн Сайншанд суманд автобуудал;<br>5. Төв аймгийн Лүн сумын нутаг дэвсгэрт “Урьхан-2” үйлчилгээний цогцолбор;<br>6. Баян-Чандмань сумын нутаг дэвсгэрт Аглагийн хийд рүү эргэдэг уулзварын үйлчилгээний цогцолборыг тус тус барьсан.<br>7. Увс аймгийн Улаангом сумын Цагаан дэглий нисэх буудлын барилгыг автобуудал болгон өөрчлөн тохижуулсан.<br>8. Сэлэнгэ аймагт дахь “УБТЗ” ХНН-ийн автобуудлаас улс, хот хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг гүйцэтгэх шийдвэр гаргуулж, үйл ажиллагаа эхлүүлсэн.<br>9. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын төвд Худалдааны төвийн барилгыг автобуудал, техникийн хяналтын үзлэгийн төвийн зориулалтаар ашиглах асуудлаар ЗГ, УИХ-аар шийдвэр гаргуулсан.<br>10. Улаанбаатар хот, Ховд, Завхан, Дорнод зэрэг аймгуудад шаардлагатай автобуудал, авто замын дагуух үйлчилгээний цогцолборын барилга байгууламжийг орон нутгийн концессын зүйлийн жагсаалтад оруулж, сонирхогч ААНБ барих-өмчлөх-ашиглах төрлөөр хэрэгжүүлэхээр аймаг, нийслэлийн ИТХТ-ийн шийдвэр гаргуулсан.<br>11. Төв аймагт улсын төсвийн хөрөнгөөр автобуудлын барилга угсралтын ажил 80 %-тай, | 100% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 12. Завхан, Баян-Өлгий аймагт “АТҮТ” ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар автобуудлын барилга байгууламжийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.<br>13. Баянхонгор аймгийн Баянхонгор суманд “Номгон оюу” ХХК, Булган аймгийн Рашаант сумын нутаг дэвсгэр “Элсэн тасархай”-т “Сод хан трэвел” ХХК авто замын дагуух үйлчилгээний барилга байгууламжийн барих ажлаа эхлүүлсэн. | |
| **Тэргүүлэх зорилт №5.6.** Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого хэрэгжүүлж, гадаад бодлогын нэгдмэл байдал, залгамж чанарыг хадгалж, дэлхийн улсуудтай найрсаг харилцаа, улс төр, худалдаа, эдийн засаг, соёлын болон бусад салбарын хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улсын хамтын нийгэмлэгт байр суурийа бэхжүүлж, бүс нутгийн хамтын ажиллагаанд оновчтой оролцож, хилийн чанадад Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн эрх ашгийг тууштай хамгаалж, иргэд гадаадад зорчих нөхцөлийг улам сайжруулж, эх орноо гадаадад сурталчилан таниулах ажлыг эрчимжүүлнэ. | | | | | | | | | |
| 20 | 5.6.1. Монгол Улс, ОХУ-ын стратегийн түншлэл болон Монгол Улс, БНХАУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлж, худалдаа, эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, хоёр хөршийн далайн боомтыг ашиглах, тэдгээрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөлийг бүрдүүлнэ.<br>4. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хоорондын Транзит тээврийн ерөнхий хэлэлцээрийг байгуулах. | | 2016-2020 | Улсын төсөв | 800,0 | Хэлэлцээрийг байгуулах | 250.0 | “Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн төслийн жагсаалт”-ын 12 дугаарт тусгагдсан “Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэрлэлт гүйцэтгэх тухай ОХУ, МУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулж, УИХ-ын 2018.04.12-ны өдрийн хуралдаанаар соёрхон баталсан. “Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэрлэлт гүйцэтгэх тухай" Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд “Хөгжлийн зам-Тээвэр, логистикийн хамтын ажиллагаа” сэдэвт олон улсын бага хурлыг УБ хотноо 2017.10.19-20-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>Улаанбаатар хотноо 2018 оны 06 дугаар сард Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайд, ОХУ-ын Тээврийн сайд нар “Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т үсэг зурсан. Хэлэлцээр байгуулснаар манай улсын экспортын бараа, бүтээгдэхүүн ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжуулан гуравдагч зах зээлд гаргахад төмөр замын тарифын хөнгөлөлт 25 жилийн турш эдэлнэ. | 100% |
| **Нийт** | | | | | | | | | **82.3** |